

Варшав хот, 2020 оны 3 дугаар сарын 3

Санал дүгнэлтийн дугаар:
JUD-MNG/352/2020 [AIC]

<http://www.legislationline.org/>



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ, ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИНД ӨГӨХ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус Санал дүгнэлтийг ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газрын захиалгаар хийсэн дээрх хуулийн Англи хэл дээрх албан бус орчуулга дээр үндэслэн гаргав.

Санал дүгнэлтийг дараах экспертүүдийн тайлбар дээр үндэслэв: Др. Гжегош Борковски (Шүүгч, Олон улсын эрх зүйн шинжээч, Польшийн Шүүхийн Үндэсний Зөвлөлийн дарга асан), Надежда Хриптиевски (Олон улсын эрх зүй болон хүний эрхийн асуудлаарх шинжээч), Проф. Андраш Саёо (Будапешт дах Төв Европын Их сургуулийн профессор, шүүгч асан, Европын Хүний Эрхийн Шүүхийн Дэд ерөнхийлөгч).

Энэхүү санал дүгнэлт нь зөвхөн ЕАБХАБ/АИХЭГ-ын байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд шинжээч нарын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

ЕАБХАБ-ын Ардчилсан Институц, Хүний Эрхийн Газар
Ulica Miodowa 10 PL-00-251 Warsaw Утас: +48 22 520 06 00 Факс: +48 22 520 0605

Энэхүү Санал дүгнэлтийн Монгол хэл дээрх хувилбар байгаа хэдий ч Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны бичиг баримтад тооцогдоно.

ГАРЧИГ

I.	ТАНИЛЦУУЛГА.....	3
II.	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ЦАР ХҮРЭЭ.....	3
III.	ТОВЧ ХУРААНГУЙ БА ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ	4
IV.	ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ ҮҮД.....	10
1.	Олон улсын холбогдох хэм хэмжээ болон ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага	10
2.	Шүүхийн хууль эрх зүйн орчин	13
3.	Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт.....	13
	3.1. Шүүхийн тогтолцоо.....	15
	3.2. Хууль тогтоомж боловсруулах явц дах шүүхийн оролцоо.....	17
	3.3. Шүүхийн төсөв.....	18
	3.4. Бусад тайлбар.....	22
4.	Шүүхийн захиргаа ба бие даасан байдал	23
	4.1. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үүрэг	23
	4.2. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийг нэр дэвшүүлэх/ сонгох болон хугацаанаас нь өмнө чөлөөлөх журам.....	28
	4.3. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг шүүхэд хянан шийдвэрлүүлэх...	36
	4.4. Шүүхийн захиргааны бусад байгууллагууд.....	38
	4.5. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн төсөв ба Ажлын Алба	44
5.	Шүүгчийн эрх зүйн байдал.....	45
	5.1. Шүүгчийн бие даасан, хараат бус байдал.....	45
	5.2. Шүүгчийн эрх	46
	5.3. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, халдашгүй байдлын баталгаа	53
	5.4. Сонгон шалгаруулалт ба томилгоо	57
	5.5. Шүүгчийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх.....	68
	5.6. Шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлага.....	70
	5.7. Шүүгчийн сургалт	81
6.	Шүүхийн ерөнхий шүүгчид болон Улсын Дээд Шүүхийн танхимын тэргүүн нар.....	82
	6.1. Шүүхийн Ерөнхий шүүгчдийн томилгоо	82
	6.2. Улсын Дээд Шүүхийн Ерөнхий Шүүгчийн томилгоо	84
	6.3. Ерөнхий шүүгч болон Улсын Дээд Шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх	84
7.	Шүүхийн захиргааны ажилтнууд	87
8.	Нэмэлт тайлбар	89
	8.1. Хэрэг хуваарилах журам	89
	8.2. Шүүхийн шийдвэрийн үндэслэл	90
	8.3. Маргаанд оролцогч талуудын хувийн нууцыг хангах	91
9.	Монгол Улсад шүүх эрх мэдлийн хүрэн дэх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн хуульчилахад анхаарах асуудлууд болон зөвлөмжүүд	91
	Хавсралт: Монгол Улсын Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд	

I. ТАНИЛЦУУЛГА

1. 2019 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр Монгол Улсын Шүүхийн Ерөнхийн Зөвлөлийн даргаас Монгол Улсын шүүх эрх мэдлийн тухай хуулийн багцад дүн шинжилгээ гаргуулах хүсэлтийг ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газарт (цаашид АИХЭГ) ирүүлсэн болно. Улмаар АИХЭГ нь ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг хариуцлага, олон улсын хүний эрх, хуулийн засаглалын хэм хэмжээнд эдгээр хууль тогтоомжийн нийцлийг үнэлж, санал зөвлөмж боловсруулж өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлсэн.
2. Улмаар АИХЭГ нь эдгээр хуулинд хоёр тусад нь санал дүгнэлт хийх шийдвэр гаргасан. Эхний санал дүгнэлтийг Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай (цаашид Хуулиуд) хууль тогтоомж дээр төвлөрөн хийж, удаахыг нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай болон Эвлүүрүүлэн зуучлалын тухай хууль дээр төвлүүрэн хийв. Эдгээрийг хамтад уншиж, танилцах нь зүйтэй болно.¹
3. Энэхүү Санал дүгнэлт, зөвлөмжийг дээр дурдсан хүсэлтийг үндэслэн боловсруулсан болно. АИХЭГ нь ЕАБХАБ-ын гүшүүн орнуудад ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилго, удирдамжийн хүрээнд энэхүү саналыг боловсруулсан юм.²

II. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ЦАР ХҮРЭЭ

4. Энэхүү санал дүгнэлтийн цар хүрээ нь зөвхөн дүн шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн хуулийн багцын тайлбарыг тусгасан болно. Эдгээр хязгаарлалтын улмаас санал дүгнэлт нь Монгол Улс дах шүүх эрх мэдлийн байгууллагын эрхзүйн зохицуулалтын болон институцийн хүрээнд бүрэн, дэлгэрэнгүй тойм гаргаагүй болно. Энэхүү санал дүгнэлтийг АИХЭГ-ын Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай болон Эвлүүрүүлэн зуучлалын тухай хуульд хийсэн санал дүгнэлт, зөвлөмжүүдийн хамт уншиж, танилцах нь зохимжтой.
5. Энэхүү санал дүгнэлтийн зөвлөмжүүд нь гол асуудлыг хөндөж, цаашид анхааран засч залруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон болно. Оновчтой бөгөөд тодорхой байх үүднээс бид дээрх хууль тогтоомжийн эерэг тал дээр биш харин өөрчлөлт, залруулга шаардсан заалтууд дээр төвлөрүүлсэн болно. Санал зөвлөмжийг

¹ Монгол Улсын хууль тогтоомж болон хуулийн төсөлд хийгдсэн санал дүгнэлтүүдийг: <https://www.legislationonline.org/odhr-documents/page/legal-reviews/country/60/Mongolia/show> цахим хуудаст байршуулсан болно.

² ЕАБХАБ-ын орон зайнд хуулийн засаглалыг бэхжүүлэх тухай Сайд нарын Зөвлөлийн 07/08 дугаар шийдвэрийн (2008) 4 дэх зүйлд “ЕАБХАБ-ын гишүүн улсууд нь, шаардлагатай тохиолдолд ЕАБХАБ-ын Тамгын газар түүний нэгжүүд өөрийн мандат болон нөөц бололцооны хүрээнд дэмжлэг үзүүлж, хуулийн засаглалыг бэхжүүлэх /үүний дотор/ шүүхийн бие даасан, хараат бус байдал, шүүхийн захиргаа, шударгаар шүүлгэх эрх болон шүүхэд хандах эрх, төрийн байгууллага болон төрийн албан хаагчид хариуцлага тооцох, төрийн удирдлагад хууль дээдлэх зарчмыг хүндэтгэх, хууль эрх зүйн туслалцаа авах эрх, засан хүмүүжишч нарын хүний эрхийг хамгаалах зэрэг чиглэлээр харилцан сайн туршлага, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаагаа өргжүүлэн ажиллах нь зүйтэй /.../” гэжээ.

ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг, хариуцлага, бусад олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээ болон олон улсын сайн туршлага дээр тулгуурлан гаргасан болно. Мөн энэхүү Саналд ЕАБХАБ-ын гишүүн орнуудын энэ салбар дах сайн туршлагаас тусгасан болно.

6. Түүнчлэн, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц (цаашид “CEDAW”),³ ЕАБХАБ-ын Жендерийн тэгш байдлыг дэмжих чиглэлээрх 2004 оны үйл ажиллагааны төлөвлөгөө,⁴ ЕАБХАБ-ын үйл ажиллагаа, хөтөлбөр, төсөлд жендерийн хэтийн төлөвийг бий болгох үүрэг амлалтын хүрээнд, энэхүү дүн шинжилгээ хамарсан хуулийн тайлбарт эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөллийн боломжит ялгааг мөн шинжилсэн болно.
7. Энэхүү Санал нь АИХЭГ-ын захиалгаар хийсэн дээр дурдагдсан хуулиудын албан бус орчуулга дээр үндэслэн хийгдсэн болно. Хуулийн орчуулгыг энэхүү баримт бичигт хавсаргасан болно. Оновчтой бус орчуулгаас үүдэн зөрүүтэй, алдаатай зүйл гарч болзошгүй. Тус Санал дүгнэлтийн Монгол хэл дээрх хувилбар байгаа хэдий ч Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны бичиг баримтад тооцогдоно.
8. Дээрх шалтгааны улмаас АИХЭГ-ын зүгээс нэмэлтээр аман болон бичгэн санал зөвлөмж гаргах мөн цаашид Монгол Улсын шүүхийн эрх мэдлийн байгууллалгын тухай хууль тогтоомжид санал дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагаанд энэхүү Санал хязгаарлахгүй гэдгийг онцолж байна.

III. ТОВЧ ХУРААНГУЙ БА ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ

9. Шүүх эрх мэдлийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалтын болон институцийн хүрээнд хийсэн шинэчлэлийг үл харгалзан, Монгол Улсын шүүх байгууллагад авлигын асуудал, улс төр/гүйцэтгэх эрх мэдлийн хөндлөгийн нөлөөлөл зэргээс улбаалан шүүхийн хараат бус байдал эмзэг, шүүхийн байгууллагад олон нийтийн итгэх итгэл бага зэргийг олон улсын нийгэмлэг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг байдлыг АИХЭГ мөн тэмдэглэж байна.⁵ Ялангуяа саяхан буюу 2019 оны 3 дугаар сард шүүхийн хууль тогтоомжинд хийсэн нэмэлт өөрчлөлтийн улмаас эдгээр нь илүү их анхаарал татаж

³ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц (цаашид “CEDAW”) Ерөнхий Ассамблейн 34/180 тогтоолоор 1979 оны 12-р сарын 18-нд баталсан. Монгол Улс 1981 оны 7 дугаар сарын 20-нд соёрхон батласан.

⁴ МС.DEC/14/04 (2004) шийдвэрээр баталсан ЕАБХАБ-ын Жендерийн тэгш байдлыг дэмжих чиглэлээрх 2004 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 32-р догол мөрийг үзнэ үү.

⁵ Европын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЕЭЗХАХБ)-ын Монгол Улс дахь Авлигын эсрэг шинэтгэл-Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шатны үнэлгээний тайлан, зөвлөмжүүдийн 10 болон 60-62-р хуудас (2019), НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч болон Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын Тусгай илтгэгч нарын Хамтарсан тайлан, зөвлөмжүүд (2019 оны 5-р сарын 14), НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн (CCPR) Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай зургаа дахь тайлангийн талаарх дүгнэлтийн 31-32-р хуудас (2017 оны 8-р сарын 22), НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо (ЭЗНСЭХ)-ны Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын дөрөв дэх тайлангийн талаарх дүгнэлтийн 11 дүгээр зүйл (2015 оны 7-р сарын 7), болон НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн Монгол улсад ажилласан талаарх эцсийн тайлан (2019 оны 4-р сарын 30-наас 5-р сарын 13).

байна⁶. Үүний сацуу шүүх эрх мэдлийн байгууллагын санхүүжилтийн хангалтгүй байдал, шүүгчийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх болон хувийн карьер зэрэг асуудал дээрх тулгамддаг улс төрийн болон бусад хөндлөнгийн нөлөөлөл зэрэг нь Монгол Улсын шүүхийн бие даасан, хараат бус байдлын баталгаанд сөрөг нөлөөлөл үзүүлж буйг өргөн мэдээлж байна.⁷ Шүүхийн эрх мэдлийн байгууллага нь бие даасан, хараат бус, ил тод, мэргэшсэн байх явдал нь шударга хуулийн засаглалыг тогтоох болон шүүхийн байгууллагад олон нийтийн итгэх итгэлийг бий болгоход ач холбогдолтой болохыг тэмдэглэхийн сацуу Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагад тулгамдаж буй эдгээр асуудлыг эрх баригчид анхаарч, зайлшгүй шийдвэрлэх нь зүйтэй болно. Иймд АИХЭГ нь шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр шүүх эрх мэдлийн хүрээний эрхзүйн зохицуулалтыг шинэчлэхээр дүн шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах гэсэн төрийн байгууллагуудын эрмэлзэл, хүчин чармайлтыг сайшааж байгаа болно.

10. Өөрийн улсын шүүхийн тогтолцоог шинэчлэх аливаа улс орны эрхийг хүндлэн, хүлээн зөвшөөрөхийн сацуу ийнхүү шинэчлэх явцыг шүүхийн бие даасан, хараат бус байдлыг сулруулахгүй, олон улсын хууль, хүний эрхийн хэм хэмжээ болон ЕАБХАБ-ын үүрэг хариуцлагын хэм хэмжээнд нийцүүлэн хийх нь чухал болохыг тэмдэглэж байна. Ялангуяа хэтийн төлөвтэй өргөн хүрээг хамарсан шинэчлэл эхлүүлж санаачлахад дээрхийг анхаарах нь зүйтэйгээс гадна аливаа хууль эрх зүйн шинэчлэлийг ардчилсан хууль тогтоох үндсэн зарчимд нийцүүлж хийх нь чухал болно.
11. Ерөнхийдөө одоо мөрдөж байгаа хуулиуд нь шүүхийн бие даасан, хараат бус байдалд аюул заналхийлэл учруулахуйц маш олон орхигдуулсан зүйлтэй болон дутагдалтай байгаа бөгөөд шүүхийн эрх мэдлийн байгууллагын эрх зүйн тогтолцоонд иж бүрэн, системтэй шинэчлэл хийх үндэслэл буйг харуулж байна. Дээрх багц хуультай холбоотой гарч буй үндсэн нэг асуудал нь шүүхийн эрх мэдэлтэй холбоотой гол шийдвэрүүд, ялангуяа шүүгчдийг томилох, мөн шүүхийн бүтэц, үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглалын эрх мэдэл, нөлөөлөлийн цар хүрээ өргөн байгаа явдал мөн болно. Энэ нь эрх мэдлийн хуваарилалт, шүүхийн бие даасан байдлыг алдагдуулж, сөргөөр нөлөөлөх болзошгүй тул шүүхийн захиргааны үйл ажиллагаанд гүйцэтгэх засаглалын оролцоог тусгасан бүх зүйл заалтыг хуулиас хасаж, хүчингүй болгохыг энэхүү дүгнэлтээр зөвлөж байна. Өөр нэг тулгамдаж буй асуудал нь шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой бөгөөд мэргэшсэн, туршлагатай нэр дэвшигчдийг томилох баталгааг хангах, шударга, нээлттэй, ил тод, мерит зарчим дээр тулгуурласан сонгон шалгаруулалтыг явуулах аргачлал дутагдаж байгаа явдал болно. Үүний сацуу сахилгын хэрэгт холбогдсон шүүгчдэд зохих баталгааг өгөх, тэдний эрхийг хангах нь

⁶ НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч болон Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын Тусгай илтгэгч нарын Хамтарсан тайлан, зөвлөмжүүд (2019 оны 5-р сарын 14).

⁷ ЕЭЗХАХБ-ын Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл-Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шатны үнэлгээний тайлан, зөвлөмжүүдийн 10, 53 болон 60-62-р хуудас (2019), НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн мэдэгдэл болон НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай 2017 оны тайлангийн талаарх дүгнэлтийн 32-р зүйлийг тус тус харна уу.

чухал тул шүүгчийн ёс зүйн дүрэм болон сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг нарийвчилж, тодруулан найруулах шаардлагатай байна. Мөн зарим заалтууд нь шүүгчдийн хараат бус байдалд, ялангуяа ерөнхий шүүгчдэд ба дээд шүүхэд онцгой эрх олгосон эрх мэдлийг алдагдуулж болзошгүй байна. Эцэст нь хууль боловсруулагчид шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр, ялангуяа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний болон угсаатны цөөнхөд шударга ёсыг эрх тэгш хүртээх чиглэлээр анхаарах нь зүйтэй. Энэхүү дүн шинжилгээний зарим зөвлөмж нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл оруулахыг зөвлөсөн утга агуулана.

12. Тодруулбал, олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, хууль дээдлэх зарчим, шилдэг туршлагыг харгалзан үзэж, АИХЭГ нь Монгол Улсын шүүх засаглалын талаарх хууль эрх зүйн орчныг цаашид сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг өгч байна.

А. Монгол Улсын шүүх засаглалтай холбоотой өргөн хүрээний асуудлаарх гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын эрх мэдлийг эргэн хянаж үзэх:

- Шүүхийн захиргааны байгууллагын удирдлага, үүний дотор Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилоход хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг санал болгох тухай заалт (Шүүхийн захиргааны тухай хуулийн 13.1-р зүйл), Ёс зүйн Хорооны бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батлах тухай заалт (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.4-р зүйл), болон шүүх засаглалтай холбоотой бусад өргөн хүрээний асуудлаарх Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй холбоотой зүйл заалтуудыг тус тус хүчингүй болгох. [84 болон 137-р догол мөр]
- Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдийн болон даргыг томилох ажиллагаан дах Ерөнхийлөгчийн үүрэг оролцоог хасах, эсвэл ийнхүү үүрэг оролцоог ёслолын буюу бэлэгдлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах, эсвэл хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг оролцоо зэргээр солих, харин шүүгчийг томилохоос татгалзсан шийдвэрийн тухай үндэслэл тайлбараа бичгээр ирүүлэх үүрэг хүлээлгэх. [59-60-р догол мөр]
- Шүүхийн Мэргэшлийн Хорооны дүрэм (Шүүхийн захиргааны тухай хуулийн 23.8-р зүйл болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1-р зүйл) болон Шүүхийн Ёс зүйн хорооны дүрэм (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.4 – р зүйл) цаашилбал ёс зүйн хариуцлагын арга хэмжээ авах үүрэг бүхий тусгайлан байгуулсан хорооны дүрмийг тус тус батлах Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлах. Харин ийнхүү дүрмийг холбогдох хороод эсвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөл боловсруулж байх нь зохимжтой болно. [76, 84, 138-р догол мөр]
- Шүүхийн шүүгчдийг томилох, чөлөөлөх Ерөнхийлөгчийн үүрэг оролцоог хасах, эсвэл түүний эл эрхийг ёслолын буюу бэлэгдлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах буюу Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн (эсвэл Ёс зүйн хорооны) гаргасан саналыг хүлээн авах үүрэг хүлээлгэх, үгүй бол Ерөнхийлөгчийн эрх, үүрэг оролцоог хязгаарлаж өгөх (жишээ нь нэр

дэвшигчийг томилох эсвэл томилохоос татгалзах шийдвэр гаргах эрх зүйн үндэслэлийг тогтоож өгөх, энэ нь зөвхөн процедурын үүрэг байх). [121, 156-р догол мөр]

- Улсын Дээд Шүүхийн шүүгчдийг томилох процедураас УИХ-ын оролцоог хасах, эсвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгчийг сонгон шалгаруулах/нэр дэвшүүлэх журамд хяналт тавих үүрэг олгох зэргээр УИХ-ын оролцоог хязгаарлах. [128-р догол мөр]
- Ерөнхий шүүгчид болон Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох ажиллагаан дах Ерөнхийлөгчийн үүргийг эргэн харах, эсвэл дээрх зөвлөмжийн дагуу бусад шүүгчийг томилохтой ижил дүрэм журмыг боловсруулж, мөрдүүлэх, эсвэл тухай шүүхийн шүүгчид нь хуралдаж Ерөнхий шүүгчээ сонгож байх. [164, 167-р догол мөр]

В. Шүүх засаглалын төсвийг бууруулахыг хориглосон заалтыг дахин оруулах, эсвэл төсвийг үндэслэлгүй танахаас хамгаалах бусад хуулийн заалтыг шинэчлэн найруулах [33-р зүйл], мөн шүүгчийн цалинг бодитоор бууруулахаас зайлсхийх баталгаа, шалгуурыг хууль тогтоомжид тусгаж өгөх [36-р догол мөр], төсөвт эдгээр зардлуудыг нарийвчлан тусгаж оруулах. [32-р догол мөр]

С. Шүүхийн Ёс зүйн хорооны эрх мэдлийг шинэчлэн боловсруулж, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эрх, үүргийг нь хасаж, улмаар эрх үүргийг нь шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад ёс суртахууны хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний талаар зөвлөгөө өгөх зэрэг үүргээр хязгаарлах [82-83-р догол мөр], үүний сацуу Хуульчдын холбооны төлөөлөл болон эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөлөөс сонгосон шүүгч нараас бүрдсэн сахилгын бие даасан байгууллага байгуулах [137-р догол мөр], улмаар сахилгын хариуцлага хүлээлгэх механизмыг дараах байдлаар бэхжүүлэх:

- Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх тухай зүйл заалтуудыг хуулиудаас хасах (ялангуяа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1, 32.2, 33.1 болон 37.1-р зүйлүүд) [147-148-р догол мөр]
- Шүүгчийг огцруулах/чөлөөлөгдөхөд хүргэх сахилгын хариуцлагын үндэслэл, сахилгын хариуцлагын шийтгэл ногдуулах журам ба сахилгын шийтгэлийн хэлбэр болон сахилгын бусад хариуцлагын шийтгэлийн хэлбэр хоорондын ялгааг тодорхой болгох; [143-р догол мөр]
- Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаан дах Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн оролцооны тухай зүйл заалтыг хүчингүй болгох (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17.18-р зүйл), [149-р догол мөр]
- Шүүгчийн талаар гомдол хүлээн авсан хүн, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, шийдвэр гаргасан хүмүүс нь сахилгын хэрэг шалгах, шийдвэрлэх байгууллагын эцсийн шийдвэрт оролцохгүй байхыг баталгаажуулах; [150-р догол мөр]

- Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах үүднээс сахилгын хариуцлагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд процедурын шударга ёсны үндсэн хэм хэмжээг хангах, үүнд гомдлын болон сахилгын хариуцлагын мөн чанар, гомдлын нотлох баримтын талаар нарийвчилсан мэдээлэл авах эрхээр нь хангаж, хараат бус шударга шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх, хууль ёсны төлөөлөл авах, сахилгын шийдвэрийг давж заалдах зэрэг шүүгчдийн эрхийг нь баталгаажуулах [152-155-р догол мөр]
 - Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-р зүйлд заасан сахилгын арга хэмжээний төрлүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж, сахилгын шийтгэл нь гаргасан зөрчлийн шинжид тохирсон байх ёстой гэдгийг тодорхой тусгах; [157-158-р догол мөр]
 - Сахилгын шийтгэлийн тухай гаргасан шийдвэрийг шүүхэд давж заалдах боломжийг олгох, эцсийн давж заалдах шат хүртэл болон давж заалдах шатны байгууллагын эцсийн шийдвэр гарах хүртэл оноосон сахилгын шийтгэлийг түдгэлзүүлэх [159-р догол мөр]
- D. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг цуцлах үндэслэл, журмыг илүү нарийвчлалтай болгож, тодорхойлох, ингэхдээ хэт их, ойлгомжгүй үг хэллэгээс зайлсхийж, Зөвлөлийн гишүүдтэй холбоотой ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд шударга ёсны хэм хэмжээ, ил тод байдлын баталгааг нь хангах [63-65-р догол мөр]
- E. Шүүхийн захиргааны тухай хуульд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шийдвэр гаргах ажиллагааг хянан шийдвэрлэх нөхцөл, журам, хамрах хүрээг тодорхой тусгах эсвэл тэдгээр нь өөр хуулиар зохицуулагдсан бол дээр дурдсан хуульд хавсаргасан лавлагаа оруулах ба ингэснээр Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс гарах шийдвэр нь үндэслэл бүхий шийдвэр байх баталгааг хангах [68-69-р догол мөр]
- F. Шүүгчдийг сонгон шалгаруулах, томилох журмыг илүү нээлттэй, ил тод, шударга, үр дүнтэй болгохын тулд нэмэлт өөрчлөлт оруулах. Үүний дотор:
- Шүүхийн Мэргэшлийн Хорооны бүрэлдэхүүний бүтцийг эргэн хянан үзэж, тус хорооны гишүүдийн доод тал нь тал хувь нь шүүгч нарын бүрэлдэхүүнээс томилсон шүүгч нар байхыг баталгаажуулах; [75, 137-р догол мөр]
 - Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчийн албан тушаалд томилох хүний нэрийг санал хурааж сонгодог заалтыг хүчингүй болгох (Шүүхийн захиргааны тухай хуулийн 13.2-р зүйл) [126-р догол мөр]
 - Шүүгчийг сонгон шалгаруулах хуульд заасан болзол, шаардлагыг хангасан эсэх талаар Шүүхийн Мэргэшлийн Хорооны гаргасан үнэлгээ нь шаардлагад нийцэж буй эсэхийг шалгах, мөн нэр дэвшигчийг сонгох явц дах Ерөнхий Зөвлөлийн үүргийг хязгаарлах асуудлыг авч үзэх, Хорооны гаргасан үнэлгээ нь хуульд заасан болзол, шаардлагыг зөрчсөн талаар тодорхой, зохих баримтжуулсан бичиг баримтын үндэслэл байхгүй бол гаргасан үнэлгээг дагаж

мөрдөх. Эс бөгөөс Шүүгчийн Мэргэшлийн Хорооны гаргасан үнэлгээ, дүгнэлтийг Хуульчдын Холбоо болон Шүүхийн Ерөнхий Зөвлөл хянан магадлаж байх; [125-р догол мөр]

- Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчийн албан тушаалд сонгогдсон нэр дэвшигч нь хуульд заасан шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хангасан тухай болон сонгон шалгаруулсан бусад үндэслэлийн талаар тодорхой тайлбар өгч байх; [127-р догол мөр]
- Шүүгчид нэр дэвшүүлэхгүй байх талаар гаргасан Зөвлөлийн шийдвэрийг давж заалдах эрхийг холбогдох хууль, журмын хүрээнд нэр дэвшигчдэд олгох; [127-р догол мөр]
- Сонгон шалгаруулалт, томилолтын явцыг илүү нээлттэй, ил тод байлгах бусад аргуудыг авч үзэх; [129-131-р догол мөр]

Г. Шүүгчийн албан ажил мэргэжлийн хараат бус байдлын зарчмыг шүүх эрх мэдлийн эрх зүйн хүрээнд хуульчлан тусгах. [89-р догол мөр]

Н. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.2 дахь зүйлд заасан "улс төрийн асуудлаар байр сууриа илэрхийлэх" гэсэн ерөнхий агуулгыг хасаж, шүүгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй энэхүү зүйл заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд нийцэж байгаа эсэхийг эргэн харж, хууль эрх зүйн тодорхой байдал, зайлшгүй байдал, пропорциональ зарчимд нийцэж байгаа эсэхийг нарийвчлан тодорхойлж, дээрх заалтад тодорхой агуулга оруулах нь зүйтэй. Ингэхдээ шүүгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үүргээ гүйцэтгэхдээ бие даасан, шударга байх зарчмын шаардлага хоёрын хооронд зохистой тэнцвэрт байдлыг хангах. Ялангуяа хууль дээдлэх зарчим, шударга ёсны тогтолцооны үйл ажиллагаа, шүүхийн шинэчлэл, эсвэл эрх мэдэл хуваах, шүүхийн хараат бус байдал, дүрэм журамтай холбоотой асуудлаар цаг үеийн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцож мэдээлэл хийх үед шүүгчийн эрхийг хамгаалах буюу хуулийн зүйл заалт хамаарахгүй байх нөхцөлийг хангаж өгөх нь зүйтэй. [97-р догол мөр].

И. Шүүхийн тухай хуулийн 5.4-р зүйлд заасан найруулгыг өөрчлөх эсвэл хүчингүй болгож, улмаар шүүх байгууллагуудын шийдвэр гаргалт нь Улсын Дээд Шүүхийн хараат байдалд байх агуулга, үг хэллэгийг засаж найруулах. Түүнчлэн дээд шүүх нь кассаци буюу дээд шатны шүүхийн хувьд хяналт тавих байгууллага гэж тодотгож өгөх нь зүйтэй ; [25-26-р догол мөр]

Ж. Шүүх хуралдааны даргыг томилох, шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох тухай шийдвэрийг батлах Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг хүчингүй болгох. [170-р догол мөр], Түүнчлэн доод шатны шүүх буюу танхимын харьяаллын талаарх маргааныг хянан шийдвэрлэх Ерөнхий шүүгчийн эрхийг хүчингүй болгох (Дээд шүүхийн хувьд) [173-р догол мөр]. Үүний сацуу Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн дээд шүүхийн аль ч танхимын шүүх хуралдаанд оролцох бүрэн эрхийг

болон Ерөнхий шүүгчийн холбогдох шатны шүүхийн шүүх хуралдаанд оролцох эрхийг тус тус эргэн хянаж үзэх; [172-р догол мөр]

К. Шүүхийн тухай хууль болон холбогдох бусад холбогдох хууль тогтоомжинд хэрэг хуваарилалтыг автоматаар санамсаргүй хуваарилах нөхцөл болон зарчмыг тогтоож оруулах, эсвэл бүх шүүхэд хэрэглэж болхуйц хэрэг хуваарилах тодорхой, объектив шалгуур үзүүлэлт дээр сууриалсан дүрэм журмыг боловсруулан баталж холбогдох хууль тогтоомжинд нэмж оруулах; [180-р догол мөр]

Л. Шүүгчийн хараат бус байдалд халдахгүй байх нөхцөлийг бүрэн хангасан шүүгчийн ажлын үр дүнг үнэлэх механизмыг боловсруулж, дахин оруулах талаар эргэн судлах. [132-134-р догол мөр]

М. Бүх шатны шүүхийн системд түүний дотор дээд шатны шүүхүүдэд жендэрийн буюу цөөнхийн төлөөлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зүйл заалтуудыг хууль тогтоомжинд оруулах. Үүнд:

- Бүх шатны шүүх, тэр дундаа дээд шатны шүүхийн түвшинд жендэрийн тэгш байдал, цөөнхийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санаачилга, бодлого боловсруулж хэрэгжүүлэхийг Шүүхийн Ерөнхий Зөвлөлд даалгах; [47-р догол мөр]
- Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнд жендэрийн тэнцвэрт байдал, цөөнхийн төлөөлөлийг хангах механизмыг нэвтрүүлэх; [56-р догол мөр] ба
- Шүүгчид болон ерөнхий шүүгчдийг (холбогдох шүүхэд шүүгчид нэр дэвшигчдийг тодорхойлох, эрэмбэлэх, сонгон шалгаруулах явцад) томилохдоо эмэгтэй, эрэгтэй болон цөөнхийн төлөөллийг харгалзан үзэж, дэмжихэд чиглэсэн механизмыг нэвтрүүлэх. [116-118-р догол мөр]

Нэмэлт зөвлөмжүүдийг энэхүү санал дүгнэлтэд хар өнгөөр тодруулж оруулсан болно.

IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ ҮҮД

1. Олон улсын холбогдох хэм хэмжээ болон ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага

13. Шүүхийн хараат бус байдал нь хууль дээдлэх засаглалд суурилсан аливаа ардчилсан улсын суурь зарчим бөгөөд салшгүй нэг хэсэг юм.⁸ Шүүхийн хараат бус байх зарчим

⁸ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2015 оны 6-р сарын 30-ны өдрийн [Шүүхийн бие даасан байдал, шүүгчдийн, хулийн зөвлөх болон хуульчдын хараат бус байдлын тухай тогтоол](#), А/HRC/29/L.11 нь “НҮБ-ын Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчмууд болон хүний эрхийн бусад хэм хэмжээ, зарчим, стандартын мөрдөж, шүүхийн бие даасан байдал болон хулийн засаглалын зарчмын амин сүнс болох шүүхийн хариуцлагатай, нээлттэй болон шударга ажиллагааг баталгаажуулах”-ыг онцлон тэмдэглэсэн. [ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены](#) баримт бичигт “хуулийн засаглал гэдэг нь ардчилсан дэг журмыг тогтоох, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хууль сахиулах ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж гэсэн үг биш, харин хувь хүний эрх чөлөө, үнэт зүйлсийг хүлээн

нь хүний эрхийн бусад олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөхөд чухал ач холбогдолтой юм.⁹ Энэхүү хараат бус байдал нь шүүх засаглал нь институцийн хувьд болон бие даасан шүүгчид нь гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллага болон бусад гадны эх үүсвэрийн нөлөөлөлгүйгээр мэргэжлийн үүргээ гүйцэтгэх боломжоор хангагдсан байх ёстой гэсэн үг юм. Шүүхийн хараат бус байдал нь олон нийтийн итгэл ялангуяа шүүхийн шударга ёсны тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой бөгөөд ингэснээр хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй бөгөөд хэн ч хуулиас дээгүүр бус гэдэг зарчмын баталгаа юм. Хууль дээдэлдэг нийгэмд шүүх засаглал нь улс төрийн нөлөөнөөс хараат бус гэдэгт итгэх олон нийтийн итгэл амин чухал юм.

14. Олон улсын түвшинд , *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын* 14-р зүйлд зааснаар эрүүгийн болон иргэний хэргийн талууд хуулийн дагуу “хараат бус, тал үл харах шүүхээр” нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн¹⁰ (цаашид “ИБУТЭОУП” гэх). Бие даасан шүүх засаглалыг бий болгох, хадгалахад шаардлагатай институцийн харилцаа холбоо, механизм нь *Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмуудад* тулгуурласан (1985),¹¹ бөгөөд *Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчимуудаар* (2002) улам боловсронгуй болсон.¹² Шүүхийн хараат бус байдалд тавигдах практик шаардлагын талаар олон улсын ойлголтыг олон улсын байгууллагууд, түүний дотор НҮБ-ын Хүний эрхийн хороо,¹³ Шүүгч, хуульчдын хараат бус байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгч нар үргэлжлүүлэн тодорхойлсоор байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн (цаашид АЭНҮБК) 11-р зүйлд конвенцид оролцогч улс бүр “шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна” гэж хүлээн зөвшөөрснийг дурдах нь зүйтэй.¹⁴

зөвшөөрч, ийнхүү үнэт зүйлс, эрхийг нь бүрэн хэрэгжүүлэх хууль эрх зүйн тогтолцоон дээр үндэслэсэн шударга ёс” гэж заажээ (2 дах догол мөр).

- ⁹ [ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн 2005 оны 12-р сарын 6-ны өдрийн №12/05](#) “Эрүүгийн шүүхийн тогтолцоон дэх хүний эрх болон хуулийн засаглалыг дээдлэх тухай” шийдвэрийг харна уу.
- ¹⁰ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (цаашид “ИБУТЭОУП” гэх)-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2200А (XXI) тогтоолоор 1966 оны 12-р сарын 16-нд батласан. Монгол Улс 1974 оны 11-р сарын 18-нд соёрхон батласан.
- ¹¹ [Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмуудыг](#), НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/32 тогтоолоор 1985 оны 11-р сарын 29-нд болон 40/146 тогтоолоор 1985 оны 12-р сарын 13-нд тус тус батласан.
- ¹² [Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчимууд](#), хараат бус, бие даасан, ашгийн бус, сайн дурын Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын багийн баталсан Шүүгчийн ёс зүйн дүрмийн төслийг 2002 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Гааг хотод болсон ерөнхий шүүгчдийн дугуй ширээний уулзалтаар дахин хянасан бөгөөд НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 2006/23 тогтоолоор 2006 оны 7-р сарын 27-нд батласан. Мөн Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын багийн баталсан Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчимуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаарх гарын авлагыг (2010) мөн үзнэ үү, http://www.judicialintegritygroup.org/images/resources/documents/BP_Implementation%20Measures_Engl.pdf.
- ¹³ Ялангуяа ИБУТЭОУП-ын 14-р зүйлийн хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байх, түүнчлэн шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай Ерөнхий тайлбар 32 дугаарын 19-р догол мөрийг үзнэ үү, 2007 оны 8-р сарын 23-ны өдөр, http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CCPR%2fC%2fGC%2f32&Lang=en.
- ¹⁴ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 2003 оын 10-р сарын 31-нд батласан. Монгол Улс 2006 оны 1-р сарын 11-нд соёрхон батласан.

15. ЕАБХАБ-ын гишүүн орнууд “хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэсэн зарчмыг баримтлан, шударга ёсны тогтолцооны нэг хэсэг болох “шүүгчдийн хараат бус байдал, шүүхийн тогтолцооны шударга үйл ажиллагааг” баталгаажуулж, хангах үүрэг хүлээсэн болно ([1990 оны Копенгагены баримт бичиг](#)).¹⁵ Цаашилбал [1991 оны Москвагийн баримт бичигт](#)¹⁶ оролцогч гишүүн орнууд “шүүгчийн хараат бус байдлын тухай олон улсын хэм хэмжээг хүндэтгэх [...] болон шүүх эрх мэдлийн байгууллагын шударга үйл ажиллагааг эрхэмлэх”, “шүүхийн хараат бус байдлыг өөрийн улсын Үндсэн хуулиар болон бусад хуулиар баталгаажуулж, бие даасан, хараат бус байдлыг хангах” үүрэг хүлээсэн болно. Үүний сацуу тус бүс нутагт хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх гол элемент гэж үзэн 2008 оны [ЕАБХАБ-ын бүс нутагт хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх тухай дугаар 7/08 шийдвэрийн дагуу](#) ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөл нь гишүүн орнуудыг олон улсын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг мөн ЕАБХАБ-ын өмнө олон улсын болон үндэсний түвшинд хууль эрх зүй, засаг захиргаа, шүүх засаглалын бүхий л салбарт хууль дээдлэх талаар хүлээсэн үүргээ тус тус биелүүлэхийг уриалсан.¹⁷ Нэмэлт болон илүү нарийвчилсан удирдамжийг [Зүүн Европ, Өмнөд Кавказ, Төв Азийн шүүхийн хараат бус байдлын талаарх АИХЭГ-ын зөвлөмж баримт бичгээс харна уу](#) (2010) (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).¹⁸
16. Хэдийгээр Монгол Улс нь Европын Зөвлөлийн гишүүн улс биш боловч энэхүү санал зөвлөмжинд харьцуулж судлах, лавлах зорилгоор Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх Европын конвенц, Европын Холбооны Хүний эрхийн шүүх болон Европын Зөвлөлийн бусад хэрэгслүүдийг дурдсан болно.
17. Эцэст нь дурдахад, цаашид өгөх санал зөвлөмжүүдэд шаардлагатай гэж үзсэн олон улсын болон бүс нутгийн түвшинд боловсруулсан бусад тусгай баримт бичгийн талаар лавлагаа өгөх болно. Учир нь эдгээр нь шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр практик зөвлөмж, шилдэг туршлагыг өгдөг болно.¹⁹

¹⁵ [ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичиг](#), 5-р болон 5.12-р зүйл.

¹⁶ [ЕАБХАБ-ын 1991 оны Москвагийн баримт бичиг](#), 19.1-р болон 19.2-р зүйл.

¹⁷ [ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн дугаар 7/08 ЕАБХАБ-ын бүс нутагт хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх тухай шийдвэр](#) (Хельсинки хот, 2008 оны 12-р сарын 4-5-ны өдрүүд).

¹⁸ [Зүүн Европ, Өмнөд Кавказ, Төв Азийн шүүхийн хараат бус байдлын талаарх АИХЭГ-ын Киевийн зөвлөмжийг](#) (2010) ЕАБХАБ, Макс Планкийн харьцуулсан нийтийн болон олон улсын эрх зүйн хүрээлэн болон Шүүхийн бие даасан байдлын асуудлаарх Минерва судалгааны группын удирдамж доор бие даасан шинжээч нарын баг боловсруулсан болно.

¹⁹ Үүнд: Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан, зөвлөмжүүд <<http://www.ohchr.org/EN/Issues/Judiciary/Pages/Annual.aspx>><http://www.ohchr.org/EN/Issues/Judiciary/Pages/Annual.aspx>>; Олон улсын шүүгчдийн холбооны “[Шүүгчдийн нийтлэг тунхаглал](#)” (1999 он, 2017 онд шинэчилсэн), АИХЭГ-ын санал дүгнэлтүүд (<<http://www.legislationline.org/search/runSearch/1/type/2/topic/9>>), Венецийн Комиссын шүүхийн хараат бус байдлын асуудлаар гаргасан санал дүгнэлтүүд (<<https://www.venice.coe.int/webforms/documents/?topic=27&year=all>>). Бусад эх сурвалжид Европт гаргасан бичиг баримтууд болох Европын Шүүгчдийн холбооны Европын шүүгчдийн эрх зүйн байдлын тухай дүрэм DAJ/DOC (98)23 (Страсбург, 1998 оны 7-р сарын 8-10 өдрүүд), <<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?p=&id=1766485&direct=true>>, [ЕИИЗ3-ийн Шүүгчдийн Магна Харм](#) 2010 оны 11-р сарын 17-нд батласан, Шүүхийн Зөвлөлүүдийн Европын сүлжээний бусад баримт бичиг, тайлангууд <<https://www.ency.eu/https://www.ency.eu/>>.

2. Шүүхийн хууль эрх зүйн орчин

18. Монгол Улсын Үндсэн хуулийн III бүлгийн дөрөв дэх хэсэг нь шүүх эрх мэдлийг зохицуулдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд *“шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”* гэж заасан байдагаас гадна шүүгчийн шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс бусад байгууллага, иргэн хэн боловч оролцож болохгүй гэж заасан байдаг (49 дүгээр зүйлийн 2 заалт). Үүний сацуу 49-р зүйл нь Шүүгчийн Ерөнхий Зөвлөл нь *“шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг”* хангаж, ажиллах бөгөөд хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалж, *“шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах”* үүргийг биелүүлнэ гэж заажээ. Монгол Улсын Ерөнхийлөгч нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус томилдог (Үндсэн хуулийн 51-р зүйл). Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсвэл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно гэж заасан байдаг. Мөн Үндсэн хуульд, хуульд заасан журмаар анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу *“оролцуулна”* гэж тусгасан байна (Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дах заалт). Үндсэн хуулийн 48.2, 49. 5 дах заалтад заасны дагуу шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тус тус хуулиар тогтооно гэж заасан болно.
19. Шүүхийн зохион байгуулалт, шүүхийн захиргаа, шүүгчийн статус, шүүгчийн эрх зүйн байдал, маргаан шийдвэрлэх зэрэг асуудлыг саяхан нэмэлт, өөрчлөлт оруулсан хэд хэдэн хууль зохицуулдаг бөгөөд эдгээр нь *Шүүхийн тухай (2012 оны хууль, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), Шүүхийн захиргааны тухай (2012 оны хууль, 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), Шүүгчийн эрх зүйн байдлын тухай (2012 оны хууль, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай (2012 оны хууль, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), Эвлэрүүлэн зуучлалын тухай (2012 оны хууль, 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан) тус тус болно.*

3. Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт

20. Шүүхийн тухай хууль нь шүүхийн тогтолцоо нь нэгдмэл байх бөгөөд шүүх зохион байгуулалтын хувьд бие даасан байна гэдгийг заасанг онцолоход таатай байна (Шүүхийн тухай хуулийн 5.1-р зүйл). Гэсэн хэдий ч шүүхийн бие даасан хараат бус байдлыг хууль тогтоомждоо хуульчилан зааж практик дээр хамгаалаагүй тохиолдолд ийнхүү бие даасан хараат бус байх зарчимыг зөвхөн хүлээн зөвшөөрснөөр үр дүнд хүрэх боломжгүй юм. НҮБ-ын Хүний эрхийн хорооны ИБҮТЭОУП-ын 14 дүгээр зүйлийн Ерөнхий тайлбар 32-т пактын оролцогч орнууд нь *“шүүх засаглалын бие даасан байдлыг хангаж, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын улс*

төрийн нөлөөллөөс ангид байлгах нөхцөлийг хангах ёстой" гэж тусгайлан заасан байдаг. НҮБ-ын Хүний эрхийн хороо нь ИБУТЭОУП-ын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүх эрх мэдлийн байгууллагын "бие даасан" байдлыг хангахын тулд пактын оролцогч орнууд нь "шүүхийн хараат бус байдлыг хангах талаар тодорхой арга хэмжээг авч, шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд улс төрийн оролцоо, нөлөөнөөс шүүгчдийг хамгаалж, хараат бус байдлын баталгааг үндсэн хуулийн болон бусад хуулийн түвшинд бий болгож, шүүгч нарыг ажилд томилох, шүүгчид тавигдаж буй шалгуурыг, тэдгээрийн цалин хангамж, бүрэн эрхийн хугацаа, дэвшүүлэх, түдгэлзүүлэх, халах ба сахилгын шийтгэл ногдуулах журмыг бодитой, объектив тогтоох" үүрэг хүлээнэ гэжээ.²⁰

21. Ерөнхийдөө, тухайн шүүх эрх мэдлийн институцийн бие даасан байдлыг тодорхойлохдоо шүүхийн бие даасан байдал болон шүүгчийн хараат бус байдлыг хоёуланг нь авч үзэх хэрэгтэй. Үүнд: (а) шүүхийн албан хаагчдыг томилох арга зам, тэдний бие даасан байдал болон карьертай холбоотой бүх талыг харгалзаж үзэх шаардлагатай; (б) шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хугацаагүй томилогдох ерөнхий зарчмыг баталгаажуулах; (в) шүүх ба түүний гишүүдийг дотоодын болон гаднын шууд болон шууд бус нөлөөллөөс хамгаалах механизмтай байх; г) шүүх бүрэлдэхүүний бие даасан байх дүр төрх.²¹ Ерөнхийдөө, гүйцэтгэх засаглалын гарт шүүх эрх мэдлийг хэт их зохицуулах эрх мэдэл өгөх явдал нь "шүүхийн үйл ажиллагаатай холбоотой асуудалд шууд болон шууд бусаар хөндлөнгөөс оролцох боломжийг олгодог" бөгөөд [Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албанаас Бангалорын зарчимүүдэд өгсөн тайлбарт](#) энэ нь шүүхийн эрх мэдлийн институцийн бие даасан хараат бус байдлыг баталгаажуулсан хамгийн наад захын нөхцөлийг зөрчсөн үйлдэл болно гэж заасан байдаг.²² Үүнтэй холбогдуулан, доор дэлгэрэнгүй тайлбар өгсөний дагуу, Монгол Улсын Ерөнхийлөгч нь шүүх эрх мэдэлтэй холбоотой өргөн хүрээний асуудлаар, ялангуяа шүүхийн зохион байгуулалт, шүүгчийн статус, шүүгчийг томилох болон чөлөөлөх зэрэг асуудлаар өргөн хүрээг хамарсан хэт их эрх мэдэлтэй байгаа явдал нь ИБУТЭОУП-ын 14 дүгээр зүйлинд тусгасан "хуулиар тогтоосон бие даасан хараат бус шударга шүүх"-ээр шүүгдэх нэхэмжлэгчдийн эрхийг зөрчих талтай байна (доорх тодорхой зөвлөмжүүдийг үзнэ үү).

²⁰ Өмнө иш татсан 13-р зүүлт, 19-р зүйл (ИБУТЭОУП-ын Ерөнхий тайлбар 32) үзнэ үү.

²¹ Дээр дурдсан 19-р зүйлийг (ИБУТЭОУП-ын Ерөнхий тайлбар 32) үзнэ үү. Мөн [АИХЭГ-ын Шударга шүүхээр шүүгдэх эрхийн тухай олон улсын хуулийн цуглуулга боть](#) (2012); харьцуулалт хийх зорилгоор Европын хүний эрхий шүүхийн цуглуулга харна уу. [Campbell and Fell v. the United Kingdom](#) (Application nos. 7819/77, 7878/77, judgment of 28 June 1984), par 78; [Olujić v. Croatia](#) (Application no. 22330/05, judgment of 5 May 2009), par 38; [Oleksandr Volkov v. Ukraine](#) (Application no. 21722/11, judgment of 25 May 2013), par 103; [Morice v. France](#) [GC] (Application no. 29369/10, judgment of 23 April 2015), par 78; on the relation of the judiciary with other branches of power: [Baka v. Hungary](#) [GC] (Application no. 20261/12, judgment of 23 June 2016), par 165; [Ramos Nunes de Carvalho E Sá v. Portugal](#) [GC] (Application nos. 55391/13, 57728/13 and 74041/13, judgment of 6 November 2018), par 144; [Guðmundur Andri Ástráðsson v. Iceland](#) (Application no. 26374/18, judgment of 12 March 2019), pars 100-103).

²² НҮБ-ын МБГХТА, [Бангалорын зарчимүүдэд өгсөн тайлбар](#) (2007 оны 9-р сар)-ын 26-р зүйл. Түүнчлэн [АИХЭГ-ын Польш Улсын Улсын дээд шүүхийн тухай хуулийн төслийн зарим заалтад хийсэн санал дүгнэлтийг](#) (2017 оны 9-р сарын 26-ны өдрийн байдлаарх), 2017 оны 11-р сарын 13-ны өдөр, 86-р зүйлийг үзнэ үү.

3.1. Шүүхийн тогтолцоо

22. Шүүхийн тухай хуулийн 5.4-т “аливаа шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж заасан нь Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үг хэллэгийг тусгасан байна.²³ Энэ нь Монгол Улсын бүх шүүх эрх мэдлийн байгууллага (анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүд) Улсын Дээд шүүхийн “хяналт” дор байна гэсэн үг юм.
23. Дээрх 5.4 дүгээр зүйлийг практик дээр хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхойгүй байна, шүүх эрх мэдлийн дээд шатны байгууллага нь шүүгчдийн бие даасан хараат байдалд халдах ёсгүй бөгөөд урьдчилсан дүгнэлт гаргах эсвэл хууль хэрэглэх болон хуульд заасан журмыг хэрэглэх талаар тайлбар, шийдвэр гаргахаас бусад тохиолдолд дээд шатны шүүгчид доод шатны шүүгч нарт бие даасан хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар заавар, зөвлөмж өгөх ёсгүй болно.²⁴ Хэдийгээр Улсын Дээд шүүх зэрэг дээд шатны шүүх байгууллага нь аливаа улс орны хувьд эрх зүйн тодорхой байдал, урьдчилсан таамаглал, хууль тайлбарлах, хууль зөв хэрэглэх талаар тайлбар гаргах, эрх зүйн хууль тогтоомжийг нэг мөр зөв ойлгож, хэрэглэх нөхцөлийг хангахад голлох үүрэг гүйцэтгэдэг ч,²⁵ доод шатны шүүхийг хянах, шүүгчид заавал дагаж мөрдөх удирдамж, заавар, тайлбар өгөх ёсгүй болно.²⁶ Энэ тал дээр шүүхийн прецедент гэж тусгайлан тодорхойлсон дээд шүүхүүдийн жишиг шийдвэрүүд болон шийдвэрүүд нь зөвлөмжийн статустай байх ёстой бөгөөд бусад тохиолдолд доод шатны шүүхийн шүүгч нарын хувьд заавал мөрдөх ёсгүй байх болон доод шатны шүүхийн шүүгч нарыг шийдвэр гаргах, хариуцлага хүлээлгэх хараат бус байдлыг нь хязгаарлахад ашиглах ёсгүй юм.²⁷ Хэрэв орчуулгын зөрүү гараагүй бол, “хяналт” гэдэг тодорхой бус томъёолол нь шүүхийн ерөнхий хараат бус байдал болон шүүгчийн бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхуйц нөхцөл буй болгож байна.²⁸ Өөрөөр хэлбэл бусад шүүгч, дотоод шүүх эрх мэдэл, дээд шатны шүүхийн нөлөөлөлөөс ангид бие дааж шүүгчийн албан ажлаа явуулах нөхцөлд эргэлзээ үүсгэж байна. **Иймд ниймэрхүү төрлийн хяналтыг зөвхөн хууль ёсны дагуу авч хэлэлцэх/давж заалдах маягаар хэрэгжүүлэх талаар тус хуулийн 5.4-р заалтанд тодруулж өгөх хэрэгтэй юм.** Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд өмнө нь дурдаж байсан Шүүхийн тухай хуулийн 17.3.1-т “хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэх заалт нь энэхүү

²³ <https://www.legislationline.org/download/id/6489/file/Mongolia_Constitution_1992_am2001_en.pdf>. Цахим хуудаст орж харна уу.

²⁴ 18-р зүүлт, 35-р зүйл (2010 оны Киевын зөвлөмж) үзнэ үү. Түүнчлэн харьцулсан шинжилгээ хийх зорилгоор Европын Зөвлөлийн Сайд нарын хорооны “[Гишүүн орнуудын шүүгч нарын хараат бус байдлыг хангах, үр дүнтэй ажиллагаа болон үүрэг хариуцлагын тухай](#)”, CM/Rec(2010)12, 2010 оны 11-р сарын 17-ны өдрийн зөвлөмжийн 22-23-р зүйл, [ЕШЗЗ-ын Шүүхийн бие даасан хараат бус байдал болон шүүгчийн бүрэн эрхийн тухай стандартад](#) өгсөн Тайлбар 1-ийн 68-р зүйл, 2001 оны 11-р сарын 23-ны өдөр.

²⁵ [Венецийн Комиссын Босни-Герцеговин дах шүүхийн хараат бус байдал болон хууль эрх зүйн хүрээнд хийсэн санал дүгнэлт дугаар](#), CDL/AD (2012)014, 2012 оны 6-р сарын 18-ны өдөр, 64-65-р зүйлийг тус тус үзнэ үү.

²⁶ Тайлбар 18, 35-р зүйл (2010 оны Киевын зөвлөмж) үзнэ үү, мөн 2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн хараат бус байдлын тухай тайлангийн 1 дэх хэсэг – Шүүгчийн хараат бус байдлын бүлгийн 70-71-р зүйлийг үзнэ үү, <<https://rm.coe.int/1680700a63>>.

²⁷ Өмнө дурдсан 35-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Шүүхийн хараат бус байдлын тухай Киевын зөвлөмж)-ийг үзнэ үү.

²⁸ Дээрх зүйлтэй холбоотой заалтыг АИХЭГ-Венецийн Комисс хамтран Киргиз Улсын Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн санал дүгнэлтийн 66-р зүйлийг үзнэ үү. 2016 оны 10-р сарын 19-ний өдөр, <https://www.legislationline.org/download/id/6433/file/294_CONST_KGZ_19Oct2016_en_final.pdf>.

зарчмуудтай илт зөрчилдөж байгаа тул 2015 онд Үндсэн хуулийн зарлигаар хүчингүй болгосон явдал нь баярлууштай юм.

24. Шүүхийн тухай хуулийн 5.4-р заалтыг мөн Дээд шүүх доод шатны шүүхийн шийдвэрүүдэд хяналт шалгалт тогтооно (зайлшгүй эргэн харах хангалттай үндэслэл бүхий онцгой зарим нөхцөлөөс бусад тохиолдолд)²⁹ гэж ойлгож болохгүй юм. Учир нь энэ нь *res judicata* (шүүхийн эцсийн шийдвэрийг заавал дагаж мөрдөх зарчим) зарчимтай нийцэхгүй бөгөөд хууль эрх зүйн тодорхой байдлыг сулруулж, улмаар хууль дээдлэх зарчмыг зөрчих юм.³⁰
25. Дээр дурдсаны дагуу хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид доод шатны шүүхүүд шийдвэр гаргахдаа Улсын Дээд Шүүхэд шаталсан байдлаар захирагддаг байдлыг халах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 5.4-р заалтыг илүү тодруулах боломжийг авч үзэх эсвэл хүчингүй болгох нь зүйтэй юм. Бас нэг өөр хувилбар нь Дээд шүүхээс баталсан зааварчилгаа болон шийдвэрүүдийг зөвлөмж болгон ашиглах ба доод шатны шүүхийн хувьд тэдгээр нь зайлшгүй мөрдөх ёсгүй байхаар хуульд зааж өгөх хэрэгтэй юм.
26. Шүүхийн тухай хуулийн 15.1-т зааснаар Улсын Дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд “*хяналтын шатны шүүх*” мөн гэж заасан байдаг. Мөн цаашлаад 17-р зүйлд Үндсэн хуулийн 50-р зүйлийг³¹ тусган Дээд шүүхийн бүрэн эрхийг тодорхойлсон ба үүнд мөн “*давж заалдах журмын дагуу авч хэлэлцэх болон шүүхийн маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ*” гэж заасан байна. Гэхдээ Үндсэн хуулийн болон тус хуулийн томъёолоос харахад энэ нь ямар үр дагавартай байх нь тодорхойгүй байна. Дээд шүүх нь мөн чанараараа давж заалдах шүүх мөн үү (тэрээр зөвхөн доод шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг л авч үздэг ба факт буюу баримтуудыг авч үздэггүй, зарчмын хувьд хэргийг шүүхэд буцаадаг) эсвэл баримтууд болон хуулийг хэрэглэсэн байдлыг авч хэлэлцэж эцсийн шийдвэр гаргадаг Улсын Дээд шүүх байгууллага уу гэдгийг тодруулах хэрэгтэй юм. Хэрэв орчуулгын зөрүү гараагүй бол мөн процедурын дүрэм журам/хуулиуд нь энэ асуудлыг тодруулж магадгүй ч, эл асуудлыг тодорхой болгохын тулд Шүүхийн тухай хуульд Улсын

²⁹ Харьцуулалт хийх зорилгоор Европын хүний эрхий шүүхийн 7-р нэмэлт протоколын 4-р зүйлд, шинэ буюу шинэ олдсон баримт нотолгоо байгаа бол, эсвэл өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн үр дүнд нөлөөлж болзошгүй ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дагуу хэргийг дахин нээх боломжтой гэж заажээ (ECtHR, [Lenskaya v. Russia](#) (Application no. 28730/03, judgment of 29 January 2009), para 36-44). Венецийн Комиссын [Rule of Law Checklist](#), CDL-AD(2016)007, 2016 оны 3-р сарын 18-ны өдрийн, 63-р зүйл болон Европын Зөвлөлийн “*The Council of Europe and the Rule of Law - An Overview*”, CM(2008)170, 2008 оны 11-р сарын 21-ний өдөр, 48-р зүйлийг тус тус үзнэ үү.

³⁰ Дээд шүүхийн захирамж, тайлбар, тушаал гаргахыг дэмжих ёсгүй, гэхдээ энэ нь байж болох тохиолдолд доод шатны шүүхийн шүүгчид заавал дагаж мөрдөх ёсгүй. Эс тэгвэл тэд шүүгчийн бие даасан хараат бус байдлыг зөрчсөн гэж үзэж байгаа юм. Энэ тал дээр шүүхийн прецедент гэж тусгайлан тодорхойлсон дээд шүүхүүдийн жишиш шийдвэрүүд болон шийдвэрүүд нь зөвлөмжийн статустай байх ёстой бөгөөд бусад тохиолдолд доод шатны шүүхийн шүүгч нарын хувьд заавал мөрдөх ёсгүй байх болон доод шатны шүүхийн шүүгч нарыг шийдвэр гаргах, хариуцлага хүлээлгэх хараат бус байдлыг нь хязгаарлахад ашиглах ёсгүй юм. Хуулийн талаарх нэгдсэн тайлбарыг шүүхийн практикийг судлах замаар дэмжих нь зүйтэй юм. ЭЗХАХБ-ын Киргиз дахь Авлигын эсрэг шинэтгэл-Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний хоёрдугаар үе шатны үнэлгээний тайлан, зөвлөмжүүдийн 71-р хуудас үзнэ үү, <<http://www.oecd.org/corruption/acn/49882439.pdf>>. Харьцуулалт хийх зорилгоор, ОХУ-ын хянан шийдвэрлэх журам, [Ryabykh v. Russia](#) (Application no. 52854/99, judgment of 24 July 2003), 51-58-р зүйлийг үзнэ үү.

³¹ <https://www.legislationline.org/download/id/6489/file/Mongolia_Constitution_1992_am2001_en.pdf> цахим хуудаст нэвтэрч үзнэ үү.

Дээд Шүүхийн мөн чанарыг тодруулж өгөх нь зохистой юм. Яг үүнтэй адил, хэрэв мэдээж үүнийг Үндсэн хуулийн цэц болон Ерөнхий прокурорын тухай холбогдох хууль тогтоомжуудад тодорхой заагаагүй бол, тус хуулийн 17.3.4-р зүйлд Үндсэн хуулийн цэц болон Ерөнхий прокуророос шилжүүлэх ямар асуудлыг хянан шийдвэрлэх эрхтэйг тодорхой болгох нь зүйтэй эс бөгөөс холбогдох хууль тогтоомжийн лавлагааг дурдах нь зүйтэй болно.

27. Эцэст нь Шүүхийн тухай хуулийн 16.1-р зүйлд Улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, 24-ээс доошгүй шүүгчээс бүрдэнэ гэж заасан байдаг. Хуульд дээд хязгаарыг нь заагаагүй явдал нь нэгэн зэрэг олон тооны шүүгчийг томилох магадлалыг үгүйсгэхгүй байгаа бөгөөд үүнийг Дээд шүүхийн “эрх мэдлийг булаан авах” арга хэрэгсэл нээлттэй гэж ойлгож болохоор байна. Энэ нь тус институцийн бие даасан байдалд ноцтой үр дагавар дагуулж болзошгүй юм.³² Иймд хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид гишүүдийн тооны дээд хязгаарыг нэвтрүүлэх боломжийг судалж үзэх нь зүйтэй болно.

3.2. Хууль тогтоомж боловсруулах явц дах шүүхийн оролцоо

28. Шүүхийн тухай хуулийн 20.1.3-р болон 23.1.2-р зүйлд давж заалдах болон анхан шатны шүүхүүдэд шүүн таслан ажиллагааны шүүхийн практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын Дээд шүүхэд уламжлах эрхийг тус тус олгож байна. Хууль тогтоомж боловсруулах явц дах шүүхийн оролцоо янз бүр байдаг ба тухайн улс орны хууль эрх зүйн тогтолцооноос хамаардаг болно.³³ Ерөнхийдөө шүүгчийн эрх зүйн байдал, шүүхийн захиргаа, хэрэг хянан шийдвэрлэх процессын хууль тогтоомжууд, мөн түүнчлэн шүүх тогтолцоо болон шүүх тогтолцооны үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болох бүх хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажиллагаанд шүүгчид, шүүгчдийн холбоонууд болон шүүхийн зөвлөлүүдтэй зөвшилцөж байхыг сайн туршлагад тооцдог болно.³⁴ Ер нь шүүхийн

³² АИХЭГ-ын [Молдав улсын Дээд шүүх болон Прокурорын байгууллагыг шинэчлэх тухай хуулийн төслийн талаарх санал дүгнэлт](#) (2019 оны 9-р сарын байдлаар), 2019 оны 10-р сарын 16-ны өдөр, 40-р зүйлийг үзнэ үү. Мөн Венецийн Комиссын [Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл; Польшийн Ерөнхийлөгчийн өргөн барьсан Дээд шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн төсөл](#), CDL-AD (2017) 031, 80-р зүйл.

³³ АНУ-ын Калифорни муж, Төрийн Хууль зүйн хүрээлэн, ["Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулах үйл явц дах шүүхийн оролцооны талаарх шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарт зориулсан гарын авлага"](#) -г дараах дөрвөн асуудалтай холбоотой удирдамжийг оруулсан байна. Үүнд шүүх засаглалын салбарын төсөв, нөөцтэй холбоотой асуудал, шүүх засаглалд шууд хамааралтай асуудал, шударга ёсыг хэрэгжүүлэхэд хамаарах бусад асуудал, хууль тогтоомжийн бусад асуудлаарх тус тус шүүхийн оролцоо багтдаг байна. Мөн Шотландын шүүх засаглалын хууль тогтоох үйл явц дах оролцооны асуудлаарх олон нийтийн өргөдөл гомдлын хорооны танилцуулга (2010), [<http://www.parliament.scot/ResearchBriefingsAndFactsheets/Petitions%20briefings%20S3/PB10-1361.pdf>](#); Лордуудын танхим, [Davidson v. Scottish Ministers хэргэ](#) (2004). Канадын Шүүхийн зөвлөлөөс гаргасан Шүүгчийн ёс зүйн зарчим болон Шүүгчийн ёс зүйн зарчмын шинэчилсэн найруулгын төслийг (2019 оны 11-р сарын 20-ны байдлаарх) 5.D.2.зарчмыг тус тус үзнэ үү, [<https://cjc-ccm.ca/sites/default/files/documents/2019/news_pub_judicialconduct Principles_en.pdf>](#); [<https://cjc-ccm.ca/sites/default/files/documents/2019/EPJ%20-%20PDJ%202019-11-20.pdf>](#).

³⁴ НҮБ-ын шүүгч, хуульчийн хараат бус байдлын талаарх тусгай илтгэгч, [2019 он. Шүүгчид ба прокурорүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван цугларах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх тухай тайлан](#), А/НРС/41/48, 2019 оны 4-р сарын 29, 69-р зүйл; жишээ нь, ишлэл. тайлбар 32, 141, 143, 146-р зүйлүүд (Молдавын талаарх 2019 оны ОДИНР Завсрын санал дүгнэлт). Түүнчлэн харьцуулах зорилгоор ССЖЕ, [Opinion no. Шүүгчийн ёс зүй ба харьцуулалтын тухай 3](#) (2002), 34-р зүйл; Санал Үгүй. ["Нийгэмд үйлчлэх шүүхийн зөвлөлийн тухай" 10](#) (2007), 87-р зүйл; [Санал Үгүй. 18 \(2015 он\) Шүүгчийн байр суурь ба орчин үеийн ардчилал дахь төрийн бусад эрх мэдэлтэй харьцах тухай](#) 2015 оны

байгууллагын саналыг шүүгч түс бүрээр уламжлах бус харин шүүхийн институцийн хамтарсан санал хэлбэрээр уламжлахыг зөвлөдөг болно.³⁵ Үүнтэй холбогдуулан шүүгч нар өөрсдийн саналаа хувиараа уламжилдаггүй, харин Улсын Дээд шүүх дээр цуглуулж нэгтгэж, улмаар Дээд шүүх цааш хууль санаачлагчдад уламжилдаг нь сайн талтай юм (Шүүхийн тухай хуулийн 17.3.2-р зүйл).

29. Үүний зэрэгцээ хууль боловсруулах үйл ажиллагаанд шүүгч нар шууд оролцох явдал нь тэдний тал үл харах буюу төвийг сахих байдалд эргэлзээ төрүүлэхэд хангалттай нөхцөл байдал үүсгэж болох юм. Ялангуяа тухайн шүүгчийг хэлэлцэж буй хууль тогтоомж эсвэл журам дүрмийг тайлбарлахад үүссэн маргааныг шийдвэрлэх зорилгоор эсвэл эдгээр заалтуудын томъёоллыг тайлбарлахаар дуудах шаардлага гарах тохиолдолд ийнхүү эргэлзээ гарах магадлал өндөр байна.³⁶ Шүүхийн захиргааны асуудлаарх хууль тогтоомж боловсруулах шатанд шүүгчид болон тэдгээрийн мэргэжлийн байгууллагууд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх явдал болон хуулийн гол зүйл заалтуудыг боловсруулах ажилд тэдгээрийг оролцуулах нь зохимжтой боловч, шүүгчийн тал үл харах буюу төвийг сахих байдалд эргэлзээ төрүүлэхгүй байх нөхцөлийг хангахын тулд тухайн шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомж боловсруулахад оролцож байсан тохиолдолд түүнийг тус хэргийг хянан шийдвэрлэх ажилд оролцохгүй байлгах механизмыг урьдчилан бий болгох нь чухал юм. Хэрэв Монголын хууль тогтоомж практик дээр зарим нэг тодорхой шүүгчийг хууль боловсруулах үйл явцад шууд болон идэвхтэй оролцохыг хүлээн зөвшөөрдөг бол, мөн энэ нь бусад хууль тогтоомжинд тусгагдаагүй бол, **тухайн шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх асуудалтай холбоотой хууль тогтоомж боловсруулах явцад шууд болон идэвхтэй оролцсон тохиолдолд тухайн хэрэгтэй холбогдолтой хуулиудыг хөндөхөд хүргэх хэргүүдийн шүүх ажиллагаанд тухайн шүүгчийг түдгэлзүүлэх боломжийг эсвэл тодорхой шүүгчийг автоматаар оролцуулахгүй байх механизмыг хуулинд тусгах нь зохистой болно.**

3.3. Шүүхийн төсөв

30. Шүүхийн тухай хуулийн 6.4-р зүйлд “*шүүх засаглал нь бие даасан төсөвтөй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана*” гэж заасан байдаг. Шүүхийн тухай хуулийн 28.3-р зүйл шүүхийн төсөв нь Улсын Дээд шүүхийн, аймаг, нийслэлийн шүүхийн, дагнасан шүүхийн болон Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн төсвөөс тус тус бүрдэнэ гэж заасан. Тус хуулийн 28.4-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлнэ гэсэн байна. Эдгээр чухал заалтууд нь Шүүхийн захиргааны тухай хуульд бүрэн тусгагдаагүй, ялангуяа Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн энэ талаарх эрх мэдлийн тухайд тусгагдаагүй байна.

10-р сарын 16-ны өдөр, 31-р хэсэг; ор. ишлэл. 9-р сарын 19, 9-р тайлбар (2010 оны CCJE Magna Carta Шүүгчдийн тухай); ба оп. ишлэл. тайлбар 19, хуудас 1.8. (1998 оны Европын дүрэм).

³⁵ Өмнө иш татасан 22-р зүүлтийн 139-р догол мөрийг үзнэ үү (2007 НҮБ-ын МБГХТА, Бангалорын зарчимуудын тайлбар).

³⁶ Харьцуулах зорилгоор ЕХЭШ-ийн цуглуулгын [McGonnell v. the United Kingdom](#) (2000), 55-р зүйл харна уу.

Иймд энэ асуудлыг тодорхой болгох үүднээс **Шүүхийн захиргааны тухай хуулинд Шүүхийн тухай хуультай холбогдох заалтуудын лавлагааг оруулах эсвэл тус хуулинд Шүүхийн Ерөнхий Зөвлөл бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлнэ гэсэн заалтууд оруулахыг зөвлөж байна.** Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.1-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөнө гэсэн заалтыг хассан явдал нь ойлгомжгүй байгаа юм. Гэтэл энэ эрх мэдлийг Шүүхийн тухай хуулийн 28.4-т тодорхой заасан байдаг. Энэ тал дээр тодорхой болон тууштай байдлыг хангах нь чухал байна.

31. Ерөнхийдөө шүүх засаглал бие даасан төсөвтөй байх зарчим нь сайшаалтай боловч хуулинд шүүх засаглалын санхүүгийн хараат бус байдлыг хангах баталгаа болон шүүхийн зохих үйл ажиллагааг хангахад зориулсан хангалттай санхүүжилт, нөөц бололцоо хувиарлах баталгаа үгүй байна. Шүүхийн тухай хуулийн “шүүхийн эдийн засгийн баталгааны тухай” 28.1-р зүйлд “*бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна*” гэж заасан байна. Гэхдээ хангалттай тооны шүүгч гэж хэрхэн тодорхойлох арга замыг зааж өгөөгүй тохиолдолд энэ нь зөвхөн зарчмын төдий мэдэгдэл хэвээр үлдэж болох юм. Шүүгчийн албан тушаалын тоог тодорхойлох ажлын хувьд гэвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон хууль тогтоогчид шүүх засаглалтай зөвшилцсөнөөр шүүгчийн тоог эцэслэн тодорхойлох боломж илүүтэй байдаг юм.³⁷ Энэ талаар холбогдох хууль тогтоомжинд тодорхой зааж өгөхийг зөвлөж байна.
32. Зарчмын хувьд шүүх эрх мэдлийн байгууллагын төсвийг боловсруулах ажил системчлэгдсэн, гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн зүгээс хараат бус буюу улс төрийн хөндлөнгийн зохисгүй нөлөөллөөс ангид байх ёстой юм.³⁸ Шүүхийн төсвийг төлөвлөн боловсруулах болон түүнийг шүүхүүдэд хуваарилах ажлыг ерөнхийд нь шүүхийн зөвлөлүүдэд даалгах нь зүйтэй гэж зөвлөх байна.³⁹ Шүүхийн төсөв санхүүжилтийг албан байгууллагуудын үзэмжээр гаргасан шийдвэрийг үндэслэн тогтоох бус харин объектив, ил тод шалгуураар үндэслэлтэй тогтоох нь зүйтэй юм.⁴⁰ Иймд улс болгон ИБҮТЭОУП-ын 14 дүгээр зүйлд заасан стандартад нийцүүлэн шүүгч болон шүүхийн албан тушаалтнууд үр дүнтэй үйл ажиллагаагаа явуулах хангалттай нөөц бололцоо, хөрөнгө мөнгө болон шаардлагатай техник

³⁷ Жишээ нь, [Польшийн Дээд шүүхийн тухай хуулинд хийсэн санал дүгнэлт](#), 2017 оны 8-р сарын 30-ны 38-39-р зүйлийг үзнэ үү. Мөн Венецийн Комиссын цуглуулага, [Гүрж улсын шүүхийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөлд Венецийн Комисс болон Европын Зөвлөлийн Хүний эрх, хуулийн засаглалын асуудлаарх \(DGI\) газрын Хүний эрхийн асуудлаарх газрын \(DHR\)-ын хамтран хийсэн](#) санал дүгнэлтийн 14, 19-р зүйлийг үзнэ үү. CDL-AD (2014) 031, 2014 оны 10-р сарын 14.

³⁸ Харьцуулах зорилгоор, [Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээнээс гаргасан 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлангийн](#) 3-р хуудас үзнэ үү.

³⁹ Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2018 оны Шүүхийн зөвлөлийн тухай тайлангийн 91-р зүйлийг үзнэ үү. 2018 оны 5-р сарын 2, A/HRC/38/38, <https://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/38/38>.

⁴⁰ Өмнө иш татсан 26-р зүйлийг харна уу. 2010 оны Венецийн Комиссын Шүүхийн хараат бус байдлын талаарх тайлангийн 1-р хэсэг – Шүүгчийн хараат бус байдлын тухай бүлгийн 53-р зүйл.

хэрэгслэлээр хангаж өгөх ёстой юм.⁴¹ Шүүхийн тухай хуульд төсөв нь шүүх засаглалын үүрэг болон үйл ажиллагааг бүрэн, хараат бус, үр ашигтай болон үр дүнтэй гүйцэтгүүлэхэд хангалттай байхаар зааж өгөх нь зүйтэй юм. Мөн үүнд шүүхийн дэд бүтэц, олон нийтэд хүртээмжтэй шүүхийн байр, орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи, цалин хөлс, урамшуулал, нийгмийн болон бусад тэтгэмж, шүүгчдийн чадавхийг хөгжүүлэх (энэ тухай 35-36-р зүйлд тодорхой дурдсан байгаа) зэрэгт зохистой санхүүжилтийг тусгаж өгөх ёстой юм.

33. Шүүхийн санхүүжилт нь улс төрийн тогтворгүй байдлаас⁴² болж үүссэн савалгаанаас хамгаалагдсан байх нь чухал ба эдийн засгийн хүнд байдал болон хямралын үед ч гэсэн шүүх тогтолцооны үйл ажиллагаа болон түүний хараат бус байдал нь аюулд өртөх ёсгүй юм.⁴³ Бүр онцгой тохиолдолд төсвийг бууруулах зайлшгүй чухал шалтгаан байсан ч гэсэн ийнхүү төсөвийн танаас нь шүүхийн тогтолцооны эдийн засгийн баталгааг аль болох хөндөхгүй байх нь зүйтэй юм. Шүүхийн тухай хуулийн 28.5-р зүйл буюу шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно гэсэн заалтыг 2015 онд хүчингүй болгосон гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй байх. Олон улсын байгууллагуудын дүгнэлтэд шүүх тогтолцооны төсөв санхүүжилтийн хэмжээ доогуур байгааг онцлоод, саяхан шүүхийн үйл ажиллагааны төсөвт хийсэн тодотгол нь шүүх тогтолцооны үйл ажиллагаанд болон ерөнхийдөө шүүхийн хараат бус байдалд нь сөрөг нөлөө үзүүлж байна гэж тэмдэглэсэн байна.⁴⁴ Энэ асуудал дээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын⁴⁵ зөвлөмжийн дагуу хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид шүүхийн үйл ажиллагааны зардлыг бууруулахыг хориглосон заалтыг дахин оруулах асуудлыг авч үзэх нь зүйтэй юм. Нөгөөтэйгүүр үндэслэлгүйгээр төсвийг бууруулахын эсрэг бусад хууль эрх зүйн заалтуудыг оруулж болох юм. Жишээ нь, өмнөх жилийнхтэй харьцуулахад шүүхийн төсвийг хуваарилахад хийгдсэн аливаа таналт нь УИХ эсвэл Засгийн Газрын төсвийг хуваарилахад хийгдсэн таналтын хувиас илүүгүй байх гэх мэт заалт оруулахыг судалж үзэх.⁴⁶
34. Шүүхийн дэд бүтцэд зориулж хуваарилсан хөрөнгө санхүүжилтийн хувьд гэвэл эдгээр шүүхийн байр, танхимууд болон мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслүүд нь

⁴¹ Харьцуулах зорилгоор [ЕШЗЗ-ийн Шүүхийн санхүүжилт, захиргааны тухай 2 дах санал дүгнэлт болон өмнө иш татсан](#) 38-р зүүлт, Зөвлөмж 4 үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁴² Өмнө иш татсан: Зөвлөмж 5 үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁴³ Өмнө иш татсан 26-р зүүлтийг харна уу. 2010 оны Венецийн Комиссын Шүүхийн хараат бус байдлын талаарх тайлангийн 1-р хэсэг – Шүүгчийн хараат бус байдлын тухай бүлгийн 53-р зүйл.

⁴⁴ Өмнө иш татсан 5-р зүүлт, (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан) 53 болон 62-63-р хуудас харна уу.

⁴⁵ Дээр иш татсан: Шинэ зөвлөмж 11 (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан) 15-16-р хуудас харна уу.

⁴⁶ Жишээлбэл, хүний эрхийн үндэсний байгууллагуудын санхүүгийн хараат бус байдлыг хангах арга замын талаархи харьцуулалтыг үзнэ үү, [АИХЭГ-ын Швейцарийн Хүний эрхийн үндэсний институтийг дэмжих тухай холбооны хуулийн төслийн талаархи санал, дүгнэлт](#) (2017 оны 10-р сарын 31), 88-р зүйл; [Исландын Хүний эрхийн бие даасан үндэсний байгууллагын тухай хуулийн төслийн талаархи АИХЭГ-ын дүгнэлт](#) (2017 оны 2-р сарын 6-ны өдөр, 76-р зүйл).

олон нийтэд, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд⁴⁷ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенц (цаашид “НҮБ-ын ХБИЭК” гэх)⁴⁸ 9-р зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь “*бие даан амьдрах болон амьдралын бүхий л салбарт оролцох эрхтэй*”⁴⁹ гэсэн заалтад нийцүүлэн илүү хүртээмжтэй байх ёстой гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Иймд Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.9-р зүйлд шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийхдээ олон нийтэд нээлттэй байхыг хангахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч мөн хүртээмжтэй байх байдлыг хангахыг тусгах нь зүйтэй болно.

35. Төсөвт мөн шүүгчдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх сургалтанд хамруулах зардлыг тусгасан байх ёстой юм⁵⁰ (5.7 дэд хэсгийг харна уу). Ерөнхийдөө шүүхийн шударга, хараат бус байдал, түүний үр дүнтэй шүүх ажиллагааг хангах зорилгоор шүүгч нарын цалин хөлс, урамшуулал, нийгмийн болон бусад тэтгэмж (цалин хөлс, өвчтөй үеийн тэтгэмж, жирэмсний болон төрсний дараах цалинтай чөлөө, тэтгэвэр) зэргийг улсын зүгээс хангаж өгөх нь зүйтэй.⁵¹ Мөн шүүх тогтолцооны инноваци болон шинэчлэлд, жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх сүүлийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи⁵² нэвтрүүлэхэд зориулж хангалттай хөрөнгө санхүүжилт төсөвлөж өгөх шаардлагатай юм.
36. Шүүгчдийн цалин нь тэднийг зүй бус нөлөөллөөс ангид, хараат бус байлгах хэмжээнд хангалттай байх нь чухал учир шүүгчдийн цалин хөлс, урамшуулал нь тэдний албан тушаалын нэр хүнд, ажил үүргийн цар хүрээнд нийцүүлэн хуулиар баталгаажсан байх нь чухал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.⁵³ Зарчмын хувьд шүүгч нарыг томилсны дараа тэдний цалин хөлсийг тэд нарт хохирол учруулахуйцаар буруулах ёсгүй юм.⁵⁴ Ийм төрлийн заалтыг хууль тогтоомжинд оруулж болох юм. Гэхдээ эдийн засгийн хувьд онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн албан хаагчдын цалин хөлс нийтээрээ буурах нөхцөлд үүнийг эргэн харж болох ба ингэснээр шүүгч нарт улсын төсвөөс цалинждаг бусад албан хаагчидтай харьцуулахад хэт их

⁴⁷ НҮБ-ын ХЭЗ-ийн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийн 13-р зүйлийн дагуу Шүүхэд хандах эрхийн тухай тайлангийн 20-р зүйлийг үзнэ үү (2017 оны 12-р сарын 27), <<https://undocs.org/A/HRC/37/25>>.

⁴⁸ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийг Ерөнхий Ассамблейн 61/106 тоот тогтоолоор 2006 оны 12-р сарын 13-нд батласан. Монгол Улс 2009 оны 5-р сарын 13-нд соёрхон батласан.

⁴⁹ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийн 9-р зүйлд “*гишүүн орнууд нь эдгээр байгууллагын байр, танхимууд болон мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслүүд нь олон нийтэд, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх нөхцөлийг хангах үүрэгтэй. Үүний сацуу эдгээр байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийхдээ олон нийтэд нээлттэй байхыг хангахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч мөн хүртээмжтэй байх байдлыг хангахыг түүнчлэн одоо ашиглаж буй байр танхимын дэд бүтцийг өөрчлөхөд хангалттай төсөв санхүүжилтийг төсөвлөх үүрэг хүлээнэ*” гэж заасан болно.

⁵⁰ Өмнө иш татсан 38-р зүүлт, Зөвлөмж 3 үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁵¹ Өмнө иш татсан 5-р хуудсыг харна уу (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁵² Өмнө иш татсан: Зөвлөмж 7 үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁵³ Өмнө иш татсан 26-р зүүлт, 46 болон 51-р зүйлийг харна уу (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн хараат бус байдлын талаарх тайлангийн 1-р хэсэг – Шүүгчийн хараат бус байдалын тухай бүлэг).

⁵⁴ Өмнө иш татсан 38-р зүүлт, 5-р хуудсыг үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

ялгавартай цалин хөлс авах нь зохимжгүй учир.⁵⁵ Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний түвшинг улс ороны нийгмийн нөхцөл байдлыг харгалзан тогтоох ёстой бөгөөд төрийн дээд албан тушаалтнуудын цалингийн түвшинтэй харьцуулж, объектив болон ил тод шалгуур дээр үндэслэж тогтоох ёстой болно.⁵⁶ Мөн шүүгчийн цалинг бодит бууралтаас хамгаалахын тулд амьжиргааны өртөгтөй харьцуулан цалин хөлсийг нэмэгдүүлэх явдлыг хангах механизмыг авч үзэх нь зүйтэй.⁵⁷ **Эдгээр баталгаа болон шалгууруудыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд тусгах нь зохимжтой болно.**

3.4. Бусад тайлбар

37. Шүүхийн тухай хуулийн 3.1.2-р зүйлд “*дагнасан шүүх гэж эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг хэлнэ*” гэж тодорхойлсон байдаг. Мөн хуулийн 22.3-р зүйлд анхан шатны шүүх тодорхой хэрэг, маргааны төрлөөр насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн, гэр бүлийн, хөдөлмөрийн маргааны зэрэг танхимтай байж болно гэж заажээ. Дээрх танхимыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн санал болгосноор Улсын дээд шүүх тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн байгуулна (22.4-р зүйл). Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын саяхан гаргасан зөвлөмжүүдийн талаар энд дурдах нь зүйтэй байх. Эдгээр зөвлөмжүүдэд насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн⁵⁸ туршлагатай шүүгч нараас бүрдсэн дагнасан шүүх байгуулах, мөн авлига, луйврын хэцүү механизмыг ойлгох болон мөрдөн шалгах орчин үеийн аргуудыг эзэмших шаардлагаас⁵⁹ гадна салбар хоорондын мэдлэгийн хэрэгцээ байгаа тул авлигын хэргээр дагнасан шүүгчдийг/шүүхийг байгуулах саналууд тус тус орсон байна. **Монгол Улсын төрийн бодлого болон хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид иймэрхүү дагнасан шүүх хэрхэн байгуулах талаар сайн судлахыг зөвлөж байна. Нөгөөтэйгүүр насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчины үндэс суурийг боловсруулах болон авлигалтай тэмцэх илүү сайн бодлоготой хууль эрх зүйн орчинг цоглох шаардлага тулгарч магадгүй юм. Бас нэг хувилбар нь илүү уян хатан байдлыг**

⁵⁵ [ЕШЗЗ-ийн Шүүхийн санхүүжилт, захиргааны тухай 1 дэх санал](#), 62-р зүйл, болон өмнө иш татсан 5-р хуудсыг үзнэ үү (Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Сүлжээний 2015-2016 оны Шүүхийн санхүүжилтийн тухай тайлан).

⁵⁶ Өмнө иш татсан 26-р зүйлийг харна уу. [2010 оны Венецийн Комиссын Шүүхийн хараат бус байдлын талаарх тайлангийн 1-р хэсэг – Шүүгчийн хараат бус байдлын тухай бүлгийн](#), 46-р зүйл.

⁵⁷ Өмнө иш татсан 55-р зүйлт, 62-р зүйлийг харна уу. (ЕШЗЗ-ийн Шүүхийн санхүүжилт, захиргааны тухай 1 дэх санал (2001)).

⁵⁸ [НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын 5-р тайланд өгсөн зөвлөмжийн](#), 43/а/ зүйлийг, 2017 оны 7-р сарын 12; [НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын 4-р тайланд өгсөн зөвлөмж](#), CRC/C/MNG/CO/3-4, March 2010, 76 зүйлийг; [НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг хорооны Монгол улсын 2-р тайланд өгсөн зөвлөмжийн](#), 23-34-р зүйлийг тус тус харна уу. 2016 оны 9-р сарын 5.

⁵⁹ Өмнө иш татсан 5-р зүйлт, (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан) 120-р хуудас харна уу.

хангах зорилгоор одоо байгаа шүүхийн тогтолцооны хүрээнд дагнасан шүүгчдээс бүрдсэн мэргэшсэн зөвлөл буюу коллеги байгуулах асуудлыг авч үзэж болох юм.⁶⁰

38. Шүүхийн тухай хуулийн 11.3-р зүйлд “Улсын Дээд Шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл Засгийн газартай зөвшилцөн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна. Үүнтэй ижил заалтыг Шүүхийн захиргааны тухай хуулийн 6.1.4-р зүйлд мөн тусгасан байна.
39. Эцэст нь, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын буюу Ерөнхийлөгч болон Засгийн газрын гарт байгаа эдгээр эрх мэдлүүд нь шүүх тогтолцооны удирдлага болон улсын төсвийг захиран зарцуулах үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болж байгаа юм. Харин шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах эсвэл татан буулгах эцсийн шийдвэрийг хууль баталж парламент гаргадаг (Шүүхийн тухай хуулийн 11.1-р зүйл). Тус санал дүгнэлтийн 20-р зүйлд дурдсанаар хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын гарт шүүх эрх мэдлийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулах хэт их эрх мэдлийг байлгах нь шүүх засаглалын бие даасан, хараат бус байдлыг алдагдуулж болох талтай.⁶¹ Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүхийн тогтолцоог өөрчлөх тухай саналаа Засгийн газартай зөвшилцсөний дараа, Ерөнхийлөгчид танилцуулснаар цааш нь УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьдаг байна. Улсын төсвийг боловсруулагч болох Засгийн газартай зөвшилцөх мөн төсвийг баталдаг байгууллага болох УИХ-аар төсвөө батлуулах нь төсвийн үр дагварыг харгалзан зөвтгөж болох процедур боловч энэхүү тогтоолоцоо нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүхийн бүтцийн асуудлаар шийдвэр гаргах бие даасан байдлыг нь бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд эл явцад Ерөнхийлөгчийн оролцоо төдийлөн зохимжгүй байна. Энэ заалтыг Ерөнхийлөгчид шүүх засаглалд шийдвэрлэх үүрэг олгоно гэж ойлгож болохгүй. Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь саналаа Засгийн газартай зөвшилцсөний дараа шууд УИХ-д хэлэлцүүлэхээр өргөн барьж болно.

4. Шүүхийн захиргаа ба бие даасан байдал

4.1. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үүрэг

40. Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн Ерөнхий Зөвлөл ажиллана” гэж заажээ. Мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Ерөнхий зөвлөл “шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлэх” аж. Үндсэн хуульд шүүхийн зөвлөлүүдийн талаархи заалтуудыг оруулахыг

⁶⁰ Жишээ болгон Молдав улсын Шүүхийн захиргааны тухай хуулийн 15/2/-рт дагнасан шүүх эсвэл одоо байгаа шүүхийн тогтолцооны хүрээнд дагнасан шүүгчдээс бүрдсэн мэргэшсэн зөвлөл буюу коллеги байгуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан байдаг тул харна уу.

⁶¹ Өмнө иш татсан 22-р зүүлт, 26-р зүйлийг харна уу. (НҮБ-ын МБГХТА-ны Бангалорын зарчимуудын тайлбар).

олон улсын түвшинд зөвлөдөг⁶² ба энэхүү арга барицыг Монгол Улс дагаж мөрдөж байгаа нь сайшаалтай юм. Учир нь ийнхүү Ерөнхий зөвлөл гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байх баталгаагаар хангагдаж буй юм. Үүний зэрэгцээ, бие даасан байдлаа цаашид нэмэгдүүлэх, эрх зүйн байдлаа хамгаалахын тулд **тус байгууллага, түүний бүрэлдэхүүн** (мөн 4.2-р дэд хэсэгт энэ талаарх тайлбарыг үзнэ үү), **чиг үүрэг, бүрэн эрх, гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын эрх мэдлийн байгууллагаас бие даасан байдлыг хангасан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид бус харин Үндсэн хуульд тусгах асуудлыг хуулт эрх зүйн баримт болосвруулагчидад зөвлөж байна.**⁶³

41. Шүүхийн захиргааны тухай хуульд Ерөнхий зөвлөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл тусгагдсан байна. Тус хуулийн 3.1-р зүйлд “*шүүхийн захиргаа нь Шүүхийн Ерөнхий Зөвлөл, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв болон бусад туслах нэгжээс бүрдэнэ*” хэмээн заагдсан байна. 3.2-р зүйлд “*шүүхийн захиргаа*”-ны үндсэн чиг үүрэг дурдагдсан байна. Шүүхийн захиргааны тухай хуулийн Хоёрдугаар бүлэгт шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах талаар (6-р дугаар зүйл), шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах талаар (7-р дугаар зүйл), шүүгчийг шилж олох талаар (8-р дугаар зүйл), шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар (9-р дүгээр зүйл) ба шүүхийн хүний нөөцийн удирдлага (10-р дугаар зүйл) зэрэг таван чиглэлээрх Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх тусгагдсан байна.
42. Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах, сурталчлах үүрэг бүхий бие даасан байгууллага байгуулах нь сайн туршлага гэж олон улсын түвшинд үздэг,⁶⁴ нэн ялангуяа засаглалын бусад хэлбэр болон гадны оролцогчдын шахалтаас урьдчилан сэргийлэхэд.⁶⁵ Ийнхүү нөхцөлд шүүхийн хариуцлагыг хангахын зэрэгцээ бие даасан байдлаа хадгалж, сайн үйл ажиллагаа явуулдаг шүүхийн зөвлөлүүдийг байгуулах нь хууль дээдлэх засаглалыг баримталж буй орнуудад чухал ач холбогдолтой юм.⁶⁶ Аливаа улс оронд шүүхийн хараат бус байдлыг дэмжиж, хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул ийм зөвлөлүүд өөрсдөө хараат бус, шударга байх ёстой буюу гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас ангид байх ёстой юм.⁶⁷ Тиймээс Шүүгчийн

⁶² Жишээ болгон *өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 41 дүгээр догол мөр (Шүүхийн зөвлөлийн тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2018 оны тайлан); ба *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 13 дугаар догол мөр (Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн Шүүхийн зөвлөлийн тухай Санал дүгнэлт №10 (2007)) харна уу.

⁶³ Өмнө иш татсан 42-р зүйлийг үзнэ үү. (Шүүхийн зөвлөлийн тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2018 оны тайлан).

⁶⁴ Өмнө нь иш татсан 39-р зүүлт, 91 дүгээр догол мөр (Шүүхийн зөвлөлийн тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн 2018 оны тайлан)-г харна уу. Мөн жишээ болгон Венецийн Комисс, [Шүүхийн зөвлөл болон шүүгчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн Санал дүгнэлт](#) (Монтенегро), CDL-Ad(2018)015, 37 дугаар догол мөрийг харна уу.

⁶⁵ Жишээ болгон Венецийн Комисс, [Шүүгчийн томилооны тухай тайлан](#) (2007), CDL-AD(2007)028-e, 2007 оны 6 дугаар сарын 22, 48 дугаар догол мөрийг харна уу.

⁶⁶ Жишээ болгон АИХЭГ, [Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн Дээд Зөвлөлийн тухай хуульд өгсөн Санал дүгнэлт](#) (2018 оны 10 дугаар сарын 01), 14 дүгээр догол мөрийг харна уу.

⁶⁷ Жишээ болгон АИХЭГ, [Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлт болон зарим бусад хуульд өгсөн эцэслэгдсэн Санал дүгнэлт](#) (2017 оны 5 дугаар сарын 05), 37 дугаар догол мөрийг харна уу. Мөн 14 дүгээр догол мөр; ба *өмнө нь иш татсан* 12-р зүүлт, Удиртгал (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд 2002), “шүүгчийн хэм хэмжээг сахиулах зорилго бүхий байгуулагдсан бие даасан, хараат бус холбогдох байгууллагуудын өмнө шүүгч өөрийн зан байдлын асуудлаар хариуцлага хүлээнэ” гэж заасныг харна уу.

ерөнхий зөвлөл байгуулах сонголт нь шүүх засаглал, бие даасан шүүгчдийн хараат бус байдлыг хамгаалж, шүүхийн байгууллагын үр өгөөжтэй үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий бие даасан шүүхийн зөвлөл байгуулсан олон орны практикт нийцэж байгаа юм.⁶⁸

43. Ерөнхийдөө Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиг үүргийн хүрээнд зөвхөн шүүхийн хараат бус байдлыг хамгаалахтай холбоотой төдийгүй мөн аж ахуйн зохион байгуулалтаас эхлэн (материал, техник хангамж, шүүхийн тоног төхөөрөмж, 6.1.2-р зүйл), шүүхийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх (6.1.7-р зүйл), шүүхийн барилга байгууламж барих, засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх (6.1.9-р зүйл), шүүхийн тамгын газрын даргын ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлэх (7.1-р зүйл), шүүхийн санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн албыг зохион байгуулж, хянан шалгаж удирдах (7.1.14-р зүйл), шүүхийн тээвэр, холбоо, мэдээлэл шинжилгээ, программ хангамж болон шүүхийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах (7.1.16 ба 7.1.17-р зүйл), шүүхийг тоног төхөөрөмж, засвар, үйлчилгээгээр хангах (7.1.18-р зүйл) зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Эдгээр бүх чиг үүргийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл гүйцэтгэх ёстой эсэх нь эргэлзээтэй юм. Орон нутгийн шүүхүүдийн захиргааны болон аж ахуйн зохион байгуулалтын чанартай бүх чиг үүргийг бүрэн хянах нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн зүгээс зохисгүй байдлаар оролцох эсвэл ялгавартай хандлагад хүргэж болзошгүй бөгөөд энэ нь шүүхийн бие даасан байдлыг алдагдуулж болзошгүй юм. Шүүхийн Ерөнхий Зөвлөлд бус харин орон нутгийн шүүхийн Тамгын газрын даргад захирагдах шүүхийн менежерүүд эдгээр чиг үүргийг хэрэгжүүлвэл илүү үр дүнтэй байж болзошгүй юм. **Орон нутгийн засаг захиргааны түвшинд захиргааны удирдлагын болон аж ахуйн зохион байгуулалтын асуудалд илүү үр дүнтэй хяналт тавих зорилгоор, нэн ялангуяа урьд өмнө энэ нь бэрхшээл үүсгэж байсан тохиолдолд, Шүүхийн Ерөнхий Зөвлөл ба доод шатны шүүх хоорондын чиг үүргийн хуваарилалтыг дахин хянах шаардлагатай эсэхийг хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид хэлэлцэх нь зүйтэй болно.**
44. Бусдаар бол Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрх нь бүс нутгийн хэмжээнд гарсан зөвлөмжүүдтэй ер нь нийцэж байна.⁶⁹ Үүний зэрэгцээ, зарим заалтуудад нэмэлт тодруулга эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй юм (шүүгчийн томилгоо, сахилга, ёс зүйн талаарх бусад дэд хэсгүүд дэх нэмэлт тайлбарыг үзнэ үү). Түүнчлэн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үндсэн чиг үүргүүдийн хүрээнд нэмэлтээр оруулж болох зарим нэмэлт чухал асуудлууд байна.

⁶⁸ Жишээ болгон өмнө нь иш татсан 24-р зүүлт, 26-29 дого мөр (Европын Зөвлөлийн Зөвлөмжүүд CM/Rec(2010)12)); [ЕШЗЗ-ийн Нийгэмд үйлчлэх Шүүхий зөвлөлийн талаарх Санал дүгнэлт №10](#) (2007); өмнө нь иш татсан 26-р зүүлд, 28-32 догол мөр (Венецийн Комиссын Шүүхийн тогтолцооны бие даасан байдлын тухай тайлан – Нэгдүгээр хэсэг: Шүүгчийн бие даасан байдал (2010)) зэргийг харна уу.

⁶⁹ Нэн ялангуяа, [ЕШЗЗ-ийн Нийгэмд үйлчлэх Шүүхий зөвлөлийн талаарх Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, 42 дугаар догол мөрийг харна уу.

45. Ялангуяа, Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21.в дахь заалтад зааснаар хэргийн хөдөлгөөнийг судалж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл болон дараах үе шат тус бүрд зарцуулагдах хугацааны нэгдсэн стандартыг баталж мөрдүүлэхээр заасан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл үе шатуудын үргэлжлэх хугацаа тодорхой хэргийн нарийн төвөгтэй байдал, гол агуулга зэрэг олон хүчин зүйлээс хамаарах тул түүнийг төвлөрсөн байдлаар тогтооно гэдэг бараг боломжгүй юм. Дээрх хуулийн **7-р зүйлийн 7.1.21.в дахь заалтын үр дагвар нь шүүхийн хараат бус байдлыг ноцтой зөрчиж болзошгүй тул үүнийг бүхэлд нь дахин авч үзэх шаардлагатай юм.** Ерөнхий зөвлөл нь бүх шатны шүүхүүдийн төсвийг ерөнхийлөн захирах эрхтэй (18-р зүйлийн 18.1.7 дахь заалт) бөгөөд энэ нь шүүхүүдийн үйл ажиллагаа, удирдлагад зохисгүй нөлөөлөл үзүүлэх, улмаар тэдний хараат бус байдлыг алдагдуулах эрсдэлтэй юм. **Ийм эрх мэдлийн асуудлыг бүхэлд нь дахин авч үзэх шаардлагатай юм.** Түүнчлэн, Ерөнхий зөвлөлийн зүгээс түүнд үйл ажиллагаагаа тайлагнадаг бүх шатны шүүхийн тамгын газарт хяналт тавих нь (Шүүхийн захиргааны тухай хуулийн 4 дүгээр бүлгийг үзнэ үү) шүүхийн удирдлагад хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлж өгөх магадлалтай ба энэ нь мөн л бэрхшээлийг дагуулж буй юм. **Харин шүүхийн тамгын газрын дарга нар үйл ажиллагаагаа Ерөнхий шүүгчийн өмнө хариуцан тайлагнах, улмаар холбогдох нэмэлт өөрчлөлтийг Шүүхийн захиргааны тухай хуулийн 4 дүгээр бүлэгт, тэр дундаа 22-р зүйлд оруулахын зэрэгцээ шүүхүүдийн тамгын газрын үйл ажиллагаанд Ерөнхий зөвлөлийн зүгээс хяналт тавих тухай аливаа заалтыг хасах нь зохимжтой гэж үзнэ.**
46. Олон улсын хүний эрхийн мониторингийн байгууллагуудын тэмдэглэснээр мөн бодит байдал дээр зарим хүмүүс, эсвэл нийгмийн бүлгүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд болон нийгмийн бусад цөөнхийн бүлгүүдэд Монголд зарим үед шударга ёс хүртээмжтэй байдаг эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Ялангуяа, хуулийн байгууллагын ажилтнууд, цагдаа, хорих байгууллагын ажилтнууд зохих мэдлэггүй, сургалтанд хамрагдаагүй зэргээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн байдал болон хэлний бэрхшээл (дохионы хэл эсвэл Брайлийн шрифтээр бичих шаардлагатай бол), мөн онцгой анхаарал хандуулах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг⁷⁰ ялгаварлан гадуурхахгүй байх арга хэмжээг багтаасан процедурын дасан зохицох зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн арга хэмжээ авахыг Монгол Улсад зөвлөсөн байна. Эдгээр байгууллагууд нь нэн ялангуяа үндэстний цөөнх, уугуул иргэд, цагаач, дүрвэгсдийн зүгээс арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, хөдөлмөрийн хүчирхийллийн⁷¹ талаар гомдол гаргахад хууль эрх зүйн арга хэрэгслийн хүртээмжтэй байдалд, эсвэл илүү ерөнхийлвөл бэлгийн чиг хандлага, хүйсээр ялгаварлан гадуурхах⁷², эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд эрүүгийн хариуцлага тооцох хууль

⁷⁰ [НУБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхны илтгэлд өгсөн дүгнэлт](#), 2015 оны 05 дугаар сарын 13, 23 дугаар догол мөр.

⁷¹ [НУБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, Монгол Улсын 23, 24 дүгээр нэгтгэсэн тайланд хийсэн үнэлгээний дүгнэлт](#), 2019 оны 9 дүгээр сарын 17, 28 дугаар догол мөр.

⁷² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, [Монгол Улсын 6 дугаар тайланд хийсэн дүгнэлт](#), 2017 оны 8 дугаар сарын 22, 11-12 догол мөрийг харна уу.

тогтоомжууд болон хүчирхийллийн золиос болсон эмэгтэйчүүд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй харьцах жендэрийн мэдрэмжтэй процедуруудыг чанд сахин мөрдөх талаарх шүүгч, прокурор, цагдаагийн ажилтнууд болон хууль сахиулах байгууллагын бусад ажилтнуудын чадавх дутагдалтай буйд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна.⁷³ Тиймээс Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйльд дээр дурдсан зөвлөмжийн дагуу бүх хүмүүст шударга ёсны хүртээмжийг хангах талаар зохих арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэх, шүүгч, шүүхийн ажилтнуудад зохих сургалт зохион байгуулах зэрэг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн чиг үүрэгт, дээр дурдсан зөвлөмжүүдийн хүрээнд тодорхой үүрэг нэмж оруулахыг зөвлөж байна. Түүнчлэн процессын хууль тогтоомжуудыг нарийвчлан судлаж, жендэрийн -, хүүхдийн-, нийгмийн олон янз байдалд-мэдрэмжтэй, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог зэргийг хамарсан арга хэмжээнүүдийг⁷⁴ тусгахыг судлах нь зохистой болно.

47. Эцэст нь хэлэхэд Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчдийг сонгон шалгаруулах гол чиг үүргийнхээ хүрээнд бүх шатны шүүх, тэр дундаа дээд шатны шүүхийн түвшинд жендэрийн болон нийгмийн төлөөллийн олон талт байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санаачилга, бодлого боловсруулахад гол үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой юм.⁷⁵ Үүнийг Шүүхийн захиргааны тухай хуулийн хоёрдугаар бүлэгт мөн тусгаж болно. Үүнтэй холбогдуулан АИХЭГ-аас саяхан гаргасан Жендэр, Нийгмийн олон талт байдал, Шударга ёс (2019) нийтлэл дэх зөвлөмжүүд нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлд лавлагаа материал болох боломжтой юм. Энэ нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах асуудлаарх НҮБ-ын хорооны Монгол дах нөхцөл байдлын талаарх саяхан гаргасан тайланд улс төрийн болон нийгмийн

⁷³ НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалтыг устгах хороо, [Монгол Улсын 8, 9 дүгээр нэгтгэсэн тайланд хийсэн үнэлгээний дүгнэлт](#), 2016 оны 3 дугаар сарын 10, 19 (b) дүгээр догол мөр. Мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо, [Монгол Улсын 4 дүгээр тайланд хийсэн дүгнэлт](#), 2015 оны 7 дугаар сарын 07, 21 дүгээр догол мөрийг харна уу.

⁷⁴ Жендэрийн асуудлаарх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар *өмнө нь иш татсан* 44-р зүүлт, 15 дугаар догол мөр (НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн шударга ёсны чиглэлээр Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох талаархи шинэчилсэн загвар стратеги ба практик арга хэмжээ (2011))- харна уу. Мөн, жишээлбэл, [БНКиргиз Улсын Эрүүгийн процессын тухай хуулийн төсөлд өгсөн АИХЭГ-ын дүгнэлтийн](#), 4-р хэсгийг (2015 оны 6 дугаар сарын 19) үзнэ үү. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зохих байдлаар явуулахад шаардагдахаас бусад тохиолдолд, ажиллагааны бүх үе шатанд гэмт хэрэгтэн, хохирогч хоёрын хоорондох холбоо харилцаа тогтоох, түүнчлэн цагдаагийн байгууллагын байранд мөрдөн байцаах ажиллагаа явуулахаас зайлсхийх; хохирогчид дэмжлэг үзүүлэх зорилгоор өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчөөс гадна сэтгэлзүйч эсвэл мэргэжлийн бусад хүмүүс зэрэг гуравдагч этгээдийг байлцуулах; хохирогч өөрөөр хүсээгүй бол ижил хүйсийн байцагч ярилцлага/байцаалт авах; хохирогч, гэрч болсон хүүхдүүдээс ярилцлага авах бүрт видео төхөөрөмж ашиглах; эрх чөлөөг хязгаарлахтай холбоогүй болон квази-хорих ял оноох, батлан даалтаар гаргах, хугацаатайгаар суллах, хугацаанаас нь өмнө батлан даалтад гаргах, тэнсэн харгалзахтай холбоотой шийдвэр гаргахдаа, ялангуяа давтан болон аюултай гэмт хэрэгтнүүдтэй харьцахдаа аюулгүй байдлын эрсдлийг, түүний дотор хохирогчдын эмзэг байдлыг харгалзах; яллагдагч/ялтан нь суллагдах эсвэл оргон зайлах үед хохирогчдод мэдэгдэх үүрэг хүлээх; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг суллахтай холбогдсон шийдвэр гаргахдаа хохирогчийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийг харгалзах; хохирогч болон гэрч шүүх хуралдааны бусад оролцогчдод харагдалгүйгээр, жишээлбэл видео дамжуулалтаар гэрчийн мэдүүлэг өгөх боломж бололцоо; гэр бүлийн хүчирхийллийн хэргийг харилцан тохиролцох/зохицох журмаас хасах; нууцлал болон хувийн нууцтай холбогдох төрөл бүрийн арга хэмжээ; ба ерөнхийдөө хохирогчдод чиг лэсэн хандлага, эрүүгийн шүүхийн процессын бүх үе шатанд хохирогчдод тэдгээрийн эрхийн талаар мэдээлэх үүрэг зэргийг агуулах нь зүйтэй.

⁷⁵ Жишээ болгон АИХЭГ, [Гүрж Улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилохтой холбоотой нэмэлт өөрчлөлтийн төсөлд хийсэн санал дүгнэлт](#), 2019 оны 4 дүгээр сарын 17, 49 дүгээр догол мөрийг харна уу. Мөн АИХЭГ, [Жендэр, Цөөнхийн бүлэг ба Шударга ёс](#) (2019), 22-27 дугаар хуудсыг харна уу.

амьдралд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд⁷⁶ эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байгаа талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн асуудлыг харгалзан авч үзэхийг, болон энэ чиглэлээр сургалт хийх, боловсон хүчин бүрдүүлэхдээ жендэрийн мэдрэмжтэй байх мөн түр хугацааны тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэгээр зорилтот арга хэмжээнүүдийг авахыг тус тус зөвлөсөн байна.⁷⁷ Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид ба/эсвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь дээр дурдсан зорилтот арга хэмжээнүүдийг өөрийн хууль тогтоомжинд буулгах талаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзнэ.

4.2. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийг нэр дэвшүүлэх/ сонгох болон хугацаанаас нь өмнө чөлөөлөх журам

4.2.1. Бүрэлдэхүүн

48. Ерөнхий зөвлөл нь таван гишүүнээс бүрдэх бөгөөд 3 гишүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс, мөн Хуульчдын холбооноос нэг, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас нэг хүнийг тус тус нэр дэвшүүлэн томилдог байна (Шүүхийн захиргааны тухай хуулийн 13.1-р зүйл). Мөн заалтад эдгээр таван гишүүнийг “Монгол Улсын Ерөнхийлөгч томилно” гэж заасан байна. **Ерөнхий зөвлөлийн ажлын тасралтгүй байдлыг хангахын тулд зөвлөлийн гишүүд зөрчил гаргасан тохиолдолд тэдгээрийг орлож болох өөр гишүүдийг томилох асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзнэ.**
49. Шүүхийн захиргааны тухай хуулийн 16-р зүйлд Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг илүү нарийвчлан заасан байна. Тухайлбал, Монгол Улсын иргэн байх, хууль зүйн дээд боловсролтой байх, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх (Ерөнхий зөвлөлийн даргын хувьд мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх), ял шийтгүүлж байгаагүй, шударга зан чанар, өндөр ёс зүйтэй, шүүгчид нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг аливаа нөлөөнд үл автан бодитой үнэлэх чадавхтай байх зэрэг. Түүнчлэн Ерөнхий зөвлөлийн даргын хувьд удирдах ажлын дадлага, туршлагатай байх шаардлагыг хангасан байх ёстой гэсэн байна. **Гэхдээ шаардагдах удирдах ажлын туршлагын хугацааг нь тодорхой зааж өгөх нь зүйтэй гэж үзнэ.**
50. Нэгдүгээрт, хэрэв орчуулгын зөрүү гараагүй бол, шүүгчдийн зөвлөгөөнөөр сонгогдсон хүмүүс тухайн шатны шүүхийн шүүгч байх ёстой эсэхийг хуульд тодорхой заагаагүй байна. Шүүхийн хараат бус байдлыг хангах үүднээс олон улсын болон бүс нутгийн жишгийн дагуу шүүгчдийн сонгон шалгаруулалт, ажилд авах, томилох, үнэлэх, бүрэн эрхийг нь дуусгавар болгохтой холбоотой бүхий л шийдвэрийг гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байгууллага гаргадаг. Хөндлөнгийн зохисгүй

⁷⁶ Өмнө нь иш татсан 73-р зүүлт, 22 дугаар догол мөр (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, Монгол Улсын талаар ажишлалтын дүгнэлт (2016)).

⁷⁷ 23 (b) дугаар догол мөр (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, Монгол Улсын талаар ажишлалтын дүгнэлт (2016)).

нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд⁷⁸ тус байгууллагын бүрэлдэхүүний олонхи буюу талаас доошгүй гишүүн нь шүүгчид дундаасаа сонгогдсон шүүгч нар байдаг. Энэ нь монгол хэл дээрх найруулганд шууд ойлгогдохуйц биш байгаа тохиолдолд, **шүүгчдийн зөвлөгөөнөөс санал болгодог гурван гишүүн нь холбогдох шатны шүүхийн шүүгч нар байх шаардлагыг Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлд тодорхой зааж өгөхийг зөвлөж байна.**

51. Шүүгчдийн зөвлөгөөнөөр сонгож, санал болгосон гишүүдийн тооны тухайд 13 дугаар зүйл нь тухайн санал болгосон гишүүд тус бүр өөрийн шүүхийн шатны төлөөлөл гэсэн санааг илэрхийлсэн бололтой. Бүх шатанд шүүхийн шүүгчдийн өргөн төлөөллийг хангахыг зөвлөдөг болно.⁷⁹ АИХЭГ-ын зүгээс бүх шатны шүүх, шүүх эрх мэдлийн бусад байгууллагын хооронд тодорхой тэнцвэрт байдлыг хадгалахыг өмнө мөн зөвлөж байсан.⁸⁰ **Хуулийн эрх зүйн баримт бичиг боловсруулагчид бүх шатны шүүхийн шүүгчдийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд шүүгчдийн тоог тэнцвэртэй хуваарилах асуудлыг авч үзэх нь зүйтэй байж болох бөгөөд энэ нь яваандаа Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлэх шаардлагад хүргэж болох юм.**
52. Түүнчлэн Шүүхийн захиргааны тухай хуулийн 13-р зүйлийн дагуу Хуульчдын холбоо эсвэл Хууль зүй, дотоод хэргийн яамнаас нэр дэвшүүлсэн гишүүд нар нь тус хуулийн 16-р зүйлд дурдсан мэргэшлийн шаардлагыг хангасан байх, үүний дотор хууль зүйн дээд боловсролтой байх (16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалт) зэргээс гадна хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсвэл Хуульчдын холбооны гишүүнчлэлтэй, хууль зүйн профессор, иргэний нийгмийн төлөөлөл эсвэл бусад хүмүүс байх ёстой эсэх нь тодорхойгүй байна. **Үүнийг тодруулах нь зүйтэй юм.**
53. *АИХЭГ-ын 2010 оны Киевын зөвлөмжид "Шүүхийн зөвлөлийн нээлттэй, ил тод байдлыг хангах үүднээс зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх нь шүүгчдээс сонгогдсон гишүүд байхаас гадна тодорхой хэсэг нь хууль зүйн профессор болон Хуульчдын холбооны гишүүдээс бүрдэх нь зүйтэй"*⁸¹ хэмээн тусгасан байдаг. **Иймд Шүүхийн**

⁷⁸ Өмнө нь иш татсан 18-р зүүлт, 30 дугаар догол мөр (АИХЭГ, Киевын зөвлөмжүүд (2010)); ба өмнө нь иш татсан 32-р зүүлт, 132 дугаар догол мөр (АИХЭГ, Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу. Мөн Европын түвшинд харьцуулах зорилгоор: өмнө нь иш татсан 19-р зүүлт, 1.3 дахь догол мөр (1998 оны Европын дүрэм); өмнө нь иш татсан 26-р зүүлт, 50 дугаар догол мөр (Венецийн Комиссын Шүүхийн тогтолцооны бие даасан байдлын тухай 2010 оны тайлан), үүнд "Шүүхийн зөвлөлийн чухал бүрэлдэхүүн хэсгийг эсвэл гишүүдийн олонхийг Шүүх өөрөө сонгох ёстой" гэж заасан; өмнө нь иш татсан 27-р зүүлт, 27 дугаар догол мөр (Европын зөвлөлийн 2010 оны Зөвлөмж CM/Res (2010) 12), үүнд "ийм зөвлөлийн гишүүдийн талаас багагүй хувь нь шүүгчид дундаасаа сонгогдсон шүүгчид байх ёстой" хэмээн заасан; өмнө нь иш татсан 34-р зүүлт, 17-18, 25 дугаар догол мөр (ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)), үүнд "холимог бүрэлдэхүүнтэй (шүүгч ба шүүгч бус) байх тохиолдолд ЕШЗ3 нь аливаа хууран мэхлэлт, эсвэл дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх үүднээс гишүүдийн зонхилох олонхийг нь шүүгчид дундаасаа сонгогдсон шүүгчид бүрдүүлэх ёстой" хэмээн заасныг харна уу.

⁷⁹ Жишээ болгон өмнө нь иш татсан 39-р зүүлт, 107 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)); өмнө нь иш татсан 34-р зүүлт, 27 дугаар догол мөр (ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)), үүнд "Шүүхийн зөвлөлийн гишүүд болох шүүгчдийг бүх шатны шүүхийн хамгийн өргөн төлөөллийг баталгаажуулах замаар шүүгчид дундаасаа сонгох ёстой" зөвлөж буй; ба өмнө нь иш татсан 18-р зүүлт, 7 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)) зэргийг харна уу.

⁸⁰ Жишээ болгон өмнө нь иш татсан 32-р зүүлт, 86-р зүүлт (АИХЭГ, Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019)); ба өмнө нь иш татсан 67-р зүүлт, 51 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)) зэргийг харна уу.

⁸¹ Өмнө нь иш татсан 18-р зүүлт, 26 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)).

захиргааны тухай хуульд Хуульчдын холбооноос сонгогдсон гишүүн нь холбооны гишүүн байх, харин тав дах гишүүн нь нээлттэй, бодит, ил тод, шударга байдлаар явуулсан сонгон шалгаруулалтын дүнд сонгогдсон хууль зүйн профессор эсвэл иргэний нийгмийн төлөөлөл байх ёстой болохыг тусгахыг зөвлөж байна.

54. Ерөнхий зөвлөлийн гишүүнийн бүрэлдэхүүнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шүүгч бус хүнийг нэр дэвшүүлэх явдлыг ер нь сайн туршлагад тооцдоггүй. Шүүгч, хуульч нарын хараат бус байдлын талаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн тэмдэглэснээр “зөвлөлийн мэргэжлийн бус гишүүдийг сонгох ажиллагааг улс төрийн бус байгууллагууд сонгох нь зүйтэй ба тэдгээрийг парламент сонгох тохиолдолд сөрөг хүчний олонхийн дэмжлэгийг авсан нэр дэвшигчийг сонгох ёстой бөгөөд ямар ч тохиолдолд гүйцэтгэх засаглалаас сонгох эсвэл томилох ёсгүй юм”⁸² гэсний сацуу “тэдгээрийг мөн хууль тогтоох дээд байгууллагаас томилохгүй байх нь илүү зохимжтой”⁸³ гэжээ. Гэвч энэ нь олон улс орнуудад хэрэгжүүлдэг практик юм. Тиймээс Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зөвлөлийн нэг гишүүнийг сонгодог асуудлыг дахин хянан үзэж,⁸⁴ нэр дэвшүүлэх үйл явцыг улс төржүүлэхээс зайлсхийхийн тулд зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, үүний сацуу хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь яг ямар байгууллага (тухайлбал, эрх зүйн тэнхим, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн байгууллага, хүний эрхийн үндэсний байгууллага г.м.) тус гишүүнийг нэр дэвшүүлж болох асуудлыг хэлэлцэх нь зүйтэй юм.
55. Түүнчлэн, дээрх хуулийн 16-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүний албан тушаалд нийцэхгүй байх нөхцлийн талаар огт дурдагдаагүй байна. Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын баталгаа болж буй байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад эрх мэдлийн засаглалын бусад байгууллагын зүгээс үзүүлэх нөлөөллөөс зайлсхийхийг эрмэлзэж, парламент эсвэл гүйцэтгэх засаглалын гишүүдийг шүүхийн зөвлөлүүдийн гишүүнээр ажиллах практикийг зүй эсэхт⁸⁵ АИХЭГ, ЕШЗЗ, Венецийн Комисс болон Шүүгч, хуульчийн хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч нар эргэлзэж буйгаа тус тус илэрхийлсэн. Иймд парламентын гишүүд ба илүү ерөнхийлвэл, идэвхтэй улс төрчид болон хууль тогтоох эсвэл гүйцэтгэх

⁸² Өмнө нь иш татсан 39-р зүүлт, 108 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

⁸³ 78 дугаар догол мөр.

⁸⁴ 108 дугаар догол мөр. Мөн өмнө нь иш татсан 34-р зүүлт, 32 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)); ба өмнө нь иш татсан 65-р зүүлт, 32 дугаар догол мөр (Венецийн Комиссын Шүүгчийн томилгооны тухай тайлан (2007))-г харна уу.

⁸⁵ Жишээ болгон өмнө нь иш татсан 67-р зүүлт, 52 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)); өмнө нь иш татсан 34-р зүүлт, 23 болон 32 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)); Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч, Шүүхийн хариуцлагын тухай тайлан, А/HRC/26/32, 2014 оны 4 дүгээр сарын 28, 93 дугаар догол мөр; ба өмнө нь иш татсан 65-р зүүлт, 32 дугаар догол мөр (Венецийн Комиссын Шүүгчийн томилгооны тухай тайлан (2007))-г харна уу.

засаглалын эрх бүхий албан тушаалтнууд⁸⁶ Ерөнхий Зөвлөлийн гишүүнээр ажиллах эрхгүй гэдгийг 16 дугаар зүйлд тодотгон зааж өгөхийг зөвлөж байна.

56. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнд жендэрийн болон нийгмийн олон янз байдлыг төлөөллийн тэнцвэрт байдлыг хангах шаардлагын талаар Шүүхийн захиргааны тухай хуульд огт тусгагдаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзнэ. Энэ нь төрийн байгууллагууд дахь,⁸⁷ тэр дундаа шүүхийн болон, нэн ялангуяа шүүхийн зөвлөлүүд дэх төрийн албан тушаалд хийгдэж буй бүх томилгоонд⁸⁸ эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэнцвэртэй байдлыг хангах шаардлага тусгагдсан олон улсын зөвлөмжтэй нийцэхгүй байна. Тиймээс хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид **Ерөнхий зөвлөлд жендэрийн болон нийгмийн олон янз байдлын төлөөллийн тэнцвэрт байдлыг хангах механизм (ууд) нэвтрүүлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй юм.**⁸⁹

4.2.2. Ерөнхий зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх/томилох

57. Шүүхийн захиргааны тухай хуулийн 13-р зүйлд шүүгчийг сонгох сонгуулийн журмын талаар тусгалгүйгээр шүүгчдийн зөвлөгөөнөөр "нэр дэвшүүлэх" тухай дурдсан байна. ЕАБХАБ-ын бүс нутагт шүүхийн гишүүдийг сонгох/томилох олон загвар буйг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ шүүхийн гишүүдийг шүүгч нар дундаас "сонгохыг" нийтлэг байдлаар зөвлөдөг.⁹⁰ [АИХЭГ-ын 2010 оны Киевын зөвлөмж](#) нь **шүүхийн гишүүдийн "сонгууль"-тай**⁹¹ холбоотой болно. Иймд шүүгчийг сонгох явцын бодит, шударга, ил тод, хүртээмжтэй байдлыг хангах зорилго бүхий⁹² сонгон шалгаруулалтын журмыг **Шүүхийн захиргааны тухай хуульд тусгахыг зөвлөж байна.** Зарим улс оронд шууд

⁸⁶ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 107 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

⁸⁷ Европын зөвлөлийн түвшинд энэ нь улс төрийн болон олон нийтийн амьдралд аливаа шийдвэр гаргах байгууллага дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төлөөлөл 40% -наас доош байх ёсгүй гэсэн үг юм; 2003 оны 3-р сарын 12-ны өдрийн [Улс төрийн болон олон нийтийн шийдвэр гаргахад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэнцвэртэй оролцооны тухай Сайд нарын хорооны Res \(2003\)3-р зөвлөмжийн Хавсралтын Удиртгал](#) болон 9-10 дугаар догол мөрийг үзнэ үү. Мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблей нь 66/130 дугаар тогтоолдоо "эмэгтэйчүүдийг засгийн газрынхаа бүх түвшин дэх албан тушаалд, тэр дундаа боломжтой тохиолдолд үндсэн хуулийн, сонгуулийн, улс төрийн болон институцийн шинэчлэлийг хариуцах байгууллагуудад томилохыг" улс орнуудад уриалж байна; Ерөнхий Ассемблейн 2012 оны 3-р сарын 19-ний өдөр баталсан [66/130 дугаар тогтоолын](#) 8 дугаар догол мөрийг үзнэ үү.

⁸⁸ *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 110 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)); *өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 51 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)); ба *өмнө нь иш татсан* 32-р зүүлт, 132 дугаар догол мөр and *op. cit.* footnote 32, par 132 (АИХЭГ-ын Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу. Мөн АИХЭГ, [Жендэр, Цөөнхийн бүлэг ба Шударга ёс](#) (2019), 3 дугаар зөвлөмж; ба *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 24 дүгээр догол мөр (ЕШЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)), үүнд "Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгэм дэх цөөнхийн төлөөллийг аль болох оролцуулах нь зүйтэй" хэмээ заасныг харна уу.

⁸⁹ Жишээ болгон БНКиригиз Улсын Шүүхийн зөвлөлийн дэргэдэх Сахилгын комиссын бүрэлдэхүүнд жендэрийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр санал болгосон арга хэмжээнүүдийн талаар АИХЭГ, Венецийн Комиссоос гаргасан зөвлөмжүүдийн дагуу үүнийг боловсруулж болно. ([БНКиригиз Улсын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хууль тогтоомжид оруулан нэмэлт, өөрчлөлтүүдэд өгсөн ЕАБХАБ/АИХЭГ-Венецийн Комиссын](#), 2014 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хамтарсан Санал дүгнэлтийн 5.1 дэх дэд хэсгийн харна уу). Мөн жишээ болгон Шударга ёсны үр дүнтэй байдлын асуудлаарх Европын комисс (СЕРЕЈ), [Европын шүүхийн тогтолцооны тайлан - Шударга ёсны үр дүнтэй байдал ба чанар](#), СЕРЕЈ судалгаа №23, 2016 оны хэвлэл, (2014 оны өгөгдөл), 101 дүгээр хуудсыг үзнэ үү.

⁹⁰ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 43 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)), үүнд ийм зөвлөлтэй ЕХ-ны дийлэнх орнуудад шүүх бүрэлдэхүүнийг "шүүгчид дундаасаа сонгодог эсвэл шүүгчид өөрсдөө томилдог эсвэл санал болгодог" гэж заасныг харна уу

⁹¹ *Өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 30 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)).

⁹² *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 75 болон 109 дүгээр догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

болон шууд бус сонгууль явуулахдаа нууц саналын хуудсыг⁹³ ашигладаг явдал нь тухайн албан тушаалд нэр дэвшиж буй бүх нэр дэвшигчдэд илүү шударга хандах боломжийг бүрдүүлэхийн сацуу сонгуулийн үйл явцад үзүүлж болох хөндлөнгийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэгийг тэмдэглэх нь зүйтэй юм.⁹⁴ **Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид үүнийг харгалзаж үзэх нь зүйтэй гэж үзнэ.**

58. Ямарч тохиолдолд улс төрийн нөлөөлөлд автах эрсдлийг арилгах, корпоративизмд буруутгагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс **шүүхийн эрх мэдлийн байгууллага түс бүр сонгон шалгаруулалтын явцын нээлттэй, хүртээмжтэй, ил тод байдлыг хангахын сацуу нэр дэвшүүлэх/томилох журам, нөхцөлийг нарийвчлан боловсруулах нь шаардлагатай гэж үзнэ.**⁹⁵
59. Хуульд заасан хамгийн бэрхшээлтэй зохицуулалт бол зөвлөлийн бүрэлдэхүүний томилгоог Монгол Улсын Ерөнхийлөгч баталдаг явдал юм (13.1-р зүйл). Энэ нь ёс төдий эсэх эсвэл Зөвлөлийн гишүүдийг томилоход Ерөнхийлөгч шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг эсэх талаар дүгнэлт өгөхөд хангалттай мэдээлэл хуульд тусгагдаагүй байна. Дээр дурдсанчлан шүүхийн хараат бус байдлын баталгаа болох шүүхийн зөвлөлүүд өөрсдөө бие даасан, тал үл харах буюу төвийг сахисан байх ёстой,⁹⁶ өөрөөр хэлбэл гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн нөлөөллөөс ангид байх ёстой юм. Тиймээс шүүгч болон бусад гишүүдийг шүүхийн зөвлөлд томилох арга хэлбэр, ялангуяа томилж буй байгууллагуудын мөн чанар нь, шүүхийн өөрөө удирдах ёстой холбоотой⁹⁷ учир, эдгээр зөвлөлийн бүрэлдэхүүнд⁹⁸ улс төрийн эрх баригчдын ямар

⁹³ Жишээ болгон Итали Улсын Шүүхийн дээд зөвлөл <<https://www.csm.it/web/csm-internet/norme-e-documenti/normativa>>; *Монтенегро Улсын Шүүхийн зөвлөлийн тухай хууль* (2008)-ийн 8 дугаар зүйл; шууд бус сонгуулийн тухайд жишээ болгон Франц (Шүүхийн дээд зөвлөлийн тухайн 1994 оны хууль, сүүлд 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, ялангуяа, 3 ба 4 дүгээр зүйл, <<https://www.legifrance.gouv.fr/affichTexte.do?cidTexte=JORFTEXT000000364282>>) зэргийг харна уу.

⁹⁴ Жишээ болгон өмнө нь иш татсан 67-р зүйл, 51 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)); ба Венецийн Комисс, *Венецийн Комиссын дүгнэлт, шүүх ба шүүгчийн талаарх тайлангуудын эмхэтгэл*, CDL-PI(2015)001, 2015 оны 3 дугаар сарын 05, Зөвлөлийн гишүүдийг томилох/сонгох журмын 4.3 дахь хэсэг, 84-88 дугаар хуудсыг харна уу.

⁹⁵ *Өмнө нь иш татсан* 39-р зүйл, 109 дүгээр догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)); ба *өмнө нь иш татсан* 32-р зүйл, 67 дугаар догол мөр (АИХЭГ-ын Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу. Мөн *өмнө нь иш татсан* 67-р зүйл, 51 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)), үүнд “сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой бүх баримт бичиг, тэр дундаа боломжит нэр дэвшигчдийн талаархи баримтууд, томилгоо үйлдэх байгууллагуудын шүүх бүрэлдэхүүнийг томилох асуудлыг хэлэлцэх хуралдаан зэргийг олон нийтэд нээлттэй байлгах замаар хүртээмжтэй байх, ил тод байх байдлыг илүү хангахыг” зөвлөснийг харна уу.

⁹⁶ *Өмнө нь иш татсан* 10-р зүйл, Удиртгал (Шүүхийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд (2002))-г харна уу. Бангалорын зарчмууд нь “шүүхийн хэм хэмжээг мөрдүүлэх зорилго бүхий бие даасан, хараат бус холбогдох байгууллагуудын өмнө шүүгчид өөрсдийн ёс зүйн зан байдлын талаар хариуцлага хүлээнэ” гэж үздэг байна. Мөн *өмнө нь иш татсан* 67-р зүйл, 25 болон 37 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017))-г харна уу.

⁹⁷ Европын Хүний эрхийн шүүхийн *Oleksandr Volkov v. Ukraine* хэрэг (Хэргийн дугаар No. 21722/11, 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэр), 109-117 догол мөр, ялангуяа 112 дугаар догол мөр.

⁹⁸ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 67-р зүйл, 37-39 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017))-г харна уу. Мөн жишээ болгон Европын Хүний эрхийн шүүхийн *Oleksandr Volkov v. Ukraine* хэрэг (Хэргийн дугаар No. 21722/11, 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэр), 112 дугаар догол мөрийг харна уу. Зөвлөлд үзүүлэх улс төрийн нөлөөллийг багасгах зорилгоор Украины Шүүхийн дээд зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсныг энд тэмдэглэх нь зүйтэй. 2016 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Украины Үндсэн хуулийн 131 дүгээр зүйл (<<http://www.legislationline.org/topics/country/52/topic/9>>) болон *2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр Үндсэн хуулийн хороогоор батлагдсан Украины Үндсэн хуульд оруулахаар санал болгосон нэмэлт*

нэгэн нөлөөлөл орох ёсгүй юм. Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч “олон улсын стандартууд нь [шүүхийн гишүүдийн]⁹⁹сонгон шалгаруулалтын аль ч шатанд парламент, эсвэл гүйцэтгэх засаглал зэрэг улс төрийн эрх баригчдын оролцоог хориглодог”, ба “ямар ч тохиолдолд [шүүгч бус гишүүдийг]¹⁰⁰ гүйцэтгэх засаглал сонгох, томилох ёсгүй” хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнтэй холбогдуулан АИХЭГ болон Венецийн Комиссын зүгээс шүүхийн зөвлөлийн гишүүдийг улсын Ерөнхийлөгч томилдог журмыг шүүмжилсээр ирсэн.¹⁰¹ **Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгч томилдог /баталдаг хуулийн зохицуулалтыг бүхэлд нь дахин авч үзэх эсвэл нэр дэвшигчийг томилохоос татгалзах эрхгүйгээр зөвхөн бэлгэдлийн чанартай үүрэг¹⁰² гүйцэтгэх нөхцөлийг хангах шаардлагатай гэж үзнэ. Эсвэл Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг энгийн эрх зүйн хяналтаар (хуулиар тогтоосон шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангаж буй эсэх, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх) хязгаарлаж болно. Чингэхдээ томилохоос татгалзсан үндэслэл, шалтгаанаа бичгээр тодорхой тайлбарлах үүрэгтэй байх.**

60. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын тухайд түүнийг дотроосоо зөвлөлийн гишүүдээс нэр дэвшүүлдэг боловч мөн л Ерөнхийлөгч томилдог (13.2-р зүйл) байна. Ерөнхий зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүд сонгож буй нь сайшаалтай.¹⁰³ Үүний зэрэгцээ, Ерөнхийлөгч бэлгэдлийн чанартай бус илүү эрх мэдэлтэй байх аваас санал болгосон нэр дэвшигчийг томилохоос татгалзах боломжтой тул Ерөнхийлөгч зөвлөлийн даргыг томилж буй нь өөрөө асуудал үүсгэж болзошгүй юм.¹⁰⁴ Дээр зөвлөсний дагуу эл асуудлаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн бүхэлд нь эргэн хянаж үзэх эсвэл бэлгэдлийн чанартай эрхээр хязгаарлаж, хуульд тодорхой тусгах шаардлагатай юм. Түүнчлэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Хууль зүй, дотоод хэргийн сайдыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргаар тус тус томилохгүй байхыг зөвлөж байна.¹⁰⁵
61. Эцэст нь хэлэхэд Шүүхийн захиргааны тухай хуулийн 17.2-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга болон гишүүний цалингийн хэмжээг УИХ тогтооно гэж заасан байна. Ерөнхий зөвлөлийн хараат бус байдлыг хангахад түүний гишүүдийн цалин хөлсийг

[өөрчлөлтүүдэд Венецийн Комиссын өгсөн Санал дүгнэлтийн](#) 17-21 дүгээр догол мөрийг харна уу. Энэхүү Санал дүгнэлт нь Венецийн Комиссын 104 дүгээр ээлжит хуралдаанаар батлагдсан болно (Венец, 2015 оны 10 дугаар сарын 23-24).

⁹⁹ *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 76 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

¹⁰⁰ 108 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)).

¹⁰¹ *Өмнө нь иш татсан* 66-р зүүлт, 22-25 дугаар догол мөр (Узбекитсаны Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуульд АИХЭГ-ын өгсөн Санал дүгнэлт(2018)); ба [Казахстаны Шүүхийн дээд зөвлөлийн шинэчлэлийн талаарх үзэл баримтлалд өгсөн Венецийн Комиссын Санал](#), CDL-AD(2018)032, 21 дүгээр догол мөр зэргийг харна уу.

¹⁰² *Өмнө нь иш татсан* 5-р зүүлт, 10 дугаар догол мөрөн дэх үүнтэй холбогдуулан өгсөн зөвлөмжүүдийг харна уу (ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг тухай тайлан (2019)).

¹⁰³ *Өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 7 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)).

¹⁰⁴ *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 112 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)); ба ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007) ССЈЕ, [Opinion no.10 \(2007\) on the Council for the Judiciary at the service of society](#), 2007 оны 11 дүгээр сарын 23, 33 дугаар догол мөрийг харна уу.

¹⁰⁵ *Өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 7 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)); ба *өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 80-81 болон 112 догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

албан тушаал, ажлын ачаалалтай нь уялдуулж байх нь чухал юм.¹⁰⁶ Тиймээс хууль нь Зөвлөлийн гишүүдийг сайд эсвэл бусад дүйцүүлж болох албан тушаалтныхтай ижил цалинтай байх боломжийг хуулиар олгох ёстой юм. **Шүүхийн захиргааны тухай хуулийн 17.2-р зүйлд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах нь зүйтэй.**

4.2.3. *Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгох*

62. Шүүхийн захиргааны тухай хуулийн 19-р зүйлийн 1.1-1.2-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, тэтгэврийн насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдал, *“бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар”* албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон зэрэг үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх аж.
63. Ерөнхийд нь авч үзвэл шүүхийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг үндэслэлгүйгээр (хууль ёсны үндэслэл бус гэж холбогдох хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт) хугацаанаас нь өмнө дуусгавар болгох явдал эрх бүхий байгууллагын бие даасан байдалд, улмаар шүүх засаглалын хараат бус байдалд бүхэлд нь эргэлзээ үүсгэж буй юм.¹⁰⁷ Дээр дурдсанчлан, шүүхийн зөвлөлүүд нь шүүхийн хараат бус байдлын хамгийн чухал баталгаа болдог тул гишүүд нь ч мөн адил хараат бус байдлын баталгааг эдлэх ёстой¹⁰⁸ бөгөөд тухайн албан тушаалд байх хугацаанд нь гүйцэтгэх эсвэл хууль тогтоох эрх мэдлийн зохисгүй оролцоо нөлөөллөөс ангид байх ёстой юм.¹⁰⁹ Албан тушаалаас чөлөөлөх үндэслэлийн талаар ойлгомжгүй, тодорхой бус, өргөн хүрээнд тайлбарлагдах заалтууд нь зохисгүй нөлөөлөл эсвэл эрх мэдлээ урвуулан ашиглах байдалд хүргэж болзошгүй юм. Тиймээс *“бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар”* гэх хэллэг хэтэрхий ойлгомжгүй байгаа тул үүнийг тодруулах эсвэл хасах шаардлагатай гэж үзнэ. Ямар ч нөхцөлд хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд ийм үндэслэл агуулах нь зохисгүй болно.¹¹⁰
64. Дээрх хуулийн 19.1.4-р зүйлд зааснаар Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг шүүгчдийн хамтарсан зөвлөгөөн, Хуульчдын холбоо эсвэл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/ХЗДХЯ-ны шийдвэрээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх аж. Тухайн гишүүдийг нэр дэвшүүлж/сонгосон эрх бүхий байгууллагууд ямар хууль эрх зүйн үндэслэлээр Зөвлөлийн гишүүнийг эгүүлэн татах талаар дэлгэрэнгүй мэдээлэл харин өгөөгүй байна. Ийм ойлгомжгүй заалтууд нь Зөвлөлийн гишүүдийн гадны, тэр дундаа тэдгээрийг нэр дэвшүүлсэн/сонгосон байгууллагуудын дарамт шахалтаас хараат бус байх байдлыг хангах зорилго бүхий бүрэн эрхийг нь тогтоосон хугацааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тус

¹⁰⁶ *Өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 36 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007))-г харна уу.

¹⁰⁷ *Өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 81 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017))-г харна уу.

¹⁰⁸ *Жишээ болгон өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 36 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007))-г харна уу.

¹⁰⁹ *Өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 82 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017))-г харна уу.

¹¹⁰ 81-85 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)). Мөн *өмнө нь иш татсан* 66-р зүүлт, 37 дугаар догол мөр (Узбекитсаны Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуульд АИХЭГ-ын өгсөн Санал дүгнэлт (2018))-г харна уу.

байгууллагын бие даасан байдлыг хамгаалахын тулд зарчмын хувьд гишүүд нь бүрэн эрхийн хугацаандаа албан үүргээ ямарч гадны нөлөөллөөс ангид гүйцэтгэж дуусгах ёстой юм.¹¹¹ Ерөнхийд нь авч үзвэл шүүхийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нь шүүгчдэд үйлчилж буй адил баталгаа, зарчимд суурилсан байх ёстой.¹¹² Эдгээр зарчмын гол санаа нь гишүүний бүрэн эрх нь зөвхөн хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болж,¹¹³ үүрэгт ажлаас нь чөлөөлөх болон хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудалд улс төрийн нөлөөлөл орох аливаа эрсдэлээс зайлсхийхийн тулд ил тод, тогтсон журмын дагуу, тодорхой, бодит шалгуур үзүүлэлтүүд дээр үндэслэн¹¹⁴ шийдвэрлэхэд оршиж буй юм. Энэ нь зөвлөлийн гишүүдийг хуульд тодорхой заасан үндэслэлээр, шүүхийн нэр хүндэд халдсан ноцтой зөрчил гаргасан тухайлбал ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, эсвэл гэмт хэрэг үйлдсэн нь сахилгын болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон гэх мэт шалтгаанаар л огцруулах ёстой болно.¹¹⁵ Гишүүн өөрөө хүсэлт гаргасан, нас барсан эсвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу зөвлөлийн гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн зэрэг үндэслэлүүд гишүүн орнуудын хууль тогтоомжид ихэвчлэн тусгагдсан байдаг бөгөөд эдгээр нь ерөнхийдөө үүрэгт ажлаас нь чөлөөлөхөд хүргэж болохуйц үндэслэлүүд болно.¹¹⁶

65. Дээр дурдсанчлан зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэлийг илүү тодорхой болон оновчтой тодорхойлохыг зөвлөж байна. Үүний зэрэгцээ хэт өргөн хүрээг хамарсан, ойлгомжгүй нэр томъёоллоос зайлсхийж, зөвлөлийн гишүүдэд ийнхүү нөхцөл байдал тулгарахад шударга, ил тод байдлыг хангасан шийдвэрлэх журмын нэвтрүүлэх нь зүйтэй юм.
66. Шүүхийн захиргааны тухай хуулийн 19.2.1-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга, гишүүдийг *“хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан”* гэх үндэслэлээр огцруулахаар заасан байна. Энэхүү заалт нь хангалттай

¹¹¹ 83 ба 85 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)). Мөн *өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 83 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)), үүнд хууль тогтоомжийн өөрчлөлтөөс үүдэлтэй шүүхийн бүх гишүүдийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх нь шүүхийн хараат бус байдал, засаглалын эрх мэдлийг зааглах тухай одоо байгаа хэм хэмжээг зөрчиж байна гэснийг харна уу.

¹¹² Жишээ болгон [ЕШЗЗ-ийн Ерөнхий шүүгч нарын гүйцэтгэх үүргийн талаар Санал дүгнэлт №18](#), 2016 оны 11 дүгээр сарын 10, 44-48 дугаар догол мөрийг харна уу.

¹¹³ *Өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 82 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)). Жишээ болгон Венецийн Комиссын 100 дугаар ээлжит хурлаар (Ром, 2014 оны 10 дугаар сарын 10-11) батлагдсан "Хуучин Югославын Бүгд Найрамдах Македони Улсын" Үндсэн хуульд оруулсан нэн ялангуяа Шүүхийн зөвлөл, [Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрх болон санхүүгийн тусгай бүсүүдтэй холбогдолтой долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн Санал дүгнэлт](#), CDL-AD(2014)026-е, 77 дугаар догол мөр; ба [Венецийн Комиссын Гүрж Улсын Ердийн шүүхүүдийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн төсөлд өгсөн Санал дүгнэлт](#), CDL-AD(2013)007, 2013 3 дугаар сарын 11, 72-73 дугаар догол мөрийг үзнэ үү.

¹¹⁴ 82 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)); ба *өмнө нь иш татсан* 66-р зүүлт, 37 дугаар догол мөр (АИХЭГ-ын Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн Дээд Зөвлөлийн тухай хуульд өгсөн Санал дүгнэлт (2018))-г харна уу.

¹¹⁵ 82 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)); ба 37 дугаар догол мөр (АИХЭГ-ын Бүгд Найрамдах Узбекистан Улсын Шүүхийн Дээд Зөвлөлийн тухай хуульд өгсөн Санал дүгнэлт (2018)). Мөн жишээ болгон *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 44 дүгээр догол мөр (ЕШЗЗ-ийн Санад дүгнэлт №18 (2015))-г харна уу.

¹¹⁶ Жишээ болгон 35 дугаар догол мөр (АИХЭГ-ын БНУзбекистан Улсын Шүүхийн Дээд Зөвлөлийн тухай хуульд өгсөн Санал дүгнэлт (2018))-г харна уу.

тодорхой бус бөгөөд практик дээр зүй бусаар тайлбарлах, хэрэглэх асуудал үүсгэж болзошгүй юм. Тиймээс, "хүндэтгэн үзэх шалтгаан" гэсэн ойлголтыг хуульд тодорхой тусгаж, тухайн гишүүнийг огцруулахад хүргэх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан хуралдааны тоо, түр огцруулах хугацаа, албан тушаалд нь эгүүлэн томилох/огцруулах хугацааг цуцлах нөхцөл зэргийг нарийвчлан тогтоохыг зөвлөж байна.

67. Эцэст нь хэлэхэд Зөвлөлийн үйл ажиллагааг цалгардуулахгүй байх үүднээс түүний гишүүдийг бүгдийг нь нэгэн зэрэг солихгүй байх нь зүйтэй юм.¹¹⁷ **Үүнийг Шүүхийн захиргааны тухай хуульд тусгах шаардлагатай болно. Үүний сацуу дахин томилох журам нь тодорхойгүй байгаа тул үүнийг нарийвчлан тодорхой зааж өгөх нь зүйтэй болно.**

4.3. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг шүүхэд хянан шийдвэрлүүлэх

68. Шүүхийн захиргааны тухай хуулийн 15.3-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шийдвэрийг захиргааны шүүхэд хянан шийдвэрлүүлж болно гэж заасан нь сайшаалтай боловч бүх шийдвэрийг шүүхийн хяналтанд хамруулж болох эсэх нь тодорхойгүй байна. Үнэн хэрэгтээ шүүхийн зөвлөлийн шийдвэрүүд, ялангуяа шүүгчийн бие даасан үйл ажиллагаатай холбоотой, жишээлбэл, шүүгчдийг сонгох/томилох, тэдний ажил, албан тушаал ахих, үүрэгт ажлаас нь чөлөөлөх зэрэг асуудлаарх шийдвэрүүдийг давж заалдах нөхцөлөөр хангасан байх нь чухал юм (Сахилгын асуудлаарх 5.6-р дэд хэсгийг харна уу).¹¹⁸ Гэсэн хэдий ч хуульд ийм хуулийн хяналт тавих талаар, ялангуяа хувийн, материаллаг болон түр хугацааны хамрах хүрээ, түүнчлэн холбогдох журмын талаар нарийвчлан тусгаагүй байна. Тодруулбал, хуульд хэн ямар статустай байх, захиргааны ямар шатны шүүх ийнхүү эрх мэдэлтэй байх, тухайн захиргааны шүүхийн шийдвэрийг цаашид давж заалдаж болох эсэхийг зааж өгөх ёстой юм. Түүнчлэн гомдол гаргах хугацаа, шүүхийн шийдвэрийн эргэн хяналтын хамрах хүрээ, тухайлбал, шийдвэрийг бүхэлд нь эргэн хянах эсэх, эсвэл зөвхөн хууль/процедурын асуудалтай холбоотой байх эсэх, эсвэл Зөвлөлийн гаргасан шийдвэрүүдийн төрлөөс шалтгаалан тухайн шийдвэрийн эргэн хяналтын хамрах хүрээ өөр өөр байх эсэх талаар хуульд тусгагдаагүй байна.¹¹⁹ Өөр хууль тогтоомжид заагаагүй бол **Зөвлөлийн шийдвэрүүдийг шүүхээр хянан үзэх нөхцөл, журам, хамрах хүрээг нь нарийвчлан тодорхойлж, өөр хуулиар зохицуулагдаж байгаа бол холбогдох эшлэлийг тусгаж,**

¹¹⁷ *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 83 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу.

¹¹⁸ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 75-р зүүлт, 78 дугаар догол мөр (АИХЭГ-ын Гүрж Улсын Дээд шүүхийн шүүгчдийг томилохтой холбоотой Санал дүгнэлт (2019)); ба *өмнө нь иш татсан* 32-р зүүлт, 107-115 дугаар догол мөр (АИХЭГ, Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу. Мөн жишээ болгон *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 39 дүгээр догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007))-г харна уу.

¹¹⁹ 78 дугаар догол мөр (АИХЭГ-ын Гүрж Улсын Дээд шүүхийн шүүгчдийг томилохтой холбоотой Санал дүгнэлт (2019)); ба 14 болон 62 дугаар догол мөр (АИХЭГ, Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу.

Шүүхийн захиргааны тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

69. Энэхүү давуу эрх мэдлийг хэрэгжүүлэхийн тулд шүүхийн зөвлөлүүд дур зоргоороо бус харин олон улсын болон бүс нутгийн түвшинд гаргасан зөвлөмжүүдэд нийцсэн **үндэслэл бүхий шийдвэрүүд** гаргаж байх нь чухал юм.¹²⁰ Нэр дэвшигчид ямар шалтгаанаар амжилт гаргаж чадаагүй тухай мэдэх нь мөн чухал юм.¹²¹ Энэхүү шаардлага нь шүүгч нарын дунд болон нийт нийгэмд ил тод байдлыг хангахад чиглэж буй юм. **Үүнийг Шүүхийн захиргааны тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгах нь зүйтэй юм.**
70. Хуулийн 15.4-р зүйлд Зөвлөл хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно гэж заасан байна. Дэг нь олон нийтэд нээлттэй эсэх нь хуульд тодорхой бус байна. **Зөвлөлийн хуралдааны дэгийг нийтэд нээлттэй байлгах, үүнийг хуульд тусгайлан тусгахыг зөвлөж байна.** Энэ нь олон нийтийн тус байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах болно.¹²²
71. Хуулийн 15.7-р зүйлд Зөвлөлийн тогтоолууд Зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно гэж заасан байна. Харин эдгээр тогтоолууд нийтлэгддэг эсэх, хэвлэн нийтлэгдэх тохиолдолд хаана гэдгийг хуульд зааж өгөөгүй байна. Зөвлөлийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахын тулд Зөвлөл тогтоолуудаа адаглаад өөрийн цахим хуудсанд байршуулж, мөн боломжтой бол хууль тогтоомж, бусад норматив актууд хэвлэн нийтлэгддэг албан ёсны хэвлэлд нийтлэж байхыг зөвлөж байна. **Ямарч тохиолдолд Зөвлөлийн тогтоолыг хэвлэн нийтлэхийг хуульд тодорхой тусган оруулах шаардлагатай болно.**
72. Хуулийн 18.1.8-р зүйлийн дагуу Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга *“Ерөнхий зөвлөлийн ажлын тайланг Монгол Улсын Ерөнхийлөгчид жил бүр танилцуулах”* аж. Энэ заалт нь тодорхой бус байна. Хэрэв энэ нь Ерөнхийлөгчид мэдээлэл хүргэх ердийн утга агуулж буй бол Зөвлөлийн хараат бус байдлын үүднээс энэхүү заалт байж болох

¹²⁰ Жишээ болгон 61 болон 78 дугаар догол мөр (АИХЭГ-ын Гүрж Улсын Дээд шүүхийн шүүгчдийг томилохтой холбоотой Санал дүгнэлт (2019)); ба 118 болон 127 дугаар догол мөр (АИХЭГ, Молдавын талаарх урьдчилсан Санал дүгнэлт (2019))-г харна уу. Мөн жишээ болгон [ЕШЗС-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, шүүхийн зөвлөлүүдийн шийдвэрийн үндэслэлүүдийн тайлбарын тухай 39 дүгээр догол мөр; *өмнө нь иш татсан* 24-р зүүлт, 28 болон 48 дугаар догол мөр (Европын зөвлөлийн Зөвлөмжүүд CM/Rec(2010)12 (2010)); Кейптауны их сургуулийн профессор Хью Кэрдерээр ахлуулж, Их Британийн Олон улсын ба харьцуулсан эрх зүйн хүрээлэнгийн Бингхэмийн Хууль сахиулах төвтэй хамтран хэрэгжүүлсэн олон улсын судалгааны төслийн үр дүн болох Шүүгчдийг сонгох, томилох бие даасан комиссын үүргийн тухай Кэйп Тауны зарчмууд (2016 оны 02 дугаар сар), 13 дугаар зарчим, <<https://www.biicl.org/bingham-centre/projects/capetownprinciples>>; ба Европын Шүүхийн зөвлөлийн сүлжээ, [Шүүгчдийг сонгох, томилох хамгийн доод стандартыг тогтоосон Дублиний тунхаглал](#) (2012 оны 5 дугаар сар), Үзүүлэлт I.10-г харна уу. Мөн [Венецийн Комиссын Прокурорын байгууллагын тухай хуулийн төсөлд тусгагдсан Прокурорын зөвлөл болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй шүүхийн тухай хуульд тусгагдсан Шүүхийн дээд зөвлөлтэй холбогдох заалтуудад өссөн Санал дүгнэлт](#), CDL-AD (2018) 029-е, 45 дугаар догол мөрийг харна уу. Үүнд Венецийн Комиссоос Шүүхийн дээд зөвлөлийн баталсан, ялангуяа шүүгчийн карьерын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд зохих үндэслэлтэй байх нь чухал гэдгийг тэмдэглэсэн болно.

¹²¹ *Өмнө нь иш татсан* 210-р зүүлт, Үзүүлэлт № I.10 (ЕШЗС, Шүүгчдийг сонгох, томилох хамгийн доод стандартыг тогтоосон Дублиний тунхаглал (2012)). Мөн *өмнө нь иш татсан* 120-р зүүлт, 17 дугаар зарчим (Шүүгчдийг сонгох, томилох бие даасан комиссын үүргийн тухай Кэйп Тауны зарчмууд (2016))-г харна уу.

¹²² Мөн [ЕШЗС-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, 91 дүгээр догол мөрийг харна уу.

юм. Харин энэхүү заалт нь Ерөнхий зөвлөлөөс жил бүр Ерөнхийлөгчид тайлагнаж, Ерөнхийлөгч тайланг хүлээн авахаас татгалзах, эсвэл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт гаргах бүрэн эрхтэй байх утга агуулж буй бол энэ нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хөндсөн ноцтой асуудал үүсгэх бөгөөд тус заалтыг өөрчлөх шаардлагатай юм. Түүнчлэн Зөвлөлийн ил тод байдал, олон нийтэд тайлагнах хариуцлагыг хангах зорилгоор Зөвлөл жилийн тайлангаа өөрийн цахим хуудсанд байршуулж байхыг хуульд тусгахыг мөн зөвлөж байна.¹²³ Эцэст нь тэмдэглэхэд Зөвлөл тайландаа хийсэн ажил, тулгарч буй бэрхшээлүүдийн талаар оруулахаас гадна олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн шударга ёсны тогтолцоог болон шударга ёсны нийтэд хүртээмжтэй байдлыг боловсронгуй болгох чиглэлд авах шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар саналаа тусгаж байх нь зүйтэй юм.¹²⁴ Холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулах нь зохистой болно.

4.4. Шүүхийн захиргааны бусад байгууллагууд

73. Шүүхийн захиргааны тухай хуулийн 23-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь Шүүхийн Мэргэшлийн Хороо байгуулахаар тусгасан бол 32-р зүйлд Шүүхийн ёс зүйн хороог тусад нь байгуулах тухай тусгажээ. Ерөнхийдөө эрх мэдлийг нэг газар хэт төвлөрүүлэхгүйн тулд шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчдийг албан тушаал ахиулах, сургах, сахилгын асуудал, мэргэжлийн үнэлгээ, ёс зүй зэрэг шүүхийн захиргааны эрх мэдлийн өөр өөр асуудлуудыг ялгаж салган өөр өөр байгууллагуудад хариуцуулах нь сайн практик гэж үздэг.¹²⁵ Тодорхой чиг үүргийг нь тусгасан бүтэцтэй бөгөөд нэг байгууллага, эрх мэдлийн хяналтаас хараат бус өөр өөр бие даасан байгууллагуудыг байгуулахыг нийтлэг байдлаар зөвлөдөг.¹²⁶ Энэ үүднээс Монгол Улсад ийнхүү тусдаа байгууллагууд байгуулагдсан нь сайшаалтай. Тус бүрийн бүтэц, бүрэн эрхийг доорх байдлаар авч үзсэн болно.

4.4.1. Шүүхийн Мэргэшлийн Хороо

74. Шүүхийн захиргааны тухай хуулийн 23.2-р зүйлд заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хороог Шүүхийн Ерөнхий Зөвлөл байгуулна. Тус хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажлын туршлагатай, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, хуульчаас бүрдсэн есөн орон тооны бус гишүүний бүрэлдэхүүнтэй ба тэдгээрийг нь Хуульчдын холбооноос санал болгосноор Ерөнхий зөвлөл томилох юм. Мэргэшлийн хорооны гишүүнээр Ерөнхий зөвлөлийн болон

¹²³ Үүнтэй холбогдуулан [ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, 96 дугаар догол мөрийг харна уу.

¹²⁴ 96 дугаар догол мөр.

¹²⁵ *Өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 2 дугаар догол мөр (АИХЭГ, Киевын зөвлөмжүүд (2010)); ба *өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 95 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018)). Мөн жишээ болгон [ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, 43 дугаар догол мөрийг харна уу. Үүнд эдгээр эрх мэдлийг шүүхийн зөвлөлд төвлөрүүлж, чингэхдээ түүний төрөл бүрийн салбаруудад хуваарьлах боломжтойг санал болгосон болно.

¹²⁶ *Өмнө нь иш татсан* 39-р зүүлт, 95 дугаар догол мөр (НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүхийн зөвлөлүүдийн талаар тайлан (2018))-г харна уу. [ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10](#) (2007), 2007 оны 11 дүгээр сарын 23, 45 дугаар догол мөр.

шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор нар байж болохгүй юм (23.4-р зүйл).

75. Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн хэд хэдэн асуудлыг хөндөж буй юм. Нэгдүгээрт, Хорооны гишүүдийг Хуульчдын холбооноос санал болгож, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс томилдог тул шүүгч нар тус Хороог байгуулагдахад ямарч оролцоогүй байхаар байна. Хоёрдугаарт, Хорооны гишүүн байж болох шүүгчдийн тооны доод хэмжээг тогтоосон квотын тухай заалт огт байхгүй байна. Үүний зэрэгцээ Хорооны үндсэн чиг үүрэг бол шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчид тухайн албан тушаалд сонгон шалгаруулах болзол, шаардлагыг хангаж буй эсэх талаар үнэлгээ өгөх явдал юм (Хуулийн 23.6.1-р зүйл). Шүүгчийн томилгоог шүүгчийн сонгон шалгаруулалт, ажил мэргэжлийн асуудлыг хариуцсан, гишүүдийнх нь талаас багагүй хувь нь шүүгчид дундаасаа сонгогдсон эсвэл томилогдсон шүүгчдийн багаас бүрдсэн¹²⁷ хараат бус шүүхийн зөвлөл эсвэл өөр эрх бүхий байгууллага буюу шүүх засаглалын байгууллага өөрөө шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь зүйтэй гэж олон улсын түвшинд өргөнөөр хүлээн зөвшөөрдөг юм.¹²⁸ Харин Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн эдгээр стандартад нийцэхгүй байна. **Иймд Шүүхийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүний гишүүдийнх нь талаас багагүй хувийг, гэхдээ дийлэнх олонхи нь бус, шүүгчид дундаасаа сонгогдсон эсвэл томилогдсон шүүгчид байхаар нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөж байна. Хэрэв энэ нь Монголын нөхцөлд нийцнэ гэж үзвэл Хорооны бүрэлдэхүүнд нийгмийн бусад төлөөллөөс, жишээ нь иргэний нийгмийн төлөөлөл ба/эсвэл Хуульчдын холбооноос томилогдсон хуульч ба/эсвэл бусад байгууллагын төлөөлөл оруулж, холимог болгох нь зүйтэй юм.** Түүнчлэн, тус Санал, дүгнэлтийн шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүний тухай 55-р догол мөрөнд дурдсанчлан шүүгчид нэр дэвшигчдийг сонгох үйл явцад улс төрийн нөлөөлөл орохоос зайлсхийх үүднээс¹²⁹ **идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй улс төрчид, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын**

¹²⁷ Жишээ болгон мөнөө нь иш татсан 18-р зүүлт, 8 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)), үүнд "шүүгчдийн олонхи гадна" [сонгон шалгаруулалтын шийдвэр гаргах байгууллагын] бүрэлдэхүүн нь улс төрийн үзэл баримтлал шүүхийн албан тушаалд нэр дэвшигчийн мэргэшилээс давамгайлахгүй байхыг хангах ёстой" гэж заасныг; өмнө нь иш татсан 19-р зүүлт, 1.3 дахь догол мөр (Шүүгчийн эрх зүйн байдлын талаарх Европын дүрэм (1998)), үүнд "[Шүүгчийг сонгон шалгаруулах, ажилд авах, томилох, албан тушаалд дэвших, эсвэл бүрэн эрхийг нь цуцлахтай холбогдох шийдвэр бүрийн хувьд энэхүү дүрэмд гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байгууллагыг оролцуулахыг заасан бөгөөд тус байгууллагын бүрэлдэхүүний талаас доошгүй хувь нь шүүхийн хамгийн өргөн төлөөллийг баталгаажуулах аргын дагуу шүүгчид дундаасаа сонгогдсон шүүгчид байна" гэж заасныг өмнө нь иш татсан 34-р зүүлт, 48 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)), үүнд "Шүүхийн хараат бус байдлыг хадгалахын тулд шүүгчдийг томилох, дэвшүүлэх нь хараат бус байх нь зүйтэй бөгөөд үүнийг хууль тогтоох байгууллага эсвэл гүйцэтгэх засаглал бус Шүүхийн зөвлөлөөс хийх нь чухал юм" гэж зааныг; өмнө нь иш татсан 24-р зүүлт, 46 дугаар догол мөр (Шүүгчдийн талаар Европын Зөвлөлийн CM/Rec (2010)12 зөвлөмж: Хараат бус байдал, үр ашиг, хариуцлага (2010)), үүнд "Шүүгчдийн сонгон шалгаруулалт, ажил мэргэжлийн талаар шийдвэр гаргах байгууллага нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байх ёстой" гэж; ба өмнө нь иш татсан 65-р зүүлт, 25 болон 32 дугаар догол мөр (Венецийн Комиссын Шүүгчийн томилгооны тухай тайлан (2007)) зэргийг харна уу.

¹²⁸ Өмнө нь иш татсан 67-р зүүлт, 69 дүгээр догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017))-г харна уу.

¹²⁹ Өмнө нь иш татсан 34-р зүүлт, 51 дүгээр догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)); өмнө нь иш татсан 24-р зүүлт, 44 дүгээр догол мөр (Шүүгчдийн талаар Европын Зөвлөлийн CM/Rec (2010)12 зөвлөмж: Хараат бус байдал, үр ашиг, хариуцлага (2010)); ба 8 дугаар догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010))-г харна уу.

байгууллагын гишүүдийг ийм Хорооны бүрэлдэхүүнд орж ажиллуулахгүй байх, холбогдох нэмэлт, өөрчлөлтийг Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлд оруулах нь зүйтэй гэж үзнэ.

76. Шүүхийн мэргэшлийн хорооны үйл ажиллагааны тухайд Шүүхийн захиргааны тухай хуулийн 23.8-р зүйлд болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1-р зүйлд хорооны дүрэм, журмыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл санал болгосноор Ерөнхийлөгч батална гэсэн байна. Ерөнхийлөгч ийнхүү баталдаг явдал нь Шүүхийн мэргэшлийн хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хөндсөн асуудал үүсгэж болзошгүй юм. Шүүгчийн сонгон шалгаруулалт хариуцсан байгууллагуудын хувьд *"гүйцэтгэх засаглалын хяналтаас ангид, орон нутгийн засаг захиргаанаас хараат бус үйл ажиллагаа явуулдаг"*¹³⁰ байх нь нэн чухал юм. Хэдийгээр Хорооны журмыг Ерөнхийлөгч батлах нь бэлгэдлийн чанартай байж болох ч энэ нь Хорооны удирдлага, үйл ажиллагаанд гүйцэтгэх эрх мэдлийн ямар нэгэн хяналт байгаа мэт ойлголт төрүүлэх магадлалтай юм. Түүнээс гадна Хорооны дүрэмд түүний үйл ажиллагааны талаар техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, шүүгчийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, журмыг (5.4-р дэд хэсгийг үзнэ үү) тусгах нь зүйтэй. Гэвч эдгээрийг улсын ерөнхийлөгч гэх мэт гүйцэтгэх засаглалын дээд албан тушаалтнуудын бүрэн эрхэд хамруулахад хэт өвөрмөц шаардлага байна. Тиймээс **Шүүхийн мэргэшлийн хорооны дүрмийг Ерөнхийлөгч бус Хорооны гишүүд эсвэл Шүүхийн Ерөнхий Зөвлөл боловсруулж, баталж байх заалтыг эсвэл Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг бэлэгдлийн чанартай байх нөхцлийг хангахыг зөвлөж байна.**
77. Шүүхийн мэргэшлийн хорооны үйл ажиллагаатай холбоотой зарим чухал зохицуулалт, тэр дундаа Хорооны гаргасан шийдвэрүүдийн үр дагварын талаар мэдээлэл дутмаг байна. Тухайлбал, Мэргэшлийн хорооны зөвлөмжийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл дагаж мөрдөх шаардлагатай эсэх нь хуульд тодорхой тусгаагүй байна. Шүүгч/ерөнхий шүүгчид нэр дэвшигчид дэмжигдээгүй тохиолдолд Мэргэшлийн хорооны ийнхүү гаргасан шийдвэрийг давж заалдах боломжтой эсэх, мөн эдгээр гаргасан шийдвэрүүдийн үндэслэлийг тусгасан байх эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл алга байна.¹³¹ **Дээр дурдсан зохицуулалтыг хуулинд дэлгэрэнгүй нэмж оруулахыг зөвлөж байна** (Шүүгчдийг сонгох, томилох тухай 5.4-р дэд хэсгийг үзнэ үү).
78. Түүнчлэн, **Хороо нь орон тооны бус бүрэлдэхүүнтэй байх нь гишүүдэд үүргээ мэргэжлийн түвшинд, хичээнгүй, үр дүнтэй, цаг хугацаанд нь гүйцэтгэх боломжийг олгодог эсэхийг хуулийн төсөл боловсруулагчид дахин нягталж үзэх хэрэгтэй. Хэрэв үгүй бол тус байгууллагыг орон тооны гишүүдтэй болгох асуудлыг ЭЗХАХБ-аас зөвлөсний дагуу авч үзэх боломжтой юм.**¹³² Харин эхний хувилбарыг хэвээр үлдээх тохиолдолд гишүүдийн тоог бууруулах эсэх асуудлыг хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид үнэлэх зүйтэй юм. Хорооны гишүүд орон

¹³⁰ Өмнө нь иш татсан 18-р зүүлт, 4 дүгээр догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010)).

¹³¹ Өмнө нь иш татсан 75-р зүүлт, 61 болон 78 дугаар догол мөр (АИХЭГ-ын Гүрж Улсын Дээд шүүхийн шүүгчдийг томилохтой холбоотой Санал дүгнэлт(2019)).

¹³² Өмнө нь иш татсан 5-р зүүлт, 15-16 дугаар хуудсан дээрх 11.9 дэх шинэ Зөвлөмж болон 54 дүгээр хуудас (ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг тухай тайлан (2019))-г харна уу.

тооны бус нөхцөлтэйгээр үүргээ гүйцэтгэж буй тул тэд харьяалагдах үндсэн байгууллагадаа үргэлжлүүлэн ажиллаж, цалинжиж байх болов уу. Энэ нь тэдгээрийг үндсэн ажил олгогчоосоо тодорхой хэмжээнд материаллаг, шаталсан болон захиргааны хараат байдалд зайлшгүй оруулж буй явдал юм.¹³³ Тиймээс **хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид хорооны бүх гишүүд нь бие даасан, эрх тэгш эрхтэй бөгөөд нэрийг нь дэвшүүлсэн байгууллагаасаа болон/эсвэл үндсэн ажил олгогчоосоо үл хамааран ажиллана гэсэн тодорхой заалтыг хуульд нэмж оруулах нь зүйтэй гэж үзнэ** (5.4-р дэд хэсэгт шүүгчдийг сонгох, томилох асуудлын хүрээнд жендэр, нийгмийн олон янз байдлын төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангах талаар тайлбарыг харна уу).

4.4.2. Шүүхийн Ёс Зүйн Хороо

79. Шүүхийн захиргааны тухай хуулийн 33-р зүйлд Шүүхийн Ёс зүйн хорооны эрх үүргийг тусгасан байна. Энэ заалтаас харахад Ёс зүйн хороо нь шүүгчдийн эсрэг гаргасан сахилгын асуудлаарх гомдлыг шалгах, хэргийг хянах, зохих журмын дагуу шийдвэрлэх үүрэгтэй нь ойлгомжтой байна. Мөн хуулийн 32-р зүйлд Шүүхийн Ёс зүйн хороо нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан байна. Эдгээр есөн гишүүнийг дараах байдлаар нэр дэвшүүлнэ: анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос гурав, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага/ХЗДХЯ-наас гурван хүнийг гэжээ. Мөн Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хуульд хориглосон байна (мөн хуулийн 32.3-р зүйл). Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, дүрэмийг Ерөнхийлөгч батална (мөн хуулийн 32.4-р зүйл). Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33-37-р зүйлд Шүүхийн ёс зүйн хорооны сахилгын хэрэг хянан хэлэлцэж, шийдвэрлэх ажиллагааны талаар нарийвчлан тусгасан байна.
80. Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс тусдаа шүүгчдийн сахилгын асуудал хариуцсан байгууллага байгуулсан нь сайшаалтай ба энэ нь олон улсын зөвлөмжүүдэд нийцэж буй юм.¹³⁴ Мөн адил, корпоративизмд буруутгагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс тус байгууллага нь зөвхөн шүүгчдээс бүрдээгүй нь сайшаалтай.¹³⁵
81. Үүний зэрэгцээ, дээрх сахилгын тогтолцоотой холбоотой тулгарч болзошгүй асуудлууд цөөнгүй байна. Нэгдүгээрт, ёс зүйн зөвлөгөө өгөх байгууллага болон сахилгын хариуцлага хүлээлгэх байгууллага хоорондын үүрэг, хариуцлагыг чанд тусгаарлах нь чухал болохыг тэмдэглэх нь зүйтэй юм.¹³⁶ Мэргэжлийн ёс зүйн дүрмийн

¹³³ *Өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 87 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу.

¹³⁴ *Өмнө нь иш татсан* 125-р зүүлтэд дурдсан тайлбарыг харна уу.

¹³⁵ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 2, 5 болон 9 дүгээр догол мөр (АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд (2010))-г харна уу.

¹³⁶ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 97 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу. Мөн жишээ болгон *өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 25-27 болон 30 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын БНКиргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар

мөн чанарыг харгалзан тэдгээрийг эрх зүйн акттай адилтгаж, сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болгон ашиглаж болохгүй.¹³⁷ Ихэнх тохиолдолд эдгээр ёс зүйн хэм хэмжээг ерөнхий, тодорхой бус байдлаар томъёолж, боловсруулдаг¹³⁸ бөгөөд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, шаардлагыг хангадаггүй.¹³⁹ Ёс зүйн дүрмийн зорилго бол шүүгчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зөв зан байдлын талаар ерөнхий дүрэм, зөвлөмж, стандартуудыг бий болгох, өдөр тутмын ажилд эсвэл ажлын бус үед гарч буй тодорхой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар үнэлгээ өгөх боломжийг шүүгчид олгох явдал юм.¹⁴⁰ Ихэнх улс оронд ёс зүйн дүрэм нь албан бус статустай байдаг бөгөөд ёс зүйн зарчмыг зөрчсөн нь сахилгын арга хэмжээ авах шууд үндэслэл болдоггүй. Энэ нь тодорхой ноцтой түвшинд хүрсэн, сахилгын хариуцлага ногдуулахыг шаардагдсан ёс зүйгүй, зохисгүй үйлдлүүдийг цагдахад зориулагдсан сахилгын хариуцлагын дүрэм журмын зорилгоос огт өөр юм.¹⁴¹ ЕШЗЗ-ийн үзэж байгаагаар “*ёс зүйн зарчмууд нь шүүгчид хамаарах сахилгын дүрмээс хараат бус байх ёстой, улмаар эдгээр зарчмын аль нэгийг дагаж мөрдөхгүй байх тохиолдолд энэ нь өөрөө сахилгын зөрчилд эсвэл иргэний болон эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох ёсгүй*” юм гэжээ.¹⁴² Ёс зүйн хэм хэмжээг зөрчих нь эцсийн дүнд сахилгын гэхээсээ илүү ёс суртахууны хариуцлагад хүргэх ёстой юм.¹⁴³

хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу. Түүнчлэн [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 44 болон 46-47 догол мөрийг харна уу.

¹³⁷ Дээрх иш татсан зүүлтийг харна уу.

¹³⁸ [Венецийн Комиссын БНТажикистан Улсын Шүүгчийн ёс зүйн тухай хуулийн төсөлд өгсөн](#) 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн CDL-AD(2013)035 дугаар Санал дүгнэлтийн 31 дүгээр догол мөрийг харна уу. Энэ нь Венецийн Комиссын 97 дугаар ээлжит хурлаар батлагдсан болно (2013 оны 12 дугаар сарын 6-7-ны өдрүүд).

¹³⁹ [АИХЭГ-ын Польш улсын Ерөнхий шүүхүүдийн зохион байгуулалтын тухай, Дээд шүүхийн тухай болон зарим бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн шүүрхай урьдчилсан Санал дүгнэлт](#) (2020 оны 01 дүгээр сарын 14), 70-74 дүгээр догол мөр; мөнөө иш татсан 13-р зүүлт, 19 дүгээр догол мөр (НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ерөнхий тайлбар №32, (2007)), үүнд "Улс орнууд Үндсэн хуулиар дамжуулан эсвэл [...] шүүх бүрэлдэхүүнээс халах, тэдгээрт сахилгын хариуцлага оногдуулах тодорхой журам, объектив шалгуурыг тогтоосон хууль батлах замаар шүүхийн хараат бус байдлыг [...] баталгаажуулах тодорхой арга хэмжээг авах шаардлагатай" гэж заасныг харна уу. Мөн [АИХЭГ-Венецийн Комиссын БНМолов Улсын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн төсөлд өгсөн хамтарсан Санал дүгнэлт](#), CDL-AD(2014)006, 16 дугаар догол мөр; ба Европын хүний эрхийн шүүхийн жишгийн дүрмийг харна уу. Тус жишиг дүрэмд сахилгын арга хэмжээ авах үндэслэлийг хангалттай тодорхой байлгах хэрэгтэй бөгөөд ингэснээр холбогдох этгээд үйлдлийнхээ үр дагаврыг урьдчилан харж, үүний дагуу үйлдлээ зохих ёсоор зохицуулах боломжтой болохыг тэмдэглэсэн байна. Жишээ болгон ЕХЭШ-ийн [N.F. v. Italy](#) хэрэг (Хэргийн дугаар: 37119/97, 2001 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэр), 29-30 дугаар догол мөр; ба [Volkov v. Ukraine](#) хэрэг (Хэргийн дугаар: 21722/11, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн шийдвэр), 173ff дугаар догол мөрийг харна уу.

¹⁴⁰ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 26 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу.

¹⁴¹ [Бангалорын зарчмуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд](#), 15.1 дэх догол мөр, үүнд “*Шүүгчид сахилгын хэрэг зөвхөн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд л үүсгэж болно. Шүүгчдэд хамаарах хуулиар сахилгын шийтгэл хүлээлгэхэд хургэх зан үйлдэл, түүнчлэн дагаж мөрдөх журмыг аль болох тодорхой байдлаар тодорхойлж болно*” гэж заасныг; ба *өмнө нь иш татсан* 18-р зүүлт, 25 дугаар догол мөр (АИХЭГ, Киевын зөвлөмжүүд (2010)), үүнд “*Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бүдүүлэг болон хэлтрүүлгийг мэргэжлийн ёс зүйгүй байдал гаргасан ба шүүхийн тогтолцоонд сөрөг үр нөлөө үзүүлэх хэрэгт холбогдсон байх ёстой*” гэж заасныг харна уу. Мөн жишээ болгон [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 60 дугаар догол мөр; *өмнө нь иш татсан* **Error! Bookmark not defined.**-р зүүлт, 72-73 дугаар догол мөр (СМ/Rec(2010)12 ЕЗ-ийн Зөвлөмжүүд (2010)); ба *өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 27 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу.

¹⁴² [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 48 (i) дугаар догол мөрийг харна уу.

¹⁴³ *Өмнө нь иш татсан* 20-р зүүлт, 36 дугаар догол мөр (Венецийн Комиссын БНТажикистан Улсын Шүүгчийн ёс зүйн тухай хуулийн төсөлд өгсөн Санал дүгнэлт).

82. Дээр дурдсантай холбогдуулан хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид Ёс зүйн хорооны бүрэн эрхийг бүхэлд нь дахин нягтлаж, ялангуяа шүүгчид сахилгын хариуцлага ногдуулахтай холбогдох асуудлыг бүрэн эрхийнх нь хамрах хүрээнээс хасах (ялангуяа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33-37-р зүйлийг үзнэ үү), харин үүний оронд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх асуудал хариуцсан бие даасан тусдаа салбар байгууллага, нэгжийг байгуулах талаар бодолцох нь зүйтэй гэж үзнэ (Шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагын тухай 5.6-р дэд хэсгийг харна уу).
83. Шүүгчийн ёс зүйн хувьд, мэргэжлийн ёс зүйтэй эсвэл шүүхийн бус үйл ажиллагаа эрх зүйн статустай нь нийцэж буй эсэхтэй холбоотойгоор тулгарч буй асуудлаар шүүгчдэд зөвлөгөө өгөх зорилгоор шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд нэг эсвэл хэд хэдэн салбар байгууллага/нэгж эсвэл хүмүүс байх нь зүйтэй гэж үздэг.¹⁴⁴ Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан Шүүхийн ёс зүйн хорооны бүрэн эрхийг дээрх зөвлөмжийн дагуу нягталж, эргэж хянаж үзэх хэрэгтэй бөгөөд мэргэжлийн ёс зүйн дүрэм, үүний дотор ашиг сонирхолын зөрчилөөс ангид байх, хэм хэмжээний хүрээнд Ёс зүйн хорооны зөвлөх үүргийг онцлох нь шаардлагатай.¹⁴⁵ Энэ нь одоогоор Шүүхийн Ерөнхий Зөвлөл, шүүхүүдэд ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн дүрэмтэй холбоотой асуудлаар шүүгчдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх мэргэшсэн боловсон хүчин байхгүй нь тулгамдсан асуудал болоод буй нөхцөлд маш чухал ач холбогдолтой болно.¹⁴⁶ Шүүгчдийг ажил үүргээ хэрэгжүүлэх, үндсэн эрх чөлөөгөө эдлэхтэй холбогдох ёс зүйн зарчмуудын талаар мэдлэг олгох, мэргэжлийн болон бусад үйл ажиллагаатай нь холбоотой, ялангуяа олон нийтийн сүлжээний хэрэгслийг ашиглах талаар практик удирдамж өгөх зэрэг зохих сургалтанд хамруулах нь зүйтэй юм.¹⁴⁷ Эдгээр сургалтыг Шүүхийн ёс зүйн хороо зохион байгуулж болох юм. Олон нийтийн сүлжээний хэрэгслийг ашиглах асуудлын хувьд зохистой, зохисгүй зан байдал гэж юу болохыг тодруулж өгөх нь чухал бөгөөд энэ чиглэлд [Шүүхийн ёс зүйн нийтээр дагаж мөрдөх Болонья ба Миланы дүрэм \(2015\)](#) нь тохиромжтой удирдамж болж болох юм.
84. Түүнчлэн, Шүүхийн ёс зүйн хороо эрх мэдлийн бусад салбараас хараат бус байх нь чухал юм. Үүнтэй холбогдуулан есөн гишүүний гурвыг нь Хууль зүй, дотоод хэргийн яам томилж (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.3-р зүйл), түүний бүрэлдэхүүн, дүрэм зэргийг Ерөнхийлөгч баталдаг нь (мөн хуулийн 32.4-р зүйл) тус байгууллагын үйл ажиллагаан дах гүйцэтгэх засаглалын зохисгүй нөлөөлөл/оролцоог үүсгэж байна. Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид Шүүхийн ёс зүйн хорооны

¹⁴⁴ Өмнө нь иш татсан **Error! Bookmark not defined.**-р зүүлт, 97 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)); ба жишээ болгон [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 49 дүгээр догол мөрийг харна уу.

¹⁴⁵ 29 дүгээр догол мөр (ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №3 (2002)).

¹⁴⁶ Өмнө нь иш татсан 5-р зүүлт, 57 дугаар догол мөр (ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг тухай тайлан (2019))-г харна уу. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91-93 дугаар зүйлд шүүгчийг татгалзан гаргах, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг тусгайлан зааж өгсөн болохыг анхаарна уу.

¹⁴⁷ Жишээ болгон [АИХЭГ-ын Казахстаны Шүүгчийн ёс зүйн тухай хуульд өгсөн Тайлбар](#), (2018 оны 12 дугаар сарын 27), 46-50 дугаар догол мөрийг харна уу. Мөн өмнө нь иш татсан 34-р зүүлт, 96 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу.

бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой хуулийн зохицуулалтад Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүргийг дахин хянаж үзэх хэрэгтэй юм. Мөн тус байгууллага нь шүүгч болон шүүгч бус хүмүүсээс бүрдэх нь чухал тул Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.3-р зүйлд тусгасан Шүүгчийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгчийг орохыг хориглосон заалт нь асуудал үүсгэж буй бөгөөд энэ хэсгийг бүхэлд нь дахин хянан үзэх шаардлагатай юм (5.6.1. дэд хэсэг дэх сахилгын байгууллагын бүрэлдэхүүний талаарх тайлбарыг үзнэ үү).

85. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32-р зүйлд Ёс зүйн дүрмийг дурдсан бөгөөд энэ дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллах нь шүүгч бүрийн үүрэг гэж дурдсан байна. Хэдий тийм боловч тус хуульд энэхүү дүрмийг хэрхэн боловсруулж, батлах талаар огт заагаагүй байна. Юутай ч уг дүрмийг шүүхийн байгууллага өөрөө, жишээлбэл Ёс зүйн хорооны ивээл дор нээлттэй, ил тод үйл явцын дагуу, шүүгч нар болон тэдгээрийн төлөөллийн байгууллагуудтай өргөн хүрээнд зөвшилцөж боловсруулах нь чухал юм.¹⁴⁸ Үүнийг хуульд тодорхой тусгах нь зүйтэй юм. Энэ үүднээс НҮБ-ын МБГХТА-ны [Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмуудын талаарх тайлбар](#) (2007) нь мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг боловсруулахад тохиромжтой эх сурвалж болж болох юм.

4.5. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн төсөв ба Ажлын Алба

86. Шүүхийн тухай хуулийн 28.3-р зүйлд шүүхийн төсөв дотор Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн төсөв нь бүрдэнэ гэж заасан байна. Үүний зэрэгцээ Зөвлөлийн хараат бус, шударга байдлыг цаашид баталгаажуулахын тулд Зөвлөл нь санхүүгийн хараат бус байдлын эрх эдлэх ёстой бөгөөд энэ нь өөрийн төсвийг үр ашигтайгаар хэлэлцүүлж, захиран зарцуулах эрхтэй, хүний, санхүүгийн болон материаллаг хангалттай нөөцтэй байх, тэр дундаа өөрийн барилга байгууламжтай байх,¹⁴⁹ бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах боломжийг олгох эрх мэдэл, хүчин чадалтай байх нөхцлийг хангах шаардлагатай гэсэн юм.¹⁵⁰ Энэ нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 5-12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээг харгалзан үзэхэд онцгой ач холбогдолтой юм. Иймд хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид Шүүхийн зөвлөлийн санхүүгийн хараат бус байдлыг хамгаалах хамгаалалтын нэмэлт арга хэмжээнүүдийг нэвтрүүлэх зорилгоор Шүүхийн тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль

¹⁴⁸ 95 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу. Мөн жишээ болгон өмнө нь иш татсан 144-р зүүлт, 48 (ii) дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №3 (2002)); ба өмнө нь 24-р зүүлтэд иш татсан CM/Rec(2010)12 ЕЗ-ийн Зөвлөмжүүд (2010)-ийн 72-74 дугаар догол мөрийг харна уу.

¹⁴⁹ Жишээ болгон өмнө нь иш татсан 34-р зүүлт, 37-38 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)); ба [ЕШЗС-ний Шүүхийн байгууллагын санхүүжилтийн тухай 2015-2016 оны тайлан](#), 2016 оны 6 дугаар сарын 03, 12-13 дугаар хуудсан дээрх Шүүхийн зөвлөлийн Зарчим 3-г харна уу.

¹⁵⁰ 37-40 дүгээр догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)); ба өмнө нь иш татсан 11-р зүүлт, 93 болон 106 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

эсвэл улсын төсөв, санхүүтэй холбоотой бусад холбогдох хууль тогтоомжинд нэмэлт, өөрчлөлт тус тус оруулах тухай асуудлыг хэлэлцэх нь зүйтэй юм.¹⁵¹

87. Мөн хууль эрх зүйн хүрээнд Зөвлөлийн бие даасан үйл ажиллагааг, ялангуяа гүйцэтгэх нарийн бичгийн дарга, ажлын албаны бие даасан байдлыг хангах нь чухал бөгөөд энэ нь Зөвлөлийн бодит бие даасан, хараат бус байдалд нөлөөлж болзошгүй юм. Үүнтэй холбогдуулан **Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь гүйцэтгэх нарийн бичгийн даргыг өөрөө томилж эсвэл сонгон шалгаруулдаг байх тухай нэмэлт, өөрчлөлтийг Шүүхийн захиргааны тухай хуулийн 14.1-р зүйлд оруулах нь чухал юм. Түүнчлэн, Зөвлөлийн ажлын албаны ажилтнуудын эрх зүйн байдлыг хуульд тодорхой зааж өгөхөөс гадна Зөвлөл нь ажлаа аливаа улс төрийн болон бусад байгууллагад тайлагнахгүйгээр өөрөө зохион байгуулдаг, өөрийн болон гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлэн орон тоогоо баталдаг байх зэрэг эрхийг нь хангаж өгөх хэрэгтэй юм.**¹⁵²

5. Шүүгчийн эрх зүйн байдал

88. Монгол Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг харгалзсаныг тэмдэглэх нь чухал юм. Үүнтэй холбогдуулан АИХЭГ нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулинд дүн шинжилгээ хийсэн тул энэхүү Санал дүгнэлтийг дээр дурдсан [Санал дүгнэлтэд](#) тусгасан дүгнэлт зөвлөмжүүдийн хамт уншиж танилцах хэрэгтэй юм. Ямар ч тохиолдолд бие даасан, хараат бус, тал үл харах буюу төвийг сахисан байх гэсэн мэргэжлийн шүүгч, шүүгчдийн бүрэлдэхүүнд тавигддаг бүх шаардлага иргэдийн төлөөлөгч нарт адилхан тавигдана.¹⁵³

5.1. Шүүгчийн бие даасан, хараат бус байдал

89. Ерөнхийдөө үндэсний хууль эрх зүйн хүрээнд *"шүүгчийн шударга байдал"*, *"шүүхийн хараат бус байдал"* гэсэн нэр томъёолол ашиглагдаж байгаа боловч шүүгчийн бие даасан байдлын талаар дурдаахгүй байна. Хараат бус байдлыг хангах шаардлага нь шүүх засаглалын байгууллагад төдийгүй шүүгч бүрт хамаарах бөгөөд¹⁵⁴ шүүхийн эрх мэдлийн байгууллагын ажилтнууд засгийн газар, парламент, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд, бусад шүүгч эсвэл гуравдагч этгээдийн шууд болон

¹⁵¹ *Өмнө нь иш татсан* 67-р зүүлт, 56 дугаар догол мөр (Польш Улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн тухай эцэслэгдсэн Санал дүгнэлт (2017)).

¹⁵² Жишээ болгон *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 38 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007))-г харна уу.

¹⁵³ *Өмнө нь иш татсан* 21-р зүүлт, 66-67 дугаар хуудсан дээрх 3.3.3 дахь дэд хэсэг (АИХЭГ-ын Шударга шүүхээр шүүлгэх олон улсын эрхийн тухай хуулийн лавлах (2012)-г харна уу. Мөн жишээ болгон ЕХЭШ-ийн [Landborger v. Sweden](#) хэрэг (Хэргийн дугаар: 11179/84, 1989 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэр), 34-35 дугаар догол мөр; ба Хүний эрхийн хорооны [Wilson v. Australia](#) хэрэг, Хэргийн дугаар: 1239/2004, UN Doc CCPR/ C/80/D/1239/2004 (2004), шүүх хуралтай холбогдолтой 4.4 дэх догол мөрийг харна уу.

¹⁵⁴ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар, [Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах хүний эрхийн асуудал: Хүний эрхийн асуудлаар шүүгч, прокурор ба хуульчдад зориулсан гарын авлага](#) (2003), Дөрөвдүгээр бүлэг: Шүүгч, прокурор, хуульчдын бие даасан, хараат бус байдал, 123 дугаар хуудас.

шууд бус нөлөөллөөс ангид байх байдлыг хангах нь чухал юм.¹⁵⁵ **Шүүгчийн бие даасан, хараат бус байх зарчмыг шүүх засаглалтай холбоотой бүхий л хууль тогтоомжид илүү сайн тусгахыг зөвлөж байна.** Тухайн байгууллагын бие даасан эсэх байдалд үнэлгээ өгөхөд тус байгууллагын хөндлөнгөөс бие даасан байдал нь харагдаж, дүгнэгдэх байдал нь чухал бөгөөд гадны нөлөөлөл, хөндлөнгийн оролцоо орсон байж болзошгүй гэх таамаг төдий ялимгүй магадлал нь шүүхийн бие даасан байдлыг бүхэлд нь алдагдуулахад хангалттай байж болно гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.¹⁵⁶

90. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах баталгааг тодорхой зааж өгсөн байна. Тус хуулийн 27.1-р зүйлд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг тусгайлан хориглосон байна. Үүний зэрэгцээ, хуулинд дээр зөрчилтэй холбогдох шийтгэл оногдуулах талаар заагаагүй нь тус заалтыг ердөө хүсэл эрмэлзэл илэрхийлсэн төдий заалт болгож буй юм. **Бусад хууль тогтоомжид өөрөөр заасан бол холбогдох лавлагааг оруулахыг, үгүй бол оногдуулах шийтгэлийн талаар тодорхой тусгахыг тус тус зөвлөж байна.**
91. Түүнчлэн, шүүгч шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх байдлыг хангах нь нэн чухал юм.¹⁵⁷ **Энэ зарчмыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой тусгаж болох юм** (сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийн талаарх 146-р догол мөрийг үзнэ үү).

5.2. Шүүгчийн эрх

92. Ерөнхийдөө Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хуулиудад шүүгчийн эрхийн асуудал огт тусгагдаагүй бөгөөд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.2, 28.1.2-т үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй холбоотой эрх чөлөөг нь хязгаарласан байна (95-98-р догол мөрийг үзнэ үү). Зарчмын хувьд бусад хувь хүмүүсийн адил шүүгч нар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, тайван

¹⁵⁵ Өмнө нь иш татсан 13-р зүүлт, 19 дүгээр догол мөр (НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ерөнхий тайлбар №32, (2007)).

¹⁵⁶ Өмнө нь иш татсан 21-р зүүлт, 61 дүгээр хуудас (АИХЭГ-ын Шударга шүүхээр шүүлгэх олон улсын эрхийн тухай хуулийн лавлах (2012)-г харна уу. Мөн харьцуулалт хийх зорилгоор Европын Хүний эрхийн шүүх (ЕХЭШ), [Campbell and Fell v. the United Kingdom](#) хэрэг (Хэргийн дугаар: 7819/77, 7878/77, 1984 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэр), 78 дугаар догол мөрийг харна уу. Түүнчлэн [Olujic v. Croatia](#) хэрэг (Хэргийн дугаар: 22330/05, 2009 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн шийдвэр), 38 дугаар догол мөр; [Oleksandr Volkov v. Ukraine](#) хэрэг (Хэргийн дугаар: 21722/11, 2013 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэр), 103 дугаар догол мөр; [Morice v. France](#) [GC] хэрэг (Хэргийн дугаар: 29369/10, 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн шийдвэр), 78 дугаар догол мөр; засаглалын бусад салбартай шүүх эрх мэдэл хэрхэн холбогдох талаар: [Baka v. Hungary](#) [GC] хэрэг (Хэргийн дугаар: 20261/12, 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэр), 165 дугаар догол мөр; [Ramos Nunes de Carvalho E Sá v. Portugal](#) [GC] хэрэг (Хэргийн дугаар: 55391/13, 57728/13 ба 74041/13, 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн шийдвэр), 144 дүгээр догол мөр; [Guðmundur Andri Ástráðsson v. Iceland](#) хэрэг (Хэргийн дугаар: 26374/18, 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн шийдвэр), 100-103 дугаар догол мөрийг харна уу.

¹⁵⁷ Өмнө нь иш татсан 10-р зүүлт, Зарчим 5 (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд (2002)); ба өмнө нь иш татсан 22-р зүүлт, 183-191 дүгээр догол мөр (НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн Тайлбар (2007))-г харна уу.

жагсаал, цуглаан хийх, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох эрх нь чөлөөтэй байна (ЭЗЗХ-ийн 9-11 дүгээр зүйл, ИБУТЭОУП-ын 18-22 дугаар зүйлүүд).¹⁵⁸ Үүнтэй холбогдуулан Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай үндэсний холбогдох хууль тогтоомжинд шүүгчдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх, мөн бусадтай адил эрх тэгш байх үндсэн дээр улс төрийн эрх эдлэхийг нь хүлээн зөвшөөрсөн тодорхой заалтуудыг тус тус тусгахыг зөвлөсөн болно. Мөн шүүгчийн эдгээр эрхийг хязгаарлах нь ардчилсан нийгэм дэх шүүх засаглалын бүрэн эрх, шүүгчийн бие даасан, шударга байдлыг хадгалахад чиглэгдэхэд зайлшгүй шаардлагын хүрээнд байж болох үйлдэл юм.¹⁵⁹

93. Дээр дурдсан эрхийн аливаа хязгаарлалт нь гурван хэсгээс бүрдэх шалгуурыг хангаж байх, өөрөөр хэлбэл “хуулиар тогтоосон байх”, хүний эрхийн олон улсын хуулийн дагуу “хууль ёсны зорилгод” нийцэж байх (ИБУТЭОУП –ын 18(3), 19(3), 21 ба 22(2)-р зүйл), “ардчилсан нийгэмд зайлиггүй шаардлагатай” байх, улмаар нийгмийн тулгамдсан хэрэгцээ, шаардлагад нийцэж байх ёстой юм. Бие даасан, тал үл харах буюу төвийг сахисан, шударга байдлыг баримтлах зарчим нь шүүгчдээс албан тушаалынхаа нэр төр, шүүхийн шударга, хараат бус байдлыг бүх цаг үед хадгалаж байхыг шаарддаг.¹⁶⁰ Бүх цаг үед олон нийтийн хяналт дор байдаг тул шүүгчид энгийн иргэдэд дарамттай санагдаж болох зарим хувийн хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх ёстой боловч¹⁶¹ энэ нь олон улсын хүний эрхийн стандартуудад нийцэж буй тохиолдолд шүүх засаглалын шударга, хараат бус байдлыг хамгаалах үйлсээр зөвтгөгдөж болох юм.
94. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28-р зүйлд шүүгчийн иргэний болон улс төрийн эрхэд хязгаарлалт тогтоосон заалтууд байгаа бөгөөд эдгээрийг шүүгчид хориглох олон тооны үйлдлийг жагсаасан мөн хуулийн 27 дугаар зүйлтэй хамт унших нь зүйтэй юм.
95. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1-р зүйлд шүүгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхтэй холбогдуулан хориглох хэд хэдэн үйлдлийг тусгасан байна. Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь ИБУТЭОУП-ын 19.3-т заасны дагуу хязгаарлагдаж болох бөгөөд эдгээр хязгаарлалт нь заавал хуулиар

¹⁵⁸ Өмнө нь иш татсан 11-р зүүлт, Зарчим 8 (Шүүхийн хараат бус байдлын тухай НҮБ-ын үндсэн зарчим (1985)), үүнд шүүгч хувь хүний хувьд “үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх, цуглах эрх чөлөө эдлэх ба ийнхүү эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчид албан тушаалынхаа нэр төр, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хадгалахын тулд үргэлж зохих ёсоор биеэ авч явах ёстой” гэж заасныг харна уу. Мөн өмнө нь иш татсан 34-р зүүлт, 66 ба 110-111 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)); ба харьцуулалт хийх зорилгоор өмнө нь иш татсан 34-р зүүлт, 42 дугаар догол мөр (ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №18 (2015)); [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба харьцуулалтын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 27-36 дугаар догол мөр; ба [Венецийн Комиссын Шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай тайлан](#) (2015 оны 6 дугаар сарын 23)-г харна уу.

¹⁵⁹ 93 болон 101 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

¹⁶⁰ Жишээ болгон [АИХЭГ-ын Казахстаны Шүүгчийн ёс зүйн тухай хуульд өгсөн Тайлбар](#), (2018 оны 12 дугаар сарын 27), 36 дугаар догол мөрийг харна уу. Мөн өмнө нь иш татсан 11-р зүүлт, Зарчим 8 (Шүүхийн хараат бус байдлын тухай НҮБ-ын үндсэн зарчим (1985))-г харна уу.

¹⁶¹ Өмнө нь иш татсан 12-р зүүлт, Зарчим 4.2 (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмууд (2002))-г харна уу.

тогтоогдсон байх ёстой бөгөөд бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх эсвэл үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой юм. Шүүгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хууль ёсны хязгаарлалт нь нууцлалын зарчмаас үүдэлтэй бөгөөд энэ нь шүүгчдийн үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээлэл болон албан ажлын шаардлагаар мэргэжлийн нууцыг хадгалах үүрэгтэй нь холбоотой байдаг юм.¹⁶² Мэргэжлийн нууцлал гэдэг нь хараат бус байдал, шударга байдлыг хангах үүднээс шүүгчид одоо хянан хэлэлцэгдэж байгаа эсвэл өмнө нь хэлэлцэгдсэн хэргүүдийн талаарх өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхээс татгалзах ёстой гэсэн үг юм.¹⁶³ Үүнтэй холбогдуулан дээрх хуулийн 27.1-р зүйлд заасан зарим хязгаарлалт нь хэргийн нууцлал, мэргэжлийн нууц хадгалах зарчимтай холбоотой ба ардчилсан нийгэмд шаардлагатай гэж үзсэн хязгаарлалтуудтай бүрэн нийцэж буй юм (жишээ нь: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27.1.2, 27.1.3, 27.1.5-р зүйлийг үзнэ үү).

96. Үүний зэрэгцээ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.2-р зүйлд “*улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд улс төр, шашны асуудлаар байр сууриа илэрхийлэхийг*” хориглосон байна. Ийнхүү томъёолох нь хэтэрхий ойлгомжгүй ба “*улс төр, шашны асуудал*” гэсэн ойлголт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд олон янзаар, дур зоргоороо тайлбарлах боломжийг бүрдүүлж, улмаар олон улсын хүний эрхийн стандартад заасан хууль эрх зүйн тодорхой байдал, урьдчилан таамаглах шаардлага зэргийг хангахгүй байна.¹⁶⁴ Харин тодорхой хэрэг шүүн хянах явцад шүүгчдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нь хязгаарладаг тохиолдлууд байдаг ба энэ нь шүүх, тусгай шүүх зэрэг нь “*хараат бус, тал үл харах буюу төвийг сахисан*” байх ёстой гэсэн олон улсын хууль тогтоомжийн шаардлагаас үүдэн гардаг байна. Мөн өрөөсгөөл хандлагаа гаргасан гэх хардлагаас ангид байхын сацуу “*тусгай шүүх нь төвийг сахисан шүүх гэдэг нь ажиглагчидад харагдаж байх ёстой*”¹⁶⁵ гэсэн үг юм. Тиймээс шүүгчид олон нийтийн өмнө “*төвийг сахисан, хашир, хянуур байх*” үүрэг хүлээдэг бөгөөд энэ нь “*шүүх эрх мэдэл, шударга байдлыг эргэлзээтэй байдалд оруулж болзошгүй бүх тохиолдолд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэхдээ хязгаарлалт тавина*” гэсэн хүлээлтийг илэрхийлж буй юм.¹⁶⁶ Иймд шүүгч нар хэргийн талаар тайлбар өгөхөөс зайлсхийх хэрэгтэй¹⁶⁷

¹⁶² Өмнө нь иш татсан 34-р зүүлт, 53 болон 89 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)). Мөн өмнө нь иш татсан 11-р зүүлт, Зарчим 15 (Шүүхийн хараат бус байдлын тухай НҮБ-ын үндсэн зарчим (1985))-г харна уу.

¹⁶³ Өмнө нь иш татсан 34-р зүүлт, 53 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

¹⁶⁴ Өмнө нь иш татсан 139-р зүүлт, 55, 58 ба 61 дүгээр догол мөр (АЙХЭГ-ын Польш улсын Шүүхүүдийн тухай шуурхай урьдчилсан Санал дүгнэлт 2020).

¹⁶⁵ Жишээ болгон өмнө нь иш татсан **Error! Bookmark not defined.**-р зүүлт, 21 дүгээр догол мөр (НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ерөнхий тайлбар №32, (2007)); өмнө нь иш татсан 34-р зүүлт, 42 дугаар догол мөр (ЕШЗ3-ийн Санал дүгнэлт №18 (2015)); ЕШЗ3-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3 (2002), 27-36 дугаар догол мөр; өмнө нь иш татсан 11-р зүүлт, Зарчим 8 (Шүүхийн хараат бус байдлын тухай НҮБ-ын үндсэн зарчим (1985)); өмнө нь иш татсан 34-р зүүлт, 66, 89 ба 110-111 дүгээр догол мөр, Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019); ба [Шүүгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай Венецийн Комиссын тайлан](#) (2015 оны 6 дугаар сарын 23-ны өдөр)-г харна уу.

¹⁶⁶ Өмнө нь иш татсан 34-р зүүлт, 33 ба 101 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

¹⁶⁷ 101-106 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

бөгөөд шүүгчийн үүрэгт үл хамаарах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ нь шүүгчийн тал үл харах буюу төвийг сахисан, хараат бус байдалтай нь нийцэж байх ёстой юм.¹⁶⁸ Үүний зэрэгцээ, Шүүгч, хуульчийн хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн саяхан дахин тэмдэглэснээр шүүгчид улс төрийн эмзэг асуудлаар, тухайлбал шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн хараат бус байдал, эсвэл шударга ёсыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлд шууд нөлөөлж буй хууль тогтоомж, бодлогын талаар тайлбар хийх, байр сууриа илэрхийлэх нөхцөл байдал цөөнгүй гардаг байна.¹⁶⁹ [Шүүхийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмын \(2002\)](#) дагуу хууль, эрх зүйн тогтолцоо, шударга ёсыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар хэвлэн нийтлэх, лекц унших, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд оролцох нь шүүгчийн хүний эрх гэж үздэг.¹⁷⁰ Үүний сацуу Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тэмдэглэснээр тодорхой нөхцөл байдалд буюу ардчилал, шүүхийн шударга, хараат бус байдал, хуулийн засаглал заналхийлэлд өртөж буй нөхцөлд үндсэн хуулийн дэглэмийг хамгаалах, ардчиллыг сэргээх зорилгоор улс төрийн маргаантай сэдвээр шүүгч нар үг хэлэх үүрэгтэй ажээ.¹⁷¹ Хэдийгээр улс төрийн үр дагавартай байж болох ч, шүүгч нар олон нийтийн мэдээлэл авах хууль ёсны эрх ашгийг харгалзан үзэж, тэр дундаа шүүхийн тогтолцооны үйл ажиллагаа, засаглалын эрх мэдлийг зааглах зэрэгтэй холбоотой хууль эрх зүйн шинэчлэл, хууль эрх зүйн актуудын талаарх асуудлыг тавьж, олон нийтэд нээлттэй шүүмжлэх эрхтэй юм.¹⁷² Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт нь шүүхийн тогтолцооны үйл ажиллагаа, шүүх эрх мэдлийн шинэчлэл эсвэл засаглалын эрх мэдлийг зааглах, хууль дээдлэх ёстой холбоотой бусад асуудлаар олон нийтэд тайлбар өгсөн шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг агуулах ёсгүй юм.¹⁷³

97. Дээр дурдсантай холбогдуулан **"улс төрийн асуудлаар"** гэх хэллэгийг хасч, ерөнхийдөө Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.2-р зүйлийн томъёоллыг илүү хатуу хүрээлж, чингэхдээ шүүгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эдлэх ба үүргээ гүйцэтгэхдээ бие даасан, хараат бус, шударга байх шаардлагын хооронд зохистой тэнцвэрийг хангахын сацуу шүүгчийн үзэл бодлоо

¹⁶⁸ *Өмнө нь иш татсан* 24-р зүүлт, 21 дүгээр догол мөр (CM/Rec(2010)12 ЕЗ-ийн Зөвлөмжүүд (2010))-г харна уу.

¹⁶⁹ *Өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 13 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу. Мөн *өмнө нь иш татсан* 12-р зүүлт, 134-140 дүгээр догол мөр (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн НҮБ-ын Тайлбар (2007))-г харна уу.

¹⁷⁰ [Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын](#) 4.11 дэх зарчмыг харна уу.

¹⁷¹ *Өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 90 ба 102 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу. Мөн жишээ болгон харьцуулалт хийх зорилгоор Америк Дундын Хүний Эрхийн Шүүхийн [Lopez Lone et al. v. Honduras](#) хэрэг, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн шийдвэр, 169-173 дугаар догол мөр, ялангуяа, 173 дугаар догол мөрийг харна уу. Мөн ЕШЗС, [Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софишийн тунхаглал](#), 2013 оны 6 дугаар сарын 07, Зарчим (vii) ба [Канадын Шүүгчийн ёс зүйн зарчмуудыг харна уу](#).

¹⁷² 89 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)). Мөн жишээ болгон [АИХЭГ-ын Казахстаны Шүүгчийн ёс зүйн тухай хуульд өгсөн Тайлбар](#) (2018), 42 дугаар догол мөрийг харна уу. Түүнчлэн харьцуулалт хийх зорилгоор *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 42 дугаар догол мөр (ЕШЗС-ийн Санад дүгнэлт №18 (2015)); ба ЕХЭШ-ийн [Baka v. Hungary](#) [GC] хэрэг (Хэргийн дугаар: 20261/12, 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэр), 162-167 болон 171 дүгээр догол мөрийг харна уу.

¹⁷³ Жишээ болгон *өмнө нь иш татсан* 139-р зүүлт, 58 ба 61 дүгээр догол мөр (АИХЭГ-ын Польш улсын Шүүхүүдийн тухай шуурхай урьдчилсан Санал дүгнэлт (2020))-г харна уу.

илэрхийлэх эрх чөлөөнд аливаа хязгаарлалт тавихдаа хууль эрх зүйн тодорхой, зайлшгүй байдал, пропорциональ зарчмуудыг баримталж, ИБУТЭОУП-ын 19-р зүйлд нийцүүлэх шаардлагатай юм. Тухайлбал шүүгчийн хийсэн мэдэгдлүүд нь шударга ёсны тогтолцооны үйл ажиллагаа, шүүх эрх мэдлийн шинэчлэл эсвэл засаглалын эрх мэдлийг зааглах, хууль дээдлэх ёс, хуулийн засаглалтай холбоотой бусад асуудлаар явагдаж буй олон нийтийн хэлэлцүүлгийн нэг хэсэг болж буй тохиолдолд шүүгчийг хамгаалах эсвэл онцгой тохиолдол гэх зүйл заалтыг хуулинд тусгахыг хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид анхаарч үзэх нь зүйтэй болно.

98. “[...]шашны асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх” тухайд, төр төрийн албан хаагчдыг тэдгээрийн эрх зүйн байдлыг харгалзан шашин, шүтлэгээ ил тод олон нийтэд илэрхийлэх, бардамнахаас зайлсхийхийг үүрэгдэх эрхийг төр нь эдлэх нь хуулинд нийцэж болох юм.¹⁷⁴ Иймд шүүх хуралдааны үеэр болон өөрийн ажил үүрэгтэй холбоотой ямарч нөхцөлд шүүгч нар шашин шүтлэг, итгэл үнэмшилээ илэрхийлэх эрх чөлөөгөө хязгаарлаж, шүүхийн бүрэн хараат бус, шударга байдлыг хангах, шүүхэд итгэх итгэл үнэмшлийг хангахад шаардлагатай болно. Мөн шүүгч хувийн үнэт зүйлс, философи, эсвэл итгэл үнэмшилдээ үндэслэн тухайн хэргийг шийдвэрлэсэн гэх эргэлзээг үүсгэх ёсгүй юм.¹⁷⁵ Гэхдээ үүнийг шүүгчийн шударга байдалд эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл үүсгээгүй тохиолдолд ИБУТЭОУП-ын 18-р зүйлд заасны дагуу шүүгчдийн шүүх хуралдааны танхимаас гараад хувийн журмаар сургааль айлдах, хурал мөргөл хийх, шашны болон зан үйлийн ёслол үйлдэх зэрэг шашин шүтлэг, итгэл үнэмшилээ илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй мэтээр тайлбарлаж болохгүй болно.¹⁷⁶ “Улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд илэрхийлэх” гэсэн хориг нь шүүгчийн зөвхөн албан ёсны чиг үүргийн хүрээнд ийнхүү байр сууриа илэрхийлэхэд хамаатай эсэх нь тодорхойгүй байна. Орчуулгын зөрүү гараагүй бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.2-р зүйлд шүүгчид албан үүргээ гүйцэтгэх үед шашны асуудлаар үзэл бодол, итгэл үнэмшил эсвэл бусад хувийн үзэл бодлоо илэрхийлэхэд хязгаарлалт нь хамаарна гэж тодруулга оруулах нь зүйтэй. Ямарч тохиолдолд, эл заалтыг шашны асуудлаар хувийн үзэл бодолтой байх, мөргөл үйлдэх газарт зочлох, итгэл үнэмшилтэй нь шууд холбоотой зан үйлийн болон ёслолын үйл ажиллагаанд оролцоход нь саад учруулж буй мэтээр ойлгож болохгүй юм.¹⁷⁷

¹⁷⁴ Жишээ болгон харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Pitkevich v. Russia](#) хэрэг (Хэргийн дугаар: 47936/99, 2001 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн шийдвэр)-г харна уу.

¹⁷⁵ *Өмнө нь иш татсан* 22-р зүүлт, 60 дугаар догол мөр (НҮБ-ын МБГХТА-ны Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн Тайлбар (2007))-г харна уу.

¹⁷⁶ Жишээ болгон харьцуулалт хийх зорилгоор Хүний эрхийн тухай Европын конвенцийн шүүгчийн шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийн тухай 9 дүгээр зүйлтэй холбоотойгоор ЕХЭШ-ийн [Albayrak v. Turkey](#) хэрэг (Хэргийн дугаар: 38406/97, 2008 оны 01 дүгээр сарын 31-ийн өдрийн шийдвэр), 42 дугаар догол мөр; ба [Wille v. Lichtenstein](#) [GC] хэрэг (Хэргийн дугаар: 28396/95, 1999 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэр), 44 дүгээр догол мөрийг харна уу.

¹⁷⁷ *Өмнө нь иш татсан* 160-р зүүлт, 51-58 дугаар догол мөр (АИХЭГ-ын Казахстаны Шүүгчийн ёс зүйн тухай хуульд өгсөн Тайлбар (2018))-г харна уу. Мөн [Хүний эрхийн хорооны ИБУТЭОУП-ын 18 дугаар зүйлд өгсөн Ерөнхий тайлбар №22](#), 1993, 4 дүгээр догол мөрийг харна уу.

99. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.1-р зүйлд шүүгч нь улс төрийн намд харьяалагдах, 27.1.16-р зүйлд улс төрийн аливаа байгууллагын удирдах болон аливаа “*улс төрийн байгууллагад*” бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага эсвэл сонгуульд аливаа нэр дэвшигчийг дэмжих, сонгуулийнх нь сурталчилгаанд оролцох, эсвэл улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт олж өгөх, санхүүжүүлэх, хандив өгөх зэргийг хориглосон байна. Шүүхийн тухай хуулийн 27.4-р зүйлд шүүгч болон шүүхээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй шүүхийн ажилтан нь аливаа улс төрийн нам эсвэл “*улс төрийн хөдөлгөөний*” гишүүн байхыг хориглосон байна. Энэ заалт нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн заалтаас арай өөрөөр найруулагдсан байна. **Аливаа будлиан гарахаас зайлсхийхийн тулд найруулгыг нь холбогдох хуулинд нийцүүлэх, эсвэл бусад хуулийг нь иш татахыг зөвлөж байна.**
100. Шүүгчийн хараат бус, тал үл харах буюу төвийг сахих байдлыг хангахын тулд, нэн ялангуяа улс төрийн хувьд төвийг сахих шаардлагатай үед үндэслэлтэй байх ч, шүүгчид бусад хувь хүмүүсийн адил эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй байна.¹⁷⁸ АИХЭГ болон Венецийн Комиссын зүгээс “*холбоо байгуулах эсвэл эвлэлдэн нэгдэх нь төрийн албан хаагчийн үүрэгтэй зөрчилдөх ба/эсвэл тодорхой төрийн албан тушаалтнуудын улс төрөөс ангид/төвийг сахисан байх зарчимд халдах тохиолдолд*” зарим төрийн албан тушаалтнуудын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахыг тусгайлан хүлээн зөвшөөрч байна.¹⁷⁹ Энэ үүднээс шүүгч нарын улс төр дэх оролцоо болон улс төрийн намд харьяалагдах нь тэдгээрийн бие даасан, хараат бус байдал, шударга байдлыг хангах, засаглалын эрх мэдлийг зааглах зэрэгт асуудал үүсгэж болзошгүй юм.¹⁸⁰ Шүүгч нар улс төрийн намын гишүүн байх эрхтэй эсэх талаар олон улсын түвшинд зөвшилцөлд хүрээгүй боловч,¹⁸¹ засаглалын эрх мэдлийг зааглах, шүүхийн хараат бус байдлыг хадгалахын тулд шүүгч нар олон нийтийн улс төрийн үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх нь зүйтэй¹⁸² бөгөөд бие даасан байдлыг харагдуулахад ч чухал юм.¹⁸³ Тиймээс улс төрийн намын гишүүнчлэлтэй холбоотой хязгаарлалтыг хүлээн зөвшөөрч болохуйц байна.
101. Үүний зэрэгцээ, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.1-р зүйлд “*харьяалагдах*” гэх томъёолол нь улс төрийн намд гишүүнчлэлтэй байхыг эсвэл түүний үйл ажиллагаа, хурал зэрэгт нь оролцохыг эсвэл бусад зүйлсийг хэлж буй нь тодорхойгүй байна. Түүнчлэн “*улс төрийн байгууллага*” гэсэн нэр томъёо нь

¹⁷⁸ Жишээ болгон төрийн албан хаагчидтай ерөнхийд нь холбоотойгоор ЕХЭШ-ийн [Ahmed and Others v. United Kingdom](#) хэрэг (Хэргийн дугаар: 22954/93, 1998 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн шийдвэр), 53 ба 63 дугаар догол мөрийг харна уу.

¹⁷⁹ Жишээ болгон [АИХЭГ-Венецийн Комиссын Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай хамтарсан удирдамж](#) (2014), 144 дүгээр догол мөрийг харна уу.

¹⁸⁰ Жишээ болгон [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 30 дугаар догол мөрийг харна уу.

¹⁸¹ *Өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 60, 64 ба 109 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу.

¹⁸² 110 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

¹⁸³ 66 ба 111 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)). Мөн [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 27-36 дугаар догол мөрийг харна уу.

ойлгомжгүй бөгөөд энэ нь үйлдвэрчний эвлэл,¹⁸⁴ буяны байгууллага, их сургууль болон сургуулийн зөвлөл, шашны байгууллага, эмнэлгийн зөвлөл гэх мэт төрөл бүрийн ашгийн бус байгууллагад нэгдэхэд нь саад болох ёсгүй юм.¹⁸⁵ Үүний нэгэн адил Шүүхийн тухай хуулийн 27.4-р зүйлд заасан “улс төрийн хөдөлгөөн” гэсэн нэр томъёо нь их өргөн хүрээтэй, харьцангуй ойлголт тул ямарч тохиолдолд хувь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхээр хамгаалагдсан шүүгчийн эвлэлдэн нэгдэх эрх болон олон нийтийн ашиг сонирхлын асуудлаар хэлэлцүүлэгт оролцох, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн хөдөлгөөнүүдийг дэмжих зэрэг эрхийг нь хязгаарлах замаар практик дээр буруу тайлбарлагдаж болзошгүй байна. **Орчуулгын зөрүү гараагүй бол Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан “харьяалагдах” болон “улс төрийн байгууллага” гэсэн томъёоллыг тодорхой болгож, Шүүхийн тухай хуулийн 27.4-р зүйлд “улс төрийн хөдөлгөөн” нэр томъёог хасахыг зөвлөж байна. Ингэснээр шүүгч нарт дээр дурдсан ашгийн бус байгууллагуудаас гадна өөрсдийн эрх ашгийг хамгаалах мэргэжлийн байгууллагыг байгуулж, тэдгээрт нэгдэх нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэ нь шүүгчдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлахад хүргэж болзошгүй зүй бус тайлбаруудыг практик дээр ашиглахаас урьдчилан сэргийлэх болно** (шүүхийн ажилтнуудад хориглогдох зүйлсийн талаар 7-р дэд хэсгийг үзнэ үү).

102. Хуулинд мөн улс төрийн сонгуульд нэр дэвшихийг хүссэн шүүгч нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах бөгөөд ийнхүү албан тушаалаасаа чөлөөлөгдсөний дараа гурван жилийн хугацаанд дахин шүүгчээр ажиллах хүсэлт гаргахыг хориглосон заалтууд орсоныг тэмдэглэж байна. (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.2-р , 28.3-р зүйл). Энэхүү арга хэмжээ нь эрх мэдлийн салбарууд хоорондоо холилдсон гэх ойлголтоос зайлсхийхэд туслах юм. Нөгөөтэйгүүр, бие даагч шүүгч сонгогдоогүй тохиолдолд дээрх гурван жилийн хугацаа нь хэтрүүлсэн хугацаа эсэхийг бодолцож үзэх хэрэгтэй асуудал. Зарим тогтолцоонд сонгуульд нэр дэвших хүсэлтээ илэрхийлсэн шүүгчийг албан тушаалаас нь түр түдгэлзүүлж, сонгогдоогүй тохиолдолд албан тушаалд нь эгүүлэн томилдог байна. **Тиймээс хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж ийм хязгаарлалт нь үндэслэлтэй, пропорциональ эсэхт үнэлгээ өгөх нь зүйтэй юм.**
103. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1.3- р зүйлд шүүгчийн хөдөлмөрийн маргаанаа зохицуулах зорилгоор албан үүргээ орхих эсвэл зогсоох буюу ажил хаях эрхийг нь хязгаарласан байна. НҮБ-ын МБГХТА-ны [Шүүхийн ёс зүй талаарх Бангалорын зарчимуудад өгсөн тайлбар\(2007\)](#) “шүүгчийн ажил нь олон нийтэд болон үндсэн хуулийн хүрээнд үйлчилдэг онцлогийг харгалзан [...] ажил хаях эрхэд нь хязгаарлалт тавьж болно” гэж заасан боловч энэ нь шүүгчдийн мэргэжлийн ашиг

¹⁸⁴ Өмнө нь иш татсан 22-р зүүлт, 176 дугаар догол мөр (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн НҮБ-ын Тайлбар (2007)).

¹⁸⁵ 167 дугаар догол мөр (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн НҮБ-ын Тайлбар (2007)).

сонирхлыг төлөөлөх, хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл, холбоо байгуулах эсвэл тэдгээрт нэгдэхэд нь шүүгч нарт саад болох ёсгүй юм.¹⁸⁶

104. Шүүгч шударга бус байдал гаргаж буй гэсэн ойлголтыг төрүүлж болзошгүй тул шүүгч нар нь арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, үндэс угсаа, гарал үүсэл, бэлгийн чиг хандлагаар ялгаварлан гадуурхдаг аливаа байгууллагад гишүүнчлэлтэй байх нь зохимжгүй юм.¹⁸⁷ Тиймээс **энэхүү хязгаарлалтыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд тусгаж болно гэж үзнэ.**
105. Эцэст нь хэлэхэд шүүгчдэд үндсэн эрх чөлөөгөө эдлэж, хэрэгжүүлэх талаар тодорхой удирдамжийг боловсруулж, Ёс зүйн дүрэм эсвэл мэргэжлийн стандартын тухай бусад удирдамжинд дэлгэрэнгүй тусгах нь зохимжтой байж болох юм.¹⁸⁸

5.3. *Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, халдашгүй байдлын баталгаа*

106. Үндсэн хуулийн 51.4-р зүйлд “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэж заасан байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20.4.4-р зүйлд, хуульд өөрөөр заагаагүй бол, шүүгчийг тодорхойгүй хугацаагаар томилно гэсэн байна. Хуульд туршилтын хугацаанд эсвэл хязгаарлагдмал мандаттай шүүгч томилох бусад тохиолдлыг тусгаагүй нь сайшаалтай. Хэдий тийм боловч, “хуульд өөрөөр заагаагүй бол” гэх томъёолол нь шүүгчээр тодорхой хугацаанд яаралтай томилогдох тохиолдлыг хэлж буй эсэх, эсвэл хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох тохиолдлуудад хамаарч буй эсэх гэсэн хоёрдмол утгыг илэрхийлж буй тул бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгоход хүргэж болзошгүй нөхцөл байдлыг хуульд тодорхой, нарийвчлан зааж өгөх нь зүйтэй юм. Шүүгчийн тэтгэвэрт гарах насны хязгаар хүртэлх хугацаагүй томилгоог эсвэл бүх насаар нь шүүгчээр томилсон тодорхой хугацаагүй томилгоог хуулиар тогтоосон сахилгын болон эрүүгийн заалтыг ноцтой зөрчсөн, шүүгч цаашид албан үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон, шүүгч эрт тэтгэвэрт гарах, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан зэрэг тохиолдолд л цуцална.¹⁸⁹ **Дээр дурдсан тохиолдлуудад бүрэн эрхийг нь дуусгавар болгохтой холбогдох заалтуудтай холбогдох хуулийн эшлэлийг оруулж өгөх нь чухал болно.** Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах зорилгоор болон хуулийн заалтыг урвуулан хэрэглэхээс зайлсхийхийн тулд шүүгчийг албан

¹⁸⁶ Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудын 4.13 дахь зарчим; ба *өмнө нь иш татсан* 22-р зүүлт, 176 дугаар догол мөр (Шүүгчийн ёс зүйн тухай Бангалорын зарчмуудад өгсөн НҮБ-ын Тайлбар (2007))-г харна уу. Мөн *өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 108 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу.

¹⁸⁷ *Өмнө нь иш татсан* 34-р зүүлт, 60 дугаар догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019)).

¹⁸⁸ Жишээ болгон 94 дүгээр догол мөр (Шүүгч, хуульчдын бие даасан байдлын тухай НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан (2019))-г харна уу.

¹⁸⁹ *Өмнө нь иш татсан* 11-р зүүлт, Зарчим 12 (Шүүхийн хараат бус байдлын тухай НҮБ-ын үндсэн зарчим (1985))-г харна уу. Мөн жишээ болгон *өмнө нь иш татсан* 24-р зүүлт, 49-50 дугаар догол мөр (Шүүгчдийн талаар Европын Зөвлөлийн CM/Res (2010)12 зөвлөмж: Хараат бус байдал, үр ашиг, хариуцлага (2010))-г харна уу.

тушаалаас нь хугацаанаас нь өмнө чөлөөлөх үндэслэлүүдийг холбогдох хуулинд бус харин Үндсэн хуулинд тусгахыг зөвлөж байна.

107. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26-р зүйлд шүүгч халдашгүй эрхтэй бөгөөд халдашгүй байдалд нь албаны болон хувийн байр, албаны болон хувийн тээвэр, холбооны хэрэгсэл, өөрийнх нь мэдэлд байгаа ачаа тээш, бусад эд хөрөнгө болон бичиг баримт зэрэг хамаарна гэж заасан байна (26.2-р зүйл). Зарчмын хувьд хууль тогтоомж нь шүүгчийн үүргээ хэрэгжүүлэх явцад гаргаж буй (хууль ёсны) үйлдэлтэй холбоотой үйл ажиллагааны халдашгүй байдлыг хамгаалах ёстой бөгөөд энэ нь шүүгчийн эсрэг хохирогч тал, түүний дотор төрийн байгууллагуудын зүгээс эрүүгийн болон иргэний хэрэг үүсэх айдасаас болж бие даасан шийдвэр гаргах чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэх боломжийг хангахад нь чухал үүрэг гүйцэтгэнэ.¹⁹⁰ Шүүгчийн халдашгүй эрх, байдлын талаарх үүний дотор шүүн таслах ажил эрхэлж байх үед нь түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглосон хууль эрх зүйн зохицуулалт, болон энэхүү халдашгүй эрхийг нь хамгаалсан хууль эрх зүйн зохицуулалт хоёрыг салгаж үзэх нь зохистой болно. (халдашгүй байдлыг түдгэлзүүлэх журмын тухай 110-р догол мөрийг харна уу).
108. Дээрх хуулийн 26.3-р зүйлд шүүгч эрх мэдлээ урвуулан ашигласан, илт хууль бус тогтоол, шийдвэр, шүүхийн бусад акт гаргасан нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор нотлогдоогүй бол бүрэн эрхийнхээ хугацаанд болон бүрэн эрх нь дуусгавар болсны дараа шүүн таслах ажил эрхэлж байх үедээ илэрхийлсэн санал, гаргасан шийдвэрийнх нь төлөө түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглоно гэж заасан байна. Энэ нь үйл ажиллагааны халдашгүй байдлыг хангаж буй тул уг заалтыг сайшааж байна. Учир нь эрх мэдлээ урвуулан ашиглах эсвэл “илт хууль бус” үйлдэл гаргах зэрэг нь тусгайлан харгалзаж үзэх тохиолдлууд тул үйл ажиллагааны халдашгүй байдал нь өөрөө төгс төгөлдөр зүйл биш юм. Гэсэн хэдий ч “илт хууль бус” шийдвэр эсвэл шүүхийн бусад акт гэж юу болохыг тодорхой тусгаж өгөөгүй байна. Шүүгч нь хуулийн ялгаатай тайлбар зэрэг шүүхийн алдааны хариуцлагыг бие даан хүлээх ёсгүй бөгөөд шүүгчийн гаргасан шийдвэрийг дээд шатны шүүхэд хэрэгсэхгүй болгосныг үндэслэн түүний гаргасан тухайн шийдвэрийг хууль бус гэж тодорхойлох хангалттай үндэслэл болохгүйг тэмдэглэх нь зүйтэй гэж үзнэ.¹⁹¹ Ийм ойлгомжгүй, тодорхой бус, өргөн утга агуулж буй заалт нь шүүгчид хараат бус, шударга байдлаар хуулийг тайлбарлах, баримтыг дүгнэх, нотлох баримтыг нарийн нягт үнэлэхэд саад учруулж болзошгүй ба тус заалтыг хэргийг таслан шийдвэрлэх явцад шүүгчдэд дарамт

¹⁹⁰ Жишээ болгон Шүүгч, хуульчдын бие даасан байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн Шүүгчийн хариуцлагын тухай ойлголтын талаарх тайлан, [A/HRC/26/32](#), 2014 оны 4 дүгээр сарын 28, 52 дугаар догол мөрийг харна уу. Мөн өмнө нь иш татсан 89-р зүүлт, 37 ба 41 дүгээр догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014)); өмнө нь иш татсан 190-р зүүлт, 19 дүгээр догол мөр (Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт (2013)); [ЕШЗЗ-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3](#) (2002), 52 дугаар догол мөр; ба ЕХЭШ-ийн [Ernst v. Belgium](#) хэрэг (Хэргийн дугаар: 33400/96, 2003 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэр), 85 дугаар догол мөрийг харна уу. Үүнд шүүгчдийн бие даасан байдлыг хангахын тулд тэдгээрийн эсрэг гомдол гаргахыг хориглосон нь ашигласан арга хэрэгсэл, тавьсан зорилгын хоорондох зохистой пропорциональ байдлын шаардлагыг хангасан гэж үзсэн болно.

¹⁹¹ Жишээ болгон [Шүүгчдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар Үндсэн хуулийн цэцэд бэлтгэсэн Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт](#), CDL-AD(2017)002, 49 дүгээр догол мөрийг харна уу.

үзүүлэх зорилгоор ашиглах, улмаар гаргасан шийдвэрийг нь "илт хууль бус" гэж үзнэ хэмээн айдаст нь нөлөөлж, тэдний хараат бус, шударга байдлыг алдагдуулахад хүргэж болзошгүй юм.¹⁹² Тиймээс орчуулгын зөрүүгээс болж үл ойлголцол гараагүй бол үүний оронд санаатайгаар эсвэл илт хайхрамжгүй байдал гаргахтай холбон дээрх заалтын томъёоллыг тодруулан найруулахыг зөвлөж байна. Ямар ч тохиолдолд шүүгч албан үүргээ гүйцэтгэхдээ гэмт хэрэг үйлдсэн бол үйл ажиллагааны халдашгүй байдлыг нь түдгэлзүүлэх нь зүйтэй юм.¹⁹³ Монгол Улсад авлигатай тэмцэх шаардлага нь тулгамдсан асуудал болоод буйг харгалзан¹⁹⁴ тус хуульд үйл ажиллагааны халдашгүй байдлын хамрах хүрээнд хээл хахууль, авлига, ашиг сонирхолын зорилгоор нөлөөлөл үзүүлэх зэрэг нь хамаарахгүй болохыг тусгаж өгөх нь зүйтэй гэж үзнэ.¹⁹⁵ Үйл ажиллагааны халдашгүй байдлын хамрах цар хүрээг багасгасан ч (жишээ нь, хээл хахууль, авлига, ашиг сонирхолын зорилгоор нөлөөлөл үзүүлэх зэрэг эрүүгийн гэмт хэргийг хасах замаар) ажлын байрандаа гэмт хэрэг үйлдсэн гэхтэй нь холбогдуулан айлган сүрдүүлэх зэргээс шүүгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс зарим урьдчилан сэргийлэх процедурын арга хэмжээнүүдийг хуулиар тогтоож өгөхийн сацуу зөвхөн зохих үндэслэл бүхий нэхэмжлэл, гомдлыг хянан шийдвэрлүүлэхэд л шүүхийн зөвлөлийн зөвшөөрлийг авч байх нөхцлийг хангах шаардлагатайг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.¹⁹⁶

109. Эцэст нь хэлэхэд халдашгүй байдалд шүүгчийн албан үүргээ гүйцэтгэж буй үед төдийгүй хувийн амьдралдаа хийж буй аливаа үйлдэлийг нь мөн хамаардаг эсэх нь тодорхойгүй байна. Зарчмын хувьд шүүгчийн чиг үүргийг гүйцэтгээгүй байх үедээ шүүгч бусад энгийн иргэдийн адил иргэний, эрүүгийн, захиргааны хуулийн дагуу хариуцлага хүлээх ёстой юм.¹⁹⁷ Гэхдээ шүүгчид дарамт шахалт үзүүлэх зорилгоор түүний эсрэг гаргасан үндэслэлгүй, хуурамч, санаатай хэрэг тулгалт эсвэл гомдлоос (урьдчилан сэргийлэх процедурын арга хэмжээнүүдийн талаар доороос харна уу) хамгаалах зорилгоор 110-р догол мөрөнд дурдсан зарим урьдчилан сэргийлэх

¹⁹² 48 дугаар догол мөр (Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт (2017)).

¹⁹³ *Өмнө нь иш татсан* 26-р зүүлт, 61 дүгээр догол мөр (Венецийн Комиссын Шүүхийн тогтолцооны бие даасан байдлын тухай тайлан (2010), Нэгдүгээр хэсэг – Шүүгчдийн бие даасан байдал), үүнд "[шүүгчид] үйл ажиллагааны – гэхдээ зөвхөн үйл ажиллагааны – халдашгүй эрхтэй байх ёстой (авлига, хээл хахууль гэх мэт санаатай гэмт хэргээс бусад чийш үүргээ гүйцэтгэхдээ хэрэгжүүлсэн үйлдэлтэй нь холбогдуулан хэрэг үүсгэхийн эсрэг халдашгүй эрх)" гэж заасныг; мөн 1993 оны 12 дугаар сарын 12-нд бүх нийтийн санал хураалтаар батлагдсан ОХУ-ын Үндсэн хуульд (Долдугаар бүлэг: Шударга ёс: 118-129 дүгээр зүйл) өгсөн Венецийн Комиссын Санал дүгнэлт (1994)-ийн 3 дугаар догол мөрийг үзнэ үү.

¹⁹⁴ *Өмнө нь иш татсан* 5-р зүүлт, 57 дугаар хуудас (ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг тухай тайлан (2019)).

¹⁹⁵ *Өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 42, 59-61 догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014)).

¹⁹⁶ 42 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014)).

¹⁹⁷ 50 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын БНКиргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014)). Мөн жишээ болгон өмнө нь иш татсан 24-р зүүлт, 71 дүгээр догол мөр (Шүүгчдийн талаар Европын Зөвлөлийн CM/Res (2010)12 зөвлөмж: Хараат бус байдал, үр ашиг, хариуцлага (2010)), үүнд "Шүүхийн чийш үүргийг хэрэгжүүлээгүй байх үедээ шүүгчид бусад иргэний адил иргэний, эрүүгийн, захиргааны хуулийн дагуу хариуцлага хүлээнэ" гэж заасныг харна уу. Мөн ЕШЗ3-ийн Шүүгчдийн ёс зүй ба хариуцлагын тухай Санал дүгнэлт №3 (2002), 75 дугаар догол мөрд "i) шүүгчийн албан тушаалаас гадуур үйлдсэн гэмт хэрэгт шүүгчид ердийн хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой; ii) үүргээ гүйцэтгэхдээ санаатай бус алдаа гаргасны төлөө шүүгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёсгүй" гэж заасныг харна уу. Түүнчлэн өмнө нь иш татсан 190-р зүүлт, 53 дугаар догол мөр (Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт (2013))-г харна уу.

процедурын арга хэмжээнүүдийг авч болох юм. **Үүнийг дээрх хуулийн 26-р зүйлд тодруулах нь зүйтэй.**

110. Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хуулийн зохицуулалтын талаар (процедурын халдашгүй байдал) дээрх хуулийн 26.7-26.9-р зүйлд шүүгчийг *гэмт үйлдлийн явцад, гэмт хэргийн газарт* нь баривчилсан тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл Ерөнхийлөгчид гаргаж, Ерөнхийлөгч ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэх зэрэг процедурын тусгай арга хэмжээг тусгасан байна. Иймд хуулиар зөвхөн *гэмт үйлдлийн явцад, гэмт хэргийн газарт* нь баривчилсан тохиолдолд л шүүгчийн халдашгүй байдлыг түдгэлзүүлэхээр тогтоосон байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд халдашгүй байдлыг түдгэлзүүлэх бусад тохиолдлыг тодорхойлоогүй байна. Ийм процедурын хамгаалалтын үндэслэл нь шүүгчийн эсрэг хуурамчаар хэрэг тулгах, эргэлзээтэй нэхэмжлэл гаргахаас зайлсхийх бөгөөд үүний дагуу шүүгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохих үндэслэл байхгүй тохиолдолд мөрдөн байцаах ажиллагаа явуулахаас урьдчилан сэргийлэх, зогсоох механизмыг бүрдүүлэх явдал юм.¹⁹⁸ Судалгаанаас харахад зарим үед шүүхийн зөвлөлүүд шүүгчийн халдашгүй байдлыг түдгэлзүүлэхгүй байх хандлагыг баримталдаг, өөрөөр хэлбэл шүүгчийнхээ эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх нь нэн ялангуяа, шүүгч хүн хээл хахууль эсвэл авлигын асуудалд холбогдсон тохиолдолд шүүх засаглалын нэр хүндэд бүхэлд нь ихэд сөргөөр нөлөөлөх тул ийнхүү зөвшөөрөл өгдөггүй хандлага буй.¹⁹⁹ **Дээрх 108-р догол мөрөнд дурдсанчлан, Монгол Улсад авлигатай тэмцэх шаардлага нь тулгамдсан асуудал болоод буйг харгалзан мөн үндэсний онцлог нөхцөлийг бодолцож, шүүгчийг үндэслэлгүй буруутгах бодит нөхцөл үүсэх эсэхээс хамаарч,²⁰⁰ хээл хахууль, авлига, ашиг сонирхолын зорилгоор нөлөөлөл ашиглах зэрэг тодорхой эрүүгийн гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхэд Ерөнхий зөвлөлөөс заавал урьдчилж зөвшөөрөл авах нөхцөлийг алгасах боломжийн талаар холбогдох хуулийн байгууллагын төлөөлөл нь ярилцаж хэлэлцэх нь зүйтэй юм.²⁰¹ Эл практикийг нэлээд хэдэн улс оронд хэрэгжүүлдэг болно.²⁰² Эсвэл Ерөнхий зөвлөл нь гарсан гомдол нь илт үндэслэлгүй гэж үзээгүй тохиолдолд зарчмын хувьд ийнхүү зөвшөөрөл өгч байх тухай хуулинд оруулж болох юм.²⁰³**

¹⁹⁸ 55 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын БНКиргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014)).

¹⁹⁹ *Өмнө нь иш татсан* 190-р зүүлт, 24 дүгээр догол мөр (Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт (2013)), Олон улсын Транспаренси Интернешнл байгууллагын Авлигын индекс 2007, 280 дугаар хуудсыг харна уу.

²⁰⁰ 26-27 дугаар догол мөр (Венецийн Комиссын шинжээчийн дүгнэлт (2013))-г харна уу.

²⁰¹ *Өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 60 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу.

²⁰² Жишээ болгон Молдав улсад Үндсэн хуулийн шүүх Авлигын гэмт хэрэгт холбогдсон шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэхэд Шүүхийн дээд зөвлөлийн зөвшөөрөл авах шаардлагыг халсаныг Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрсөн тухай 2013 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн шийдвэрийг үзнэ үү, <http://www.constcourt.md/lib.php?l=en&idc=7&t=/Overview/Press-Service/News/&year=2013&month=9>.

²⁰³ *Өмнө нь иш татсан* 89-р зүүлт, 60 дугаар догол мөр (АИХЭГ-Венецийн Комиссын Киргиз Улсын Шүүгчдийн сахилгын хариуцлагын талаар хамтарсан Санал дүгнэлт (2014))-г харна уу.

5.4. Сонгон шалгаруулалт ба томилгоо

111. Монгол улсад шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоо, томилох ажиллагааг сайжруулах шаардлага байгаа талаар олон улсын хэд хэдэн байгууллага тэмдэглэсэн байдаг. Ялангуяа хууль тогтоомж болон практик дээр шүүгчийг сонгон шалгаруулах, томилох шийдвэр гаргах үйл ажиллагаанд улс төрийн байгууллагуудын, үүний дотор Ерөнхийлөгч болон УИХ-ын эрх мэдэл, нөлөөллийг хумьж, ийнхүү ажиллагааг ил тод, нээлттэй, мерит зарчим болон мэргэшсэн байдал дээр үндэслэн, шударга явуулах нөхцөлийг хангаж ажиллах.²⁰⁴

5.4.1. Шүүгчид тавих болзол, шаардлага

112. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4-р болон 7-р зүйлд шүүгчид тавих болзол, шаардлагуудыг заасан байдаг. Ерөнхийдөө эдгээр тавигдаж буй болзол, шаардлагууд нь олон улсын түвшинд боловсруулсан зөвлөмжүүд болох шүүгчийн сонгон шалгаруулалт нь мерит зарчимд суурилсан байх, тавигдаж буй шаалгуур нь бодит, объектив тогтоосон байж²⁰⁵ нэр дэвшигчдийн ур чадвар, мэргэшсэн байдал болон туршлага зэргийг үнэлэхэд чиглэсэн байх ёстой гэдэгтэй нийцэж байна.²⁰⁶
113. Нөгөөтэйгүүр зарим шаардлагууд нь жишээ нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх тухай шаардлага нь (4.1.4-р зүйл) Монгол Улсад хуульчийн мэргэжил эзэмших тухай журам дүрэм, тэдгээрийн хэрэглээнд илүү гүнзгий дүн шинжилгээ, үнэлгээ хийх ёстойг харуулж байна. Ингэснээр энэхүү шаардлага нь хувь хүний эрх болон цөөнхийн бүлгийн эрх ашгийг шууд бусаар зөрчиж буй эсэх болон зохистой бодит шалгуур эсэхэд дүн шинжилгээнд суурилсан дүгнэлт гарахад тустай байх болно. Үүний сацуу, мөн хуулинд заасан давж заалдах шатны шүүгчид нь мэргэшсэн чиглэлээр хэрэглэгддэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах, хуулийн зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар мэргэжлийн хэвлэлд өгүүлэл бичин, нийтлүүлсэн байх тухай шаардлага нь (5.1.3-р зүйл) цахим хэлбэрээр санал болон өгүүлэлээ өгөх хялбар систем байдаггүй л бол, мэргэжлийн хэвлэл болон хуулийн байгууллагаас алслагдсан орон нутгаас сонгон шалгаруулалтад оролцож буй шүүгчид/ нэр дэвшигчдийг хохироож буй гэх асуудал үүсгэж болох талтай байна. **Хэрэв энэ шаардлагыг тодорхой нэр дэвшигчийн хувьд үндэслэлгүй саад гэж үзвэл үүнийг заавал тавигдах шаардлага биш харин тохирох ур чадвар гэж тодорхойлох нь илүү тохиромжтой болно.** Мөн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчдэд тавигддаг эрүүл мэндийн шаардлага нь нэр дэвшигчдийн хувийн

²⁰⁴ НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) [Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай зургаа дахь тайлангийн талаарх дүгнэлтийн](#) 32-р зүйл (2017 оны 8-р сарын 22), болон өмнө иш татсан 5-р зүүлт, ЕЭЗХАХБ-ын Монгол Улс дахь Авлигын эсрэг шинэтгэл-Истанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шатны үнэлгээний тайлангийн 10-р хуудас, Шинэ зөвлөмж 11, 15-16-р хуудас (2019)

²⁰⁵ Жишээ болгон өмнө иш татсан 13-р зүүлт, 19-р зүйл (НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай зургаа дахь тайлангийн талаарх дүгнэлтийн 32-р зүйл); 24-р зүүлт, 44-р зүйл (Европын Зөвлөлийн Зөвлөмж (CM/Rec(2010)12); 18-р зүүлт, 21-р зүйл (2010 АИХЭГ-ын Киевын зөвлөмж); 19-р зүүлт, 2.1-2.2-р зүйл (1998 Европын Дүрэм); 34-р зүүлт 50-51-о зүйл (ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлийн талаарх Санал дүгнэлт дугаар 10) тус тус харна уу.

²⁰⁶ Өмнө иш татсан 11-р зүүлт, 13 дугаарх зарчим (Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмууд 1985) болон 55-р зүүлт 17-р болон 29-р зүйл (ЕШЗ3-ийн Санал дүгнэлт дугаар 1 (2001)) тус тус харна уу.

нууцлалыг хүндэтгэх үүднээс болон эл шалтгаанаар ялагварлан гадуурхах үйлдлээс зайлсхийх зорилгоор бусад хууль тогтоомжоор зохицуулагдаж байх нь зохимжтой болно.

114. Улсын Дээд шүүхийн шүүгчдийн тухайд 6-р зүйлд, шүүгчид тавигдах болзол, шаардлагаас гадна давж заалдах шатны шүүхэд таваас доошгүй жил ажилласан, өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан эсвэл хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан байх шаардлага тавигддаг. Эдгээр шүүгчдийн гүйцэтгэдэг тусгай үүргийг харгалзан үзэж хууль боловсруулагчид тодорхой шаардлага нэмэх асуудлыг авч үзэж болох юм. Жишээ нь зарим улсад хувийн зан чанар, ур чадварын нэмэлт шаардлага тавьдаг туршлага байдаг, ялангуяа нийгмийн олон давхраа, бүлгийн хэрэгцээ, асуудалд мэдрэмжтэй хандах,²⁰⁷ **хүний эрхийн асуудлаар туршлагатай** байх гэх мэт. Учир нь Улсын дээд шүүх нь эдгээр асуудал дээр чухал үүрэг гүйцэтгэдэг тул²⁰⁸ эмзэг асуудлыг хэлцэж шийдвэрлэх ур чадвар,²⁰⁹ шүүх засаглалд институцийн хувьд итгэх итгэл үнэмшил болон шаардлагатай бусад зан чанар, нэр хүндтэй зан байдал, шударга зан төлөв зэрэг шаардлага тавьдаг байна.²¹⁰ **Үүнтэй холбогдуулан хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бодолцох нь зүйтэй болов уу.** Хэдийгээр ийм зан чанарыг зарим тохиолдолд практик дээр үнэлэхэд төвөгтэй байдаг боловч²¹¹ тэдгээрийг субъектив байдлын эрсдлийг хязгаарлах зорилгоор урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээр харьцуулж, нөхцөл байдал, туршлага дээр үндэслэж, тулгуурласан асуулт тавих аргаар²¹² үнэлэх боломжтой болно.²¹³
115. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон хууль эрх зүйн орчин нь ерөнхийдөө шүүх засаглалын бүтэц нь нийт хүн амын бүтцэд нийцэж,²¹⁴ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан байх талаар огт чимээгүй байна.²¹⁵ Бие даасан, хараат бус, хүйсийн тэгш байдлыг хангасан шүүх засаглал нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүний эрхийг

²⁰⁷ Жишээ болгон ИБУИНВУ-ын Дээд шүүхийн шүүгчдэд тавигддаг шаалгуурын талаар <<https://www.supremecourt.uk/docs/information-pack-for-justices-role-2019.pdf>>. цахим хуудаст нэвтэрч үзнэ үү.

²⁰⁸ Жишээ болгон Венецийн Комиссын, *Opinion on the Reform of Judicial Protection of Human Rights in the Federation of Bosnia and Herzegovina*, CDL(1999)07830 болон 32-р зүйлийг үзнэ үү.

²⁰⁹ Өмнө иш татсан 207-р зүйлт харна уу.

²¹⁰ Шүүхийн Зөвлөлүүдийн Европын Сүлжээний гаргасан, *Dublin Declaration setting Minimum Standards for the Selection and Appointment of Judges* (May 2012), индикатор №. I.4. үзнэ үү.

²¹¹ Өмнө иш татсан 75-р зүйлт 43-р зүйл (2019 АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгч нарыг томилгооны үйл ажиллагаанд хийсэн санал дүгнэлт) болон 2009 оны Венецийн Комиссын Серб улсын шүүхийн шүүгч болон ерөнхий шүүгч нарт тавигддаг шалгуурын төсөлд хийсэн санал дүгнэлтийн 30-31-р зүйлийг тус тус үзнэ үү.

²¹² Жишээ болгон АНУ-ын Улсын Шүүхийн Үндэсний Төвийн гаргасан *Handbook for Judicial Nominating Commissioners* (2 дахь хэвлэлт) 7-р бүлгийн 146-147-р зүйл харна уу.

²¹³ Жишээ болгон өмнө иш татсан 18-р зүйлт, 21-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон *Lilongwe Principles and Guidelines on the Selection and Appointment of Judicial Officers* (2018) 3.7-р заалтын тус тус харна уу.

²¹⁴ Өмнө иш татсан 24-р зүйл үзнэ үү (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²¹⁵ *Бээжингийн тунхаглалын* стратегийн зорилт 1: “эрх мэдэл болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог эрх тэнгш хангах чиглэлээр бүхий л арга хэмжээг авах” талаарх 190-р зүйл; Эмэгтэйчүүдийн дэлхийн 4 дүгээр бага хурлын тайлангийн 1-р бүлэг, 1995 оны 9-р сарын 4-15-ны өдрүүд (A/CONF.177/20 and Add.1); Улс төр болон нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцооны талаарх ЕАБХАБ-ын *Сайд нарын зөвлөлийн шийдвэр 7/09* (2009 оны 12-р сарын 2); мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн Жендэр болон шүүхийн захиргааны талаарх тайлангийн 45-р зүйлийг тус тус харна уу, [A/HRC/17/30](#), 2011 оны 4-р сарын 29, 81 болон 91-р зүйл.

нэмэгдүүлэхэд, хүйсийн тэгш байдлыг хангахад цаашилбал шударга ёсыг хэрэгжүүлэхэд жендерийн асуудлыг тусгахад чухал үүрэгтэй билээ.²¹⁶ Иймд улс орнууд шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо бүтцийг эргэн харж, шүүхийн бүх шатанд эмэгтэйчүүдийн төлөөлөлийг хангахын сацуу хүйсийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр бүхий л арга хэмжээг авах нь зохистой болно.²¹⁷ Нөгөөтэйгүүр, шүүгчдийг сонгон шалгаруулах, томилох явцад хүйсийн эрх тэгш төлөөллийг хангах зорилтын хүрээнд шүүгчид тавигдах үндсэн болзол, шардлагыг орхигдуулж болохгүй болно.²¹⁸

116. Ер нь Монгол улсад шүүхийн бүх шатны томилгооны тухайд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн ямар нэгэн тодорхой механизм байхгүй байна. Үүнтэй холбогдуулан ЕАБХАБ-ын Афины Сайд нарын зөвлөлийн хурлын “Улс төр болон нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцооны тухай” (2009) шийдвэр нь гишүүн орнуудыг “хууль тогтоох, шүүхийн болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага дахь жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тодорхой арга хэрэгслүүд буй болгох талаар” уриалсан байдгийг дурдах нь зүйтэй болов уу. Иймд ЕАБХАБ-ын хүний хэмжигдэхүүний үүрэг хариуцлага²¹⁹ болон олон улсын бусад хэм хэмжээ, сайн туршлагад нийцүүлэн,²²⁰ **шүүгч/ерөнхий шүүгчид нэр дэвшигчдийг тодорхойлох, эрэмблэх, сонгон шалгаруулах, томилохдоо эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцангуй тэнцвэртэй төлөөллийг хангах механизм нэвтрүүлэхийг хууль боловсруулагчид судалж болох юм.** Ингэхдээ нэр дэвшигчдэд тавигддаг ажлын туршлага болон мэргэшлийн шаардлагуудын шалгуурыг хөндөхгүй байх.²²¹

²¹⁶ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн устгах тухай НҮБ-ын Конвенцийн 1-р зүйл болон НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Шүүгч, хуульчдийн хараат бус байдлын асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн Жендер болон шүүхийн захиргааны талаарх тайлангийн 45-р зүйлийг тус тус харна уу, [A/HRC/17/30](https://www.unhcr.org/refugees/45-1730), 2011 оны 4-р сарын 29.

²¹⁷ Өмнө иш татсан 47-р зүйлийг үзнэ үү.

²¹⁸ Жишээ болгон өмнө иш татсан 210-р зүйл, Шүүхийн Зөвлөлүүдийн Европын Сүлжээний гаргасан [Dublin Declaration setting Minimum Standards for the Selection and Appointment of Judges](https://www.dublindeclaration.eu) (May 2012), индикатор №. I.8.үзнэ үү. Түүнчлэн ИБУИНВУ-ынДээд шүүхийн сул орон тооны зарлалын 4-р хуудсыг харна уу. Үүнд “Сонгон шалгаруулалтыг зохих шалгаруулалтын зарчмын дагуу явуулж, нэр дэвшигчдийн мэдлэг, мэргэжлийн болон туршлагын зохистой тэнцвэрийг хангаж ажиллана” хэмэжээ, <https://www.supremecourt.uk/docs/information-pack-for-justices-role-2019.pdf>.

²¹⁹ ЕАБХАБ-ын Афины Сайд нарын зөвлөлийн хурлын (№7/09 шийдвэр 2009 он) шийдвэрээр гишүүн орнууд нь “хууль тогтоох, шүүхийн болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага дахь жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн тодорхой арга хэрэгслүүд буй болгох талаар үүрэг хүлээсэн мөн “шүүгчдийг ялгаварлан гадуурхахгүй тэгш зарчмаар мэргэжлүүлж, сургаж, сонгон шалгаруулна” (Москва 1991 он) хэмээсэн байна. Мөн ЕАБХАБ-ын Афины сайд нарын зөвлөлийн хурлаас гарсан [Улс төр, нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн оролцооны тухай №7/09 шийдвэрийн](https://www.unhcr.org/refugees/45-1730) 1-р зүйл, 2009 оны 12-р сарын 2 [болон ЕАБХАБ-ын Хүний хэмжигдэхүүний асуудлаарх Москвагийн бага хурлын баримт бичгийн](https://www.unhcr.org/refugees/45-1730) 19.2 (iv) зүйлийг үзнэ үү. Москва хот, 1991 оны 9-р сарын 10-наас 10-р сарын 4-ний өдрүүд.

²²⁰ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн устгах тухай НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг хангах хорооны Улс төр, нийгмийн амьдрал дахь оролцооны тухай Ерөнхий зөвлөмж №23 /1997/, [Бээжингийн тунхаглал](https://www.unhcr.org/refugees/45-1730) болон Эмэгтэйчүүдийн дэлхийн 4 дүгээр бага хурлын тайлангийн 1-р бүлэг, 1995 оны 9-р сарын 4-15-ны өдрүүд (A/CONF.177/20 and Add.1); ялангуяа стратегийн зорилт 1: “эрх мэдэл болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог эрх тэнгш хангах чиглэлээр бүхий л арга хэмжээг авах” талаарх 182 болон 190-р зүйл; Европын Зөвлөлийн Сайд нарын зөвлөлийн 2003 оны 3-р сарын 12-нд батласан [Улс төр, нийгмийн шийдвэр гаргах үйл явц дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцооны талаарх Зөвлөмж дугаар /2003/3 хавсралтад](https://www.unhcr.org/refugees/45-1730) “ хууль эрх зүй, захиргааны болон нэмэлт бусад арга хэрэгслээр улс төр, нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог 40%-д хүргэх зорилт тусгасан болно. Мөн өмнө иш татсан (2010 оны Киевын зөвлөмжүүд) шүүх засаглалын бүтэц нь нийт хүн амын бүтцэд нийцэж байх талаарх 18-р зүйл, 24-р зүйлийг харна уу.

²²¹ Өмнө иш татсан 75-р зүйл, 47-р зүйл (АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгч нарын томилгоонд хийсэн санал дүгнэлт), жишээ болгон бусад боломжит механизмуудын талаар өмнө иш татсан 89-р зүйл, 5.1-р дэд хэсэг (2014 оны АИХЭГ -Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчдийн сахилгын хариуцлагын талаарх баримт бичигт хамтран хийсэн санал дүгнэлт) харна уу.

117. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай НҮБ-ын конвенцийн 27-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох эрхийг “*хүртээмжтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд хөдөлмөр эрхлэнэ*” гэж тунхагласан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусадтай адил тэгш шударга ёсны тогтолцоонд оролцох эрхтэй, ингэхдээ зөвхөн үйлчлүүлэгчийн хувьд бус шүүгч, прокурор, иргэний төлөөлөгч болон хуульчийн хувиар оролцох эрхтэй болно. Хууль сахиулах салбарын мэргэжлийн тухайд “*адил тэгш оролцоо*” гэдэгт сонгон шалгаруулах болон ажлын байранд тавигдах шаардлага нь ялгаварлан гадуурхах нөхцөл агуулахгүй байхаас гадна, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн адил тэгш оролцох эрхийг нь хангасан бүхий л нөхцөлийг төр нь бүрдүүлэх үүрэгтэй,²²² шаардлага хангасан нэр дэвшигчдэд ажиллах нөхцөлийг нь бүрдүүлж өгөхийг мөн хэлнэ. Эдгээрийг сул орон тооны зарлалд тодорхой тусгаж өгч болно.
118. Дээрхтэй холбогдуулан, **шүүгчид нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, шүүгчид тавих болзол, шаардлага, мерит зарчмыг алдагдуулахгүйгээр, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, цөөнхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн харьцангуй төлөөллийг шүүх эрх мэдлийн байгууллагад хангах механизм Шүүхийн мэргэшлийн хороонд нэврүүлэхийг хууль боловсруулагчид судалж үзэж болох юм.** Зарим улс орны хууль эрх зүйн орчин нь ийнхүү жендэрийн болон цөөнхийн төлөөл оролцоог хангах шаардлагыг зөрчсөн үр дагаварт хамаарах заалтууд оруулсан байдаг.²²³ Үүний сацуу хууль боловсруулагчид Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Шүүхийн мэргэшлийн хороо нь дээрхтэй холбогдуулан холбогдох бодлого боловсруулж, хэрэгжүүлэх тухай заалтыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд оруулж болох юм (47-р догол мөрийг харна уу).

5.4.2. Сонгон шалгаруулах болон томилох журам

119. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11-13-р зүйл болон 15-р зүйл нь шүүгчийг сонгон шалгаруулах, томилох ажиллагааг зохицуулдаг бөгөөд нэгтгэвэл. Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчийн сул орон тоог зарлаж, нэр дэвшигчдийн өргөдлийг бүртгэж, нэр дэвшигч нь шүүгчид/ерөнхий шүүгчид тавих шаардлагыг хангасан эсэх талаарх үнэлгээг Шүүхийн мэргэшлийн хороо гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ (тус хуулийн 4-7-р зүйл). Хуульчдын холбоо нь нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг мөн хүргүүлнэ (12.2-р зүйл). Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ болон Хуульчдын

²²² 2010 оны Киевын зөвлөмжийн 2-р бүлэгт тусгасан шүүгчийг сонгон шалгаруулах болон сургалтад хамруулах тухай стандартуудыг харна уу, мөн өмнө иш татсан 18-р зүүлт үзнэ үү.

²²³ Өмнө иш татсан 75-р зүүлт, 49-р зүйл харна уу (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилох үйл ажиллагааны тухай хуулийн талаарх санал дүгнэлт). Тус хуулиар жендэрийн хувьд нэг хүйсийнх нь нөгөө хүйсийн төлөөллөөс илт давамгайл нөхцөлд томилгоог түдгэлзүүлэх нөхцөлийг тусгасан байна. Мөн Францын Эрэгтэчүүд болон эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлын тухай хуулийн /2014/ 75-р зүйлийг, <https://www.legifrance.gouv.fr/affichTexte.do?cidTexte=JORFTEXT000029330832&dateTexte=20190409>, болон 2013 оны 4-р сарын 19-нд батласан 2013 [Report of the UN Working Group on the issue of discrimination against women in law and in practice](#) (A/HRC/23/50) тайлангийн 39-р зүйлийг тус тус харна уу.

холбооны дүгнэлтийн хамт нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэлгээний дүнгээр эрэмбэлж, нэр дэвшигч бүртэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж дүгнэлт гаргана (13-р зүйл). Үүний дараа, Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийг (илээр) санал хураан олонхын санал авсан хүний нэрийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилдог байна (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1-р зүйл). Ерөнхийлөгч нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргаж болно. Ерөнхийлөгч нэр дэвшигчийг томилохоос татгалзах үндэслэлийн талаар ямар нэгэн дэлгэрэнгүй мэдээлэл алга, нөгөөтэйгүүр Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь ийнхүү томилохоос татгалзсан шийдвэр авсан нэр дэвшигчийн нэрийг дахин санал болгох эрхтэй эсэх талаар мэдээлэл мөн алга.

120. Шүүхийн хараат бус байдал, шүүгчид болон шүүхийн тогтолцоонд олон нийтийн итгэх итгэлийг хангахын тулд шүүгчийг сонгон шалгаруулах, томилох ажиллагаа нь ил тод, нээлттэй байх ёстой болно.²²⁴ Үүний гол зорилго нь сонгон шалгаруулах/томилох шийдвэрүүд нь зөвхөн мерит зарчим дээр суурилж,²²⁵ сонгон шалгаруулалтын ажиллагаа шударга явагдсанд итгэх нийт хуульчид болон олон нийтийн хандлагыг баталгаажуулах болно.²²⁶
121. Үүнтэй холбогдуулан Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шийдвэр гаргах ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд мерит зарчим дээр тулгуурласан томилгооны тогтолцоог хууль тогтоомж болон практик дээр хэрэгжүүлэх нөхцөлийг хангах нь чухал болно. Зарчмын хувьд шүүгчийн томилгооны журам, үйл ажиллагаа болон шүүгчид тавигддаг болзол, шаардлагын талаар олон нийт тодорхой ойлголттой байх ёстой бөгөөд энэхүү мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх ёстой.²²⁷ Нэгдүүгээрт, Шүүхийн мэргэшлийн хороо нь нэр дэвшигчдэд хэрхэн үнэлгээ хийдэг нь тодорхой бусаас гадна үнэлгээ хийх тодорхой журам байхгүй байна. Мөн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн нэр дэвшигчдийн жагсаалтыг үнэлгээний дүнгээр эрэмблэн жагсаахад Хуульчдын холбооны дүгнэлтийн үр дагавар нь ойлгомжгүй байна. Үүгээр зогсохгүй, ийнхүү эрэмблэн нэрсийн жагсаалт гаргах явдал болон илээр санал хураан олонхын

²²⁴ Өмнө иш татсан 18-р зүүлт, 21-23-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд), 26-р зүүлт, 23-32-р зүйл (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн хараат бус байдлын тухай тайлан), мөн өмнө иш татсан 19-р зүүлт 4.1-р, 5.1-р болон 5.2-р зүйлийг харна уу (1999 оны Шүүгчдийн нийлтэг тунхалглал).

²²⁵ Түүнчлэн харьцуулсан шинжилгээ хийх зорилгоор өмнө иш татсан 24-р зүүлт, 44-р зүйл (Европын Зөвлөлийн CM/Rec(2010)12); 65-р зүүлт, 4 болон 10-р зүйл (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн томилгооны талаарх тайлан) болон өмнө иш татсан 11-р зүүлт, Зарчим 10 (Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын ерөнхий зарчимууд) буюу “шүүгчийн албан тушаалд сонгогдон томилогдсон хүмүүс нь шударга, чадвартай, эрх зүйн чийгшлэлээр бэлтгэгдсэн буюу мэргэшсэн байна” гэж заасан болно.

²²⁶ Венецийн Комиссын [Молдав улсын Үндсэн хуулинд /шүүх эрх мэдэл/ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн санал дүгнэлт](#) CDL/AD(2018)003-е, 33-р зүйлийг үзнэ үү.

²²⁷ Өмнө иш татсан 18-р зүүлт, 21-23-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд), мөн өмнө иш татсан 120-р зүүлт, 9-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд). Харьцуулалт хийх зорилгоор шүүгчдэд хийх үнэлгээний тухайд, [Opinion no. 17 \(2014\) on the Evaluation of Judges' Work, the Quality of Justice and Respect for Judicial Independence](#) тайлангийн 48-р зүйлийг харна уу.

санал авсан хүний нэрийг өргөн мэдүүлэх Зөвлөлийн эцсийн шийдвэр хоорондын холбоо нь мөн ойлгомжгүй байна. Ер нь бол сонгон шалгаруулалт, үнэлгээ хийх бие даасан байгууллага байхад, шүүхийн зөвлөл нь сонгон шалгаруулалтын ажиллагаа нь журам, дүрмийн дагуу явагдсан эсэхэд хяналт тавьж, хорооны санал болгосон нэр дэвшигчийг томилох эсэхийг эсвэл томилох байгууллагад нэр дэвшигчийн нэрийг нь санал болгож танилцуулах л үүрэг хүлээдэг байхад хангалттай.²²⁸ **Шүүхийн Мэргэшлийн Хорооны гаргасан шүүгчийг сонгон шалгаруулах хуульд заасан болзол, шаардлагыг хангасан эсэх талаарх үнэлгээ нь шаардлагад нийцэж буй эсэхийг шалгах эрхийг л Шүүхийн Ерөнхий Зөвлөлд олгож, бусад үүргийг хязгаарлах асуудлыг авч үзэх, мөн Хорооны гаргасан үнэлгээ нь хуульд заасан болзол, шаардлагыг зөрчсөн талаар тодорхой, зохих баримтжуулсан бичиг баримтын үндэслэл байхгүй бол дээрх үнэлгээг дагаж мөрдөх үүрэг хүлээлгэх зэргээр журамд өөрчлөлт оруулах асуудлыг хууль боловсруулагчид судалж үзэх. Эс бөгөөс Шүүхийн мэргэшлийн хороо, Хуульчдын холбоо болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн тус тус үнэлгээ хийх журмыг хуулинд тодорхой тогтоож өгөх нь зохимжтой болно.**

122. Нөгөөтэйгүүр, хуулийн зүйл заалтуудад шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийг эрэмбэлж жагсаахдаа Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь ямар шалгуураар ийнхүү эрэмбэлж буйгаа тайлбарлах үүргийнх нь тухай хууль тогтоомжинд тусгаагүй, зөвхөн санал хураах л тухай заасан байна. Санал хураах энэхүү ажиллагаа нь мерит зарчим дээр суурилсан сонгон шалгаруулах системийг үгүйсгэсэн гаж буруу нөлөө үзүүлж байна. Нэр дэвшигчдийн ур чадвар, мэргэшлийн туршлагад үнэлгээ хийх ажиллагаа нь шүүхийн томилгооны тогтолцооны үндсэн зарчим билээ.²²⁹ Иймд **Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13.2-р зүйлд заасан шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийг илээр санал хурааж өргөн мэдүүлнэ гэх заалтыг бүхэлд нь эргэн харах нь зүйтэй болно.**
123. Цаашилбал, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ийнхүү санал хураалт нь олонхийн санал авсан нэр дэвшигчдэд ч ямар нэгэн тайлбар өгөхгүй байна, мөн зөвлөлийн гаргасан шийдвэртэй холбогдуулан шүүхэд давж заалдах эрхтэй эсэх талаар ч ямар нэгэн заалт хуулинд үгүй байна. Энэ нь олон улсын болон бүс нутгийн түвшинд боловсруулан гаргасан хэм хэмжээнд нийцэхгүй байгаа бөгөөд шүүгчид болон олон нийтийн өмнө нээлттэй, ил тод байдлыг хангах үүднээс шүүхийн зөвлөлийн шийдвэрүүд нь дур зоргоороо гаргасан бус хууль, дүрэм, журамд үндэслэн гаргасан шийдвэрүүд байх нь чухал болно.²³⁰ Иймд шүүгчийг томилох, албан тушаал ахиулах тухай шийдвэрүүд нь

²²⁸ Өмнө иш татсан 3-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²²⁹ Өмнө иш татсан 75-р зүйл, 60-61-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилох үйл ажиллагааны тухай хуулийн талаарх санал дүгнэлт) харна уу. Мөн ЕХЭШ-ийн, [Guðmundur Andri Ástráðsson v. Iceland](#) (Application no. 26374/18, judgment of 12 March 2019), 116-р зүйлийг үзнэ үү.

²³⁰ Түүнчлэн харьцуулсан шинжилгээ хийх зорилгоор өмнө иш татсан 24-р зүйл, 28 болон 48-р зүйл (Европын Зөвлөлийн СМ/Rec(2010)12), мөн өмнө иш татсан 120-р зүйл, 9-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд), Шүүхийн Зөвлөлүүдийн Европын Сүлжээний гаргасан [Dublin Declaration setting Minimum Standards for the Selection and Appointment of Judges](#) (May 2012), индикатор №. I.10 үзнэ үү. Мөн Венецийн Комиссын [CDL-AD \(2018\)029e](#) 45-р зүйлийг харна уу. Үүнд

үндэслэл тайлбартай байх ёстой бөгөөд тэнцээгүй нэр дэвшигчид зөвлөлийн гаргасан шийдвэртэй холбогдуулан гомдол гаргах эрхтэй байх нь зүйд нийцэнэ. Улмаар сонгон шалгаруулах журам, ажиллагааг шалгуулах эсхүл алагчлан үзсэн гэх гомдолын үндэслэлийг хянаж нягтлаж байх нь зохистой болно.²³¹ **Хууль тогтоомж болон практикт шүүгчийг чадахуйн зарчимд тулгуурлан томилох байдлыг хангах. Сонгон шалгаруулалтын шийдвэрийн үндэслэлийг хуулинд заасан болзол шалгуур бүрээр нь тайлбарлах үүргийг мөн нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахаар нэр дэвшүүлээгүй Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шийдвэрийн эсрэг давж заалдах тодорхой процедурыг хуульд тусгах. ЭЗХАХБ-аас өгсөн зөвлөмжтэй адил.**²³² *Бусад хуулинд өөрөөр заагаагүй бол тухайн хуультай хавсаргасан лавлагааг уг хуулинд хийх. Шүүхийн зөвлөлийн шийдвэрийг эсэргүүцэх холбогдох журмыг тайлбарласан байх ёстой.*

124. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.2-р зүйлд Хуульчдын холбооны гарсан дүгнэлттэй нэр дэвшигчид танилцах боломжтой эсэх талаар тодорхой заалт байхгүй бөгөөд Шүүхийн Ерөнхий Зөвлөл нэр дэвшигчтэй хийх ярилцлагын үеэр дээрх дүгнэлттэй холбогдуулан тайлбар хийх эрхтэй эсэх тухай мөн заалт алга байна. **Эл асуудлыг хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид судалж үзэх нь зүйтэй болов уу.**
125. Шүүхийн томилгооны ажиллагаанд Ерөнхийлөгчийн гүйцэтгэдэг үүргийн тухайд ЕАБХАБ-ын бүс нутгийн хэмжээнд шүүгчийн томилгоотой холбоотой олон төрлийн процедур хэрэглэгдэж, мөрдөгдөж байна.²³³ Бүс нутгийн түвшинд боловсруулан гаргасан зөвлөмжүүдэд шүүгчдийг сонгон шалгаруулах болон шүүгчдийн хувийн карьертэй холбоотой аливаа шийдвэр гаргадаг эрх бүхий байгууллага нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөллөөс хараат бус байвал томилгооны ажиллагаан дах улс төрийн ашиг сонирхол хэт их нөлөөлөхөөс зайлсхийх боломжтой гэдгийг онцолсон байдаг. Жишээ нь эдгээр шийдвэрүүдийг бүрэлдэхүүнийх нь тал нь шүүгчдээс бүрдсэн бие даасан шүүхийн зөвлөл эсвэл бусад эрх бүхий байгууллага

Венецийн Комисс нь шүүхийн ерөнхий зөвлөлүүд нь шүүгчийн карьертэй холбоотой журмуудыг өөрсдөө боловсруулж байх бөгөөд үндэслэлийг нь тодорхой тусгаж байх тухай заасан байна.

²³¹ Өмнө иш татсан 75-р зүүлт, 78-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилох үйл ажиллагааны тухай хуулийн талаарх санал дүгнэлт) харна уу. Өмнө иш татсан 18-р зүүлт, 23-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд). Түүнчлэн харьцулсан шинжилгээ хийх зорилгоор өмнө иш татсан 24-р зүүлт, 28 болон 48-р зүйл (Европын Зөвлөлийн CM/Rec(2010)12) тус тус харна уу. Мөн өмнө иш татсан 34-р зүүлт 39-р, 50-51-р болон 91-93-р зүйл (ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай санал дүгнэлт № 10 (2007)) болон 55-р зүүлт, 17-31-р зүйл (ЕШЗЗ-ийн санал дүгнэлт № 1 (2001)) үзнэ үү. Жишээ болгож, Венецийн Комиссын [Opinion on the Cardinal Acts on the Judiciary that were Amended following the Adoption of Opinion CDL-AD\(2012\)001 on Hungary](#), CDL-AD(2012)020 56-р зүүлт, өмнө иш татсан 19-р зүүлт 5-2-р заалтын 3-р зүйл (Шүүгчийн Нийлтэг Тунхаг); 210-р зүүлт, Индикатор № I.10 (2012 ENCJ Dublin Declaration setting Minimum Standards for the Selection and Appointment of Judges) тус тус харна уу. Түүнчлэн өмнө иш татсан 120-р зүүлт, Зарчим 17 (Шүүгчийн сонгох/томилоход бие даасан хараат бус хороодын шүүцэтгэх үүргийн тухай Кейп Тауны зарчмууд)-д “хороодын гаргасан шийдвэрийн үндэслэлийг хууль болон үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар шалгах нь зохимжтой” гэжээ.

²³² Өмнө иш татсан 5-р зүүлт, (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан) 10-р хуудас Шинэ зөвлөмж 11-ийг 15-16-р хуудаснаас харна уу.

²³³ Өмнө иш татсан 67-р зүүлт, 67-68-р зүйлийг харна уу. (2017 оны АИХЭГ-ын Польш улсын Шүүхийн зөвлөлийн талаарх эцсийн санал дүгнэлт).

гаргаж байх нь зүйтэй болно.²³⁴ Ийнхүү зохицуулалтын гол зорилго нь шүүгчдийг улс төрийн зорилго, үзэмжээр бус мерит зарчим дээр үндэслэн сонгон шалгаруулж байх явдлыг баталгаажуулахад оршино.²³⁵ Ингэхдээ гүйцэтгэх засаглал нь шүүгчийн хараат бус зөвлөлийн гаргасан шүүгчийг томилох саналыг дагаж,²³⁶ томилогдсон шүүгчид нь үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа нөлөөлөл, шахалтаас ангид байх тохиолдолд²³⁷ шүүгчдийг төр засгаас томилдог байдал нь шүүхийн хараат бус, бие даасан байдалд заналхийлэл учруулж буй явдал бус бөгөөд хүлээн зөвшөөрөгдөхуйц факт болно. [2010 оны ЕАБХАБ-ын Киевын зөвлөмжүүд нь](#) ийм тохиолдолд, Ерөнхийлөгчийн шүүгчийг томилохоос татгалзсан шийдвэр нь тухайн нэр дэвшигч хуулиар тогтоосон шүүгчид тавигдах болзол, шаардлагыг хангаагүй талаарх үндэслэл дээр тулгуурласан байх ёстойг онцолсон бөгөөд Ерөнхийлөгчийн ийнхүү гаргасан хоригийг сонгон шалгаруулах эрх бүхий байгууллага нь гишүүдийн олонхийн саналаар түдгэлзүүлэх эрх нь нээлттэй байхыг мөн тусгасан байдаг.²³⁸ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хувьд шүүгчийг томилохоос татгалзах Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарласан заалт байхгүйгээс гадна Ерөнхийлөгч ийнхүү томилохоос татгалзах шийдвэр гаргах үндэслэлийн талаар тодорхой нарийвчилсан зүйл алга байна. Энэ нь шүүхийн хараат бус байдлыг хангах ажиллагаатай нухацтай зөрчилдөж байгаа билээ.

126. Иймд шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалахын тулд шүүгчийн томилгооны ажиллагаан дах гүйцэтгэх засаглалын нөлөөллийг хумихын тулд **шүүгчийг томилох Ерөнхийлөгчийн үүрэг оролцоог бэлгэдлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар хязгаарлах буюу Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гаргасан саналыг хүлээн авах үүрэг хүлээлгэх.**²³⁹ Эсвэл Ерөнхийлөгчийн эрх, үүрэг оролцоог зөвхөн процедурын үүргээр хязгаарлаж өгөх, жишээ нь нэр дэвшигчийг томилох эсвэл томилохоос татгалзах шийдвэр гаргах эрх зүйн үндэслэлийг хууль

²³⁴ Жишээ нь, өмнө иш татсан 24-р зүүлт, 46-р зүйл (2010 оны Европын Зөвлөлийн Зөвлөмжийн CM / Rec (2010) 12) -д “шүүгчдийн сонгон шалгаруулалт, ажил мэргэжлийн талаар шийдвэр гаргах эрх мэдэл нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс хараат бус байх ёстой” гэж тусгасан байна. Өмнө иш татсан 18-р зүүлт, 8-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) -д “олон тооны шүүхийн гишүүдээс гадна” “[бүрэлдэхүүн [сонгон шалгаруулалт хийх шийдвэр гаргасан байгууллагын бүрэлдэхүүн] нь улс төрийн ашиг сонирхол нь шүүхийн албан тушаалд нэр дэвшигчийн мэргэшлийн чадвараас давамгайлахгүй байхыг баталгаажуулна”]; 1.3 дахь догол мөр (Шүүгчийн эрх зүйн байдлын талаарх Европын дүрэм (1998)), үүнд “[Шүүгчийг сонгон шалгаруулах, ажилд авах, томилох, албан тушаалд дэвших, эсвэл бүрэн эрхийг нь цуцлахтай холбогдох шийдвэр бүрийн хувьд энэхүү дүрэмд гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат бус байгууллагыг оролцуулахыг заасан бөгөөд тус байгууллагын бүрэлдэхүүний талаас доошгүй хувь нь шүүхийн хамгийн өргөн төлөөллийг баталгаажуулах аргын дагуу шүүгчид дундаасаа сонгогдсон шүүгчид байна” гэж заасныг өмнө нь иш татсан 34-р зүүлт, 48 зүйл(ЕШЗЗ-ийн Шүүхийн зөвлөлүүдийн тухай Санал дүгнэлт №10 (2007)), үүнд “Шүүхийн хараат бус байдлыг хадгалахын тулд шүүгчдийг томилох, дэвшүүлэх нь хараат бус байх нь зүйтэй бөгөөд үүнийг хууль тогтоох байгууллага эсвэл гүйцэтгэх засаглал бус Шүүхийн зөвлөлөөс хийх нь чухал юм” гэж зааныг; ба өмнө нь иш татсан 65-р зүүлт, 25 болон 32 дугаар догол мөр (Венецийн Комиссын Шүүгчийн томилгооны тухай тайлан (2007)) зэргийг харна уу.

²³⁵ Өмнө иш татсан 51-р зүйл (ЕШЗЗ-ийн 2007 оны Шүүхийн зөвлөлийн талаарх Дүгнэлт дугаар 10). Өмнө иш татсан 24-р зүүлт, 44-р зүйл (Европын Зөвлөлийн CM/Rec(2010)12 болон 18-р зүүлт, 8-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) тус тус үзнэ үү.

²³⁶ Өмнө иш татсан 21-р зүүлт, 59-р зүйл (2012 оны АИХЭГ-ын олон улсын шударга шүүхийн эрхийн тухай хуулийн түүвэр) болон [Венецийн Комиссын Шүүхийн томилгооны тайлангийн](#) 14-р зүйл CDL-AD (2007) 028, 2007 оны 6-р сарын 22-ны өдөр.

²³⁷ Харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Maktouf and Damjanović v. Bosnia and Herzegovina](#) [GC] (Application nos. 2312/08 and 34179/08, judgment of 18 July 2013), 49-р зүйлийг үзнэ үү.

²³⁸ Өмнө иш татсан 18-р зүүлт, 23-р зүйлийг харна уу. (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²³⁹ Өмнө иш татсан 5-р зүүлт, Шинэ зөвлөмж 11-ийг 15-16-р хуудсыг харна уу. (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан).

тогтоомжинд тодорхой тогтоож өгөх, мөн нэр дэвшигчдийг томилохоос татгалзах шийдвэр гаргахад нь хязгаарлалт тогтоох, ийнхүү томилохоос татгалзсан үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбарлах үүрэг хариуцлага хүлээлгэх, томилохоос татгалзсан нэр дэвшигчийг дахин санал болгох эрхийг нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлд нээлттэй үлдээж, Ерөнхийлөгчийн томилохоос татгалзсан шийдвэрийг давж гарах боломжийг олгох нь зүйтэй болно. Ийнхүү тохиолдолд Зөвлөлийн хүргүүлсэн саналыг Ерөнхийлөгч хүлээж авах үүрэг хүлээх.²⁴⁰

127. Улсын дээд шүүхийн шүүгчийн томилгооны тухайд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1-р зүйлд “*хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар*” Ерөнхийлөгч томилоно гэж заасан байна. Энэ процедуын ажиллагааны үр дагавар нь хуулинд тодорхой бус байна. Үүнтэй холбогдуулан хяналтын шатны шүүгчийг томилох ажиллагаанд улс төрийн нөлөөлөл үзүүлэх явдлыг урьдчилан сэргийлэх нь нэн чухал болно.²⁴¹ Улсын Дээд Шүүхийн шүүгчийг томилох ажиллагаан дах УИХ-ын оролцоо нь улс төржсөн байх магадлал өндөр ба ийнхүү сонгогдсон хяналтын шүүхийн шүүгчид нь хууль тогтоох байгууллагын нөлөөлөлд байдаг гэсэн ойлголт олон нийтийн дунд гарах магадлалыг нэмэгдүүлдэг.²⁴² ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын болон олон улсын болон бүс нутгийн түвшинд боловсруулсан сайн дурын зөвлөмжүүдэд шүүгчийн томилгоо үүний дотор дээд шүүхийн шүүгч нарын томилгооны ажиллагааг бие даасан, хараат бус шүүхийн зөвлөл гүйцэтгэж явуулахыг зөвлөсөн байдаг.²⁴³ Дээд шүүхийн шатны шүүгчдийн томилгоо нь хууль тогтоох байгууллагын санал хураалт дээр үндэслэн шийдвэрлэгддэг явдал нь, энэ нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад түгээмэл тохиолддог, нэр дэвшигчдийг объектив, мерит зарчим дээр үндэслэж бус харин улс төрийн ашиг сонирхолын үүднээс томилох эрсдэлийг дагуулдаг.²⁴⁴ Иймд шүүгчийг томилох ажиллагаанд шүүхийн зөвлөл эсвэл бусад бие даасаан, хараат бус байгууллага нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байх нь чухал бөгөөд улс төрийн байгууллага эл ажиллагаанд хэрэв оролцдог бол түүний шийдвэр нь зөвхөн процедурын үндэслэлээр шийдвэр гаргах зэргээр хязгаарлагдаж байх нь чухал болно.²⁴⁵

²⁴⁰ Өмнө иш татсан 18-р зүйлт, 29-р зүйлийг харна уу. (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁴¹ Өмнө иш татсан 75-р зүйлт, 26-28-р зүйл (АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгч нарын томилгооны талаар санал дүгнэлт)-ийг үзнэ үү. Жишээ болгож мөн Ази Номхон Далайн бүс нутгийн 32 Дээд шүүгчид нэгдсэн [Beijing Statement of Principles of the Independence of the Judiciary](#) (1995), 12-р зарчим нь “[...] шүүгчийн томилох журам нь [...] үр чадвар, шуударга байдал, хараат бус томилогоо хийхийн тулд зохисгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой” гэж онцгойлон заажээ.

²⁴² Өмнө иш татсан 34-р зүйлт, 15-р зүйл (2015 оны ЕШЗ3-ийн Санал дүгнэлт дугаар 18), 33 болон 45-р зүйл (2001 оны ЕШЗ3-ийн Санал дүгнэлт дугаар 1) болон 34-р зүйлт 48-51-р зүйл (2007 оны ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлийн тухай Санал дүгнэлт дугаар 10) тус тус харна уу. Мөн түүнчлэн өмнө иш татсан 65-р зүйлт, 12 болон 29-р зүйл харна уу (2007 оны Венецийн Комиссын Шүүхийн томилгооны тухай тайлан).

²⁴³ Өмнө иш татсан 65-р зүйлт, 12 болон 47-р зүйл харна уу (2007 оны Венецийн Комиссын Шүүхийн томилгооны тухай тайлан). Мөн өмнө иш татсан 19-р зүйлт, 1.3 зүйл (Европын Зөвлөлийн CM/Rec(2010)12 болон 34-р зүйлт, 27-30-р зүйл (2007 оны ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлийн тухай Санал дүгнэлт дугаар 10) тус тус харна уу.

²⁴⁴ Өмнө иш татсан 65-р зүйлт, 12 болон 47-р зүйл харна уу (2007 оны Венецийн Комиссын Шүүхийн томилгооны тухай тайлан). Мөн Венецийн Комиссын Гүрж улсын парламент 2017 оны 6-р сарын 23-нд хоёр дах хэлэлцүүлгээр батласан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай төсөлд хийсэн санал дүгнэлт [CDL-AD \(2017\)023-e8](#) 45-р зүйлийг үзнэ үү.

²⁴⁵ Өмнө иш татсан 75-р зүйлт, 28-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилгооны талаарх санал дүгнэлт). Мөн 24-р зүйлт, 47-р зүйл (2010 оны Киевын зөвлөмжүүд), 24-р зүйлт, 47-р зүйл (2010 оны

128. Дээр дурдсан байдлыг харгалзан үзэж, шүүх томилгоог улс төржүүлэхээс зайлсхийхийн тулд, Улсын Дээд Шүүхийн шүүгчдийн томилгооны ажиллагаан дах УИХ-ын үүрэг оролцоог хууль тогтоомжоос хасахыг²⁴⁶ эсвэл наад зах нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгчийг сонгон шалгаруулах/нэр дэвшүүлэх журамд хяналт тавих үүрэг олгох зэргээр УИХ-ын оролцоог хязгаарлахыг хууль боловсруулагчдад зөвлөж байна.²⁴⁷
129. Эцэст нь дурдахад, хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь Гүрж улсын Улсын дээд шүүхийн шүүгчдийг сонгон шалгаруулах, томилох ажиллагаанд хийсэн ЕАБХАБ-ын санал дүгнэлттэй танилцаж лавлагаа хийж болно. Тус санал дүгнэлт нь олон улсын болон бүс нутгийн хэм хэмжээнд нийцсэн холбогдох болзол, шалгуур, шалгаруулах ажиллагааны талаар болон процедурын ил тод, нээлттэй байдлыг хэрхэн нэмэгдүүлэх талаарх зөвлөмжүүдийг тус тус тусгасан болно. Үүнтэй холбогдуулан дурдахад олон улсын түвшинд боловсруулан гаргасан зөвлөмжүүдэд²⁴⁸ сул орон тооны зар нь нэр дэвшигчид болон олон нийтэд хүртээмжтэй байж,²⁴⁹ ингэснээр сонгон шалгаруулах, томилох үйл явц нь аль болох нийгмийг бүхэлд нь хамарсан, мөн төлөөлөл багатай нийгмийн бүлгийн төлөөллийн нэр дэвшигчдэд нээлттэй, хүртээмжтэй байхыг тусгасан байдаг.²⁵⁰ Иймд сул орон тооны тухай зарыг бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, үүний дотор өдөр тутмын сонинд нийтлэх, бусад мэргэжлийн байгууллагын болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахим хуудсанд байрлуулах, ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болон ээлтэй байх нөхцөлийг нь хангах тухай заалт оруулахыг бодолцох нь зүйтэй.²⁵¹
130. Хуулийн 11.5-р болон 11.6-р зүйлд нэр дэвшигчдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, Шүүхийн Мэргэшлийн Хорооны ажлын алба нь нэр дэвшигчийн талаар олон нийтээс хуульд заасан шаардлага хангасан хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгаж, бодитой санал дүгнэлт гаргаж, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдэд танилцуулна гэж заасан байна. Ийнхүү иргэний

Европын Зөвлөлийн CM/Rec(2010)12, 65-р зүүлт 10,12,25,32-р зүйл (2007 оны Венецийн Комиссын Шүүхийн томилгооны талаарх тайлан) болон 34-р зүүлт, 49-р зүйл (2010 оны ЕШЗ3-ийн Шүүхийн зөвлөлүүдийн талаарх Санал дүгнэлт дугаар 10) тус тус харна уу.

²⁴⁶ Өмнө иш татсан (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн томилгооны талаарх санал дүгнэлт) болон Венецийн Комиссын Молдав улсын Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал дүгнэлтийн 27-р зүйл, [CDL-AD \(2018\)003](#), 2018 оны 3-р сарын 19-ний өдөр.

²⁴⁷ Өмнө иш татсан 82-87-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн томилгооны талаарх санал дүгнэлт).

²⁴⁸ Өмнө иш татсан 18-р зүүлт, 21-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон мөн өмнө иш татсан 120-р зүүлт, 9-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд).

²⁴⁹ Жишээ болгож [2013 оны Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын талаарх Истанбулын тогтоолыг үзнэ үү](#). Мөн иш татсан 12-р зүүлт, 12.3-р зүйл (2010 оны Шүүгчийн ёс зүйн талаарх Багалорын зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чийглэсэн арга хэмжээнүүд) болон өмнө дурдсан 9-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд).

²⁵⁰ Жишээ болгох үүднээс ЕАБХАБ-ын Үндэсний цөөнхий асуудлаарх Дэд комиссарын 2017 оны 11-р сард гаргасан [The Graz Recommendations on Access to Justice and National Minorities](#), 25-р хуудсыг мөн өмнө иш татсан Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлын талаарх Истанбулын тогтоолын 13-р бүлгийг харна уу.

²⁵¹ Үүний дотор харааны бэрхшээлтэй хүмүүст уншихад хялбар формат ашиглах, сонсох хувилбарт шилжих боломжийг хангах, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хадмал бичмэл формат хангах, мөн дуу авиа, дүрсгүй аудио, видео бичглэг тавих зэрэг орно.

нийгмийн төлөөллийг шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд оролцуулах явдал нь сайшаалтай бөгөөд сонгон шалгаруулах ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд ач холбогдолтой болно. Гэвч, нөгөөтэйгүүр нэр дэвшигчдийг үнэлэх ажиллагаанд тухайн шүүгчийн талаарх олон нийтийн үзэл бодлыг харгалзаж үзэхээс зайлсхийхийг холбогдох олон улсын байгууллагууд мөн зөвлөсөн байдаг.²⁵² Иймд **олон нийтээс ирсэн бүх мэдээллийг нягтлаж, шалгаж, үнэлэх**²⁵³ механизмыг боловсруулан хуулинд тусгах нь зүйтэй бөгөөд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн эцсийн шийдвэр гарахаас өмнө эдгээр ирсэн мэдээллийг няцаах нэр дэвшигчийн эрхийг нь хангах нь зохимжтой болно.

131. Процессын ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд сонгон шалгаруулалтын бусад ажиллагааны талуудыг мөн тодорхой тусгаж өгөх нь зүйтэй. Жишээ нь Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь сонгосон шүүгчдийн талаарх гаргасан шийдвэрийг хэвлэн нийтлэх үүрэгтэй эсэх тухай болон ярилцлагуудыг олон нийтэд нээлттэй явагдах талаар хуулинд тусгаагүй байна – мэдээж ийм заалтыг болгоомжтой ашиглах нь зүйтэй болно. Хэдийгээр шүүгчдийг сонгон шалгаруулах, томилох ажиллагааг нээлттэй явуулах нь шүүх эрх мэдлийн байгууллагад олон нийтийн итгэх итгэлийг хадгалах эерэг талтай ч,²⁵⁴ хууль боловсруулагчид нь сонгон шалгаруулалт болон томилгооны үйл ажиллагааны шатны аль нь олон нийтэд нээлттэй байхыг тогтоох нь зохистой бөгөөд ингэхдээ шүүхийн бие даасан байдлыг хамгаалах болон сонгон шалгааруулах, томилох ажиллагаанд олон нийтийн итгэлийг хангах хоорондын тэнцвэрийг хангах нь нэн чухал болно.²⁵⁵ Ялангуяа, тодорхой нийгмийн хүрээнд, шүүгчийг сонгон шалгаруулах, томилох ажиллагаа нь ил тод бус гэж үздэг эсвэл шүүхийн зөвлөл нь тал харсан шийдвэр гаргадаг гэсэн шүүмжлэлд өртдөг бол шүүхийн зөвлөл нь нэр дэвшигчдээс нээлттэй сонголт хэлбэрээр ярилцлага авах явдал нь томилгооны ажиллагаа нь хууль ёсных гэдэг итгэл үнэмшлийг буй болгож, эерэгээр сурталчилахад нааштай байх магадлалтай болно.²⁵⁶ Ийнхүү нээлттэй сонголт хэлбэрээр явагдах асуулга нь нэр дэвшигчдийн нэр хүндэд халдахгүй, хүндэтгэлтэй, шударга явагдах ёстой²⁵⁷ бөгөөд шүүхийн бие даасан, хараат бус байдалд аюул учруулахгүй байх ёстой

²⁵² Жишээ болгож, [2017 оны АИХЭГ-ын Украины Шүүхийн тухай болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн санал дүгнэлтийн](#) 69-р зүйл харна уу: Мөн өмнө иш татсан 227-р зүйл, 48-р зүйл (ЕШЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай санал дүгнэлт дугаар 17); болон Венецийн Комисс болон Европын Зөвлөлийн DHR-DGI, Украины шүүхийн тогтолцоо болон шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд хийсэн хамтарсан санал дүгнэлт, [CDL-AD\(2010\)026-e](#), 60-р зүйл тус тус харна уу.

²⁵³ Өмнө иш татсан 2017 оны АИХЭГ-ын Украины Шүүхийн тухай болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн санал дүгнэлтийн 69-р зүйлийг болон [Европын Зөвлөлийн Украины шүүхийн зөвлөлийн журмын талаар хийсэн санал дүгнэлтийн](#) 3.5-р зүйлийг харна уу. 2017 оны 4-р сар.

²⁵⁴ Өмнө иш татсан 75-р зүйл, 54-р зүйлийг харна уу (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилгооны талаарх санал дүгнэлт).

²⁵⁵ Өмнө иш татсан 55-р зүйлийг үзнэ үү.

²⁵⁶ Өмнө иш татсан 55-р зүйлийг үзнэ үү. Мөн жишээ болгож, 120-р зүйл, өмнө дурдсан 120-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд). Түүнчлэн өмнө иш татсан 249-р зүйл (2013 оны Шүүхийн үйл явч дах ил тод байдлын тухай Истанбулын тогтоол)-ын 4-р хэсгийг үзнэ үү.

²⁵⁷ Жишээ болгож, өмнө иш татсан 75-р зүйл, 62-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилгооны талаарх санал дүгнэлт) болон 25-р зүйл, 25-р зүйл (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн ил тод байдлын тухай тайлан)-д ил тод болон “хоорондоо уялдаатай журам дүрэм байхыг” онцолсон байдаг болно. Мөн түүнчлэн өмнө дурдсан 12-р зарчим (2016 оны Кейп Тауны Шүүгчдийг сонгон шалгаруулах/томилоход бие даасан хороодын гүйцэтгэх үүргийн талаарх зарчимууд).

болно. Хуулинд наандаж Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчид нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтын дүнг хэвлэн нийтлэх үүрэг хүлээх тухай тусгах нь зүйтэй болно, мөн түүнчлэн нэр дэвшигчдээс нээлттэй сонголт хэлбэрээр ярилцлага авах асуудлыг судалж болох юм.

5.5. Шүүгчийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх

132. Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалах гэх үндэслэлээр шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэхийг түдгэлзүүлсэн байна.²⁵⁸ Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг гурваас таван жилд дүгнэх шалгуур үзүүлэлт, журмыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл Шүүхийн мэргэшлийн хороотой хамтран боловсруулж, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална гэсэн заалт Монгол Улсын холбогдох хууль тогтоомжинд байсан. Гэвч эдгээр заалтыг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны дүгнэлтээр шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах мөн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн үүргийг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуулийн 49-р зүйлийн 1 дэх болон 4 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэлээр түдгэлзүүлсэн болно.²⁵⁹
133. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх ажиллагаа нь өөрөө шүүхийн хараат бус байдалд аюул заналхийлэл учруулахгүй гэдгийг онцлох нь зүйтэй. Шүүхийн хараат бус байдалд үзүүлэх нөлөөлөл нь үнэлгээний зорилго, дүгнэх шалгуур үзүүлэлт, журам болон дагуулах үр дагвар зэргээс ихэд хамаарна. Ерөнхийдөө шүүхийн систем дэх шүүгч нарын үйл ажиллагааны түвшинг үнэлж, дүгнэхэд чиглэсэн ажиллагаа нь²⁶⁰ үндсэн хоёр зорилготой байдаг, нэрлэвэл ардчилсан нийгэм дэх шударга шүүх ёс болон шүүхийн хариуцлагын түвшинг үнэлэх юм.²⁶¹ Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж, дүгнэх нь ерөнхийдөө шүүгч нар ажлаа сайжруулж болох зүйлийг тодорхойлоход нь туслах мөн карьераа ахиулах боломжийг нь нэмэгдүүлэхэд нь хэрэглэж болох аргачлал юм.²⁶²
134. Мэргэжлийн түвшинг үнэлэх, дүгнэх шалгуур болон журмыг тодорхойлох үүргийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь хүлээж, харин мэргэжлийн үнэлгээ хийх байгууллагын тухайд дотооддоо буюу тухайн шатны шүүхийн эсвэл бусад шатны шүүхийн шүүгчдийн төлөөллөөс бүрдсэн шүүгч нарын баг явуулж байх нь зохимжтой болно, харин Ерөнхий шүүхийн онцгой эрх үүргийн хүрээнд бус.²⁶³ Үнэлгээний арга хэлбэр болон шалгуурын тухайд, хуулиар тогтоосон аргачлал болон шалгуур дээр үндэслэн шүүгчдийн мэргэжлийн үнэлгээг хийх нь зохистой²⁶⁴ бөгөөд шүүгчийн бие даасан

²⁵⁸ Өмнө иш татсан 5-р зүүлт, 53-р хуудсыг харна уу. (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан).

²⁵⁹ Дээр иш татсан 53-р хуудсыг харна уу. (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан)

²⁶⁰ Өмнө иш татсан 18-р зүүлт, 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁶¹ Жишээ болгож, өмнө иш татсан 34-р зүүлт, 45-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Молдав улсын тухай урьдчилсан санал дүгнэлт), болон 227-р зүүлт, 49 (1) (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийн үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17) тус тус үзнэ үү.

²⁶² Өмнө иш татсан 18-р зүүлт, 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁶³ Өмнө иш татсан 30-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁶⁴ 2014 оны 6-р сарын 13-нд [АИХЭГ-ын Молдав улсын шүүгчдийг сонгон шалгаруулах, ажлыг нь үнэлж дүгнэх болон карьерын тухай хуулинд хийсэн санал дүгнэлтийн](#) 10.D болон 34-р зүйлийг тус тус харна уу.

байдлыг хязгаарлах магадлалтай учир ойр ойрхон бус байх нь чухал болно.²⁶⁵ [АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд](#) нь үнэлгээ нь чанарын үзүүлэлт буюу юун түрүүнд шүүгчийн ур чадварыг үнэлэхэд л оршино. Үүнд шүүгчийн мэргэжлийн ур чадвар (хууль эрх зүйн мэдлэг, шүүх хуралдаан явуулах чадвар, үндэслэлтэй шийдвэр гаргах чадвар), хувийн чадвар (ажлын ачааллыг даван туулах чадвар, шийдвэр гаргах чадвар, шинэ технологид нээлттэй байх чадвар), нийгмийн чадвар (зуучлах чадвар, талуудыг хүндэтгэх) мөн захиргааны албан тушаалд дэвшин ажиллах тохиолдолд, удирдах чадвар зэргийг тус тус үнэлэнэ.²⁶⁶ Шүүгчдийг гаргасан шийдвэр, тэдгээрийн үр дүн, гүйцэтгэлээр нь (шууд эсвэл цуцлах хувь хэмжээг тооцоолох замаар) үнэлж, дүгнэх ёсгүй болно.²⁶⁷ Шүүхийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн статистикийг үндсэндээ захиргааны зорилгоор ашиглах ёстой бөгөөд шүүгчийг үнэлэхэд нөлөөлж болох нэг хүчин зүйл байх нь зохимжтой.²⁶⁸ Шүүгчийн хараат бус байдалд аюул учруулахгүйн тулд тааламжгүй үнэлгээ, дүгнэлт нь шүүгчийг ажлаас нь огцруулахад хүргэх ёсгүй.²⁶⁹ Үнэн хэрэгтээ, үнэлгээний үйл явц нь юуны түрүүнд шүүхийн байгууллагын ажлыг сайжруулахад чиглэгдэх ёстой бөгөөд ийнхүү үнэлгээ нь зөрчил гаргасан тохиолдолд шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагын журмаар албан тушаалаас чөлөөлөх асуудалтай хамааралгүй байх ёстой.²⁷⁰ Үнэлгээний үйл явц нь шүүгчид өөрсдийн үйл ажиллагааны талаар болон ажлыг үнэлж буй үнэлгээний талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох ёстой. Үүний сацуу тааламжгүй үнэлгээ, дүгнэлттэй холбогдуулан бие даасан байгууллага эвсэл шүүхэд гомдол гаргах боломжийг мөн шүүгч нарт олгох ёстой.²⁷¹ Ямар ч тохиолдолд шүүгчийн үйл ажиллагааг үнэлэх ажиллагаанд мөрдөх үндсэн дүрэм нь шүүхийн хараат бус байдлыг бүхэлд нь хүндэтгэх явдал²⁷² бөгөөд үнэлгээний үйл ажиллагаанд оролцож буй шүүгчдэд мөн

²⁶⁵ Жишээ болгож, өмнө иш татсан 227-х зүүлт, 6-р зүйл (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17), болон 26-р зүүлт, 72-р зүйл (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн ил тод байдлын тухай тайлан) тус тус харна уу.

²⁶⁶ Өмнө иш татсан 18-р зүүлт, 27-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁶⁷ Өмнө иш татсан 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

²⁶⁸ Өмнө иш татсан 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд). Жишээлбэл, Испанид хэрэгжүүлдэг, тоон статистикийн шалгуур үзүүлэлтийг шийдвэрийг төрөл, сэдэв, нарийн төвөгтэй байдлаар нь ангилдаг чанарын статистикийн аргаар нөхөж болно (Европын шүүхийн зөвлөлийн сүлжээ (ENCJ), [Development of Minimal Judicial Standards III: Minimum Standards regarding evaluation of professional performance and irremovability of members of the judiciary](#) (2012-2013 он) 15-р хуудсыг тус тус харна уу.

²⁶⁹ Өмнө иш татсан 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд). Түүнчлэн 2014 оны 6-р сарын 13-ны өдрийн [АИХЭГ-ын Молдав улсын шүүгчдийг сонгон шалгаруулах, ажлыг нь үнэлж дүгнэх болон карьерын тухай хуулинд хийсэн санал дүгнэлтийн](#) 31-33-р зүйлийг харна уу. 2014 оны 6-р сарын 13-ны өдөр. Өмнө иш татсан 227-р зүүлт, 29-р зүйл (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17) үзнэ үү. Жишээ болгож, мөн 2015 [АИХЭГ-ын Украины Шүүгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний тухай журамд хийсэн санал дүгнэлтийн](#) 53-р зүйлийг үзнэ үү.

²⁷⁰ Өмнө иш татсан 34-р зүүлт, 45-р зүйлийг үзнэ үү (2019 оны АИХЭГ-ын Молдав улсын талаарх урьдчилсан санал дүгнэлт). Өмнө иш татсан 29-р зүйл (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17) үзнэ үү. Жишээ болгож, мөн АИХЭГ-ын Украины Шүүгчдийг сонгон шалгаруулах үнэлгээний тухай журамд хийсэн санал дүгнэлтийн 53-р зүйлийг үзнэ үү.

²⁷¹ Өмнө иш татсан 18-р зүүлт, 28-р зүйлийг харна уу (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд). Үүнд үнэлгээний дүнтэй танилцаж, давж заалдах эрхийг олгох нөхцөлийг хангах тгэж заасан болно. Жишээ болгож, өмнө иш татсан 41-о зүйлийг үзнэ үү (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17).

²⁷² Өмнө иш татсан 55-р зүүлт, 45-р зүйл (2001 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт дугаар 1) болон 34-р зүйлийг (2004 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт дугаар 6) тус тус харна уу.

процедурын баталгаа өгөх ёстой болно.²⁷³ Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь тухайн үнэлгээг хийснээр ямар тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтойг тодорхойлж, дээр дурдсан шалгуур дээр үндэслэн боловсруулсан шүүгчийн ажлыг үнэлэх механизмыг дахин нэвтрүүлэх шаардлагатай эсэхийг харгалзаж үзэх нь зүйтэй болно.

5.6. *Шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлага*

135. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31-37-р зүйл нь шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагыг зохицуулдаг бол 27-р зүйл нь шүүгчид хориглох зүйлийг тогтоосон байна. Юун түрүүнд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос хамгийн сүүлд гаргасан шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлага, арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох ёстой гэсэн зөвлөмжийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.²⁷⁴

5.6.1. *Сахилгын хариуцлага хүлээлгэх эрх бүхий байгууллага*

136. Одоогоор шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх үүргийг (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33-р зүйл) хуульд заасны дагуу шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр гаргасан гомдолд үндэслэн Шүүхийн ёс зүйн хороо гүйцэтгэдэг бөгөөд ирсэн гомдлыг хянаж, шалгаж, сахилгын хэрэг үүсгэх, эсвэл үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргадаг болно (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34-37-р зүйл). Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.1-р зүйлд Шүүхийн ёс зүйн хороо нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий ганц байгууллага байна гэж заасан байна. Нөгөөтэйгүүр тус хуулийн 8-р зүйлд шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах тухай саналыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ гэж заасан байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.3-р зүйлд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн саналыг үндэслэн шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож чөлөөлөх тухай заасан байхад мөн хуулийн 37.2-р зүйлд огцруулах сахилгын арга хэмжээ оногдуулсан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ гэж дурдсан байна. **Иймд шүүгчид сахилгын арга хэмжээ оногдуулсаны улмаас ажлаас нь чөлөөлөх, огцруулах шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь хэн болох нь тодорхой бус байгаа бөгөөд тодорхой болгох шаардлага байна.** Ямар ч тохиолдолд, тус санал дүгнэлтийн 4.4.2-р зүйлд дурдсаны дагуу, ёс зүйн асуудлаар зөвлөгөө өгөх болон сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, салгах нь зохимжтой²⁷⁵ бөгөөд Шүүхийн ёс зүйн хорооны эрх үүргийг бүрэн эргэн

²⁷³ Өмнө иш татсан 227-р зүүлт, 44-р зүйл (2014 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийг үнэлэх тухай Санал дүгнэлт дугаар 17) үзнэ үү. Үүнд ЕШЗЗ нь “ шүүгчийг үнэлэх үйл ажиллагаанд ороцлож буй шүүгч нарт мөн процедурын баталгаа өгөхийг” онцлон тэмдэглэсэн байна.

²⁷⁴ НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) [Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай 2017 оны тайлангийн талаарх дүгнэлтийн](#) 32-р зүйлийг харна уу.

²⁷⁵ Өмнө иш татсан 89-р зүүлт, 30-р зүйл (2014 оны АИХЭГ болон Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт)-ийг үзнэ үү.

харж, ёс зүйн дүрмийн талаар тайлбар өгөх болон ёс зүйн дүрэм боловсруулах л чиг үүргээр эрхийг нь хязгаарлахыг зөвлөж байна (82-83-р догол мөрийг харна уу).

137. Сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий, бие даасан байгууллага байгуулах тохиолдолд тус байгууллагын хараат бус байдлыг хангаж, гүйцэтгэх эрх мэдэл болон улс төрийн нөлөөллөөс ангид байх нөхцөлийг нь хангаж, ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн сахилгын баг байх нь нэн чухал болно.²⁷⁶ Үүний сацуу түүний гишүүдийг томилохдоо гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн нөлөөллөөс ангид байх нөхцөлийг нь хангах нь чухал. Тус санал дүгнэлтийн 4.4.2-р дэд хэсэгт дурдсаны дагуу шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэн байгууллага (Шүүхийн ёс зүйн хороо)-ын гишүүдийн бүрэлдэхүүн нь дээр дурдсан зарчимд нийцэхгүй байна, учир нь ХЗДХЯ-наас гурван хүний нэрийг дэвшүүлдэг болно. Ер нь бол, сахилгын хариуцлага хүлээлгэх байгууллага нь шүүгч нараас (захиргаа, төсөв санхүү болон шүүгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцдоггүй байх) бүрдсэн мөн шүүгч нар өөрийн үзэмжийн хүрээнд шийдвэр гаргахаас сэргийлэх үүднээс улс төрийн нөлөөллөөс ангид бөгөөд шүүгчийн алба ажил эрхэлдэггүй гишүүдээс бүрдэж байх нь зохимжтой.²⁷⁷ Тус санал дүгнэлтийн 80-р догол мөрөнд дурдсан, **Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч орохыг хориглосон заалт нь (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.3-р зүйл) асуудалтай бөгөөд бүхэлд нь эргэн харах нь зохимжтой болно.** Үүний сацуу, хорооны ихэнх гишүүд нь шүүгчид бус байхаас гадна, хорооны бүрэлдэхүүнийг болон даргыг Ерөнхийлөгч томилж буй явдал нь түүний шүүх засаглал дахь бусад томилгоо хийх эрх мэдэлтэй нь ижил байна (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.2-р зүйл). **Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагын гишүүдийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх болон томилох эрх, үүргийг ХЗДХЯ болон Ерөнхийлөгчид хүлээлгэхээс зайлсхийх нь зохимжтой (84-р догол мөрийг харна уу) бөгөөд ийнхүү эрх бүхий байгууллага нь ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нарын дундаас томилогдсон гишүүдээс бүрдэх нөхцөлийг хангах нь чухал болно.**
138. Ерөнхийлөгч мөн Хорооны дүрмийг баталдаг байна (Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.2-р болон 32.6-р зүйл). Ер нь бол [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмж](#)нд шүүхийн зөвлөл болон сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагын хяналтыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад өгөхөөс зайлсхийхийг тодорхой тусгасан байдаг.²⁷⁸ Иймд, **хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь**

²⁷⁶ Олон улсын стандартад зааснаар, шүүхийн хараат бус байдлыг хамгаалахын тулд, шүүгчийг сонгон шалгаруулах, томилох, үнэлэх болон бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, огцруулах зэрэгтэй холбоотой аливаа шийдвэрийг гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагаас хараат бус, бие даасан эрх бүхий байгууллага хэрэгжүүлж байхыг мөн гадны зохисгүй нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор тус байгууллага нь ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн байхыг зөвлөдөг болно. Өмнө иш татсан 19-р зүүлт, 1.3-р зүйл (1998 оны Европын Дүрэм); өмнө иш татсан 18-р зүүлт, 9.26 болон 30-р зүйлүүд (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд); 24-р зүүлт, 69-р зүйл (Европын Зөвлөлийн Зөвлөмж CM/Rec(2010)12); 26-р зүүлт, 50-р зүйл (2007 оны Венецийн Комиссын Шүүхийн зөвлөлүүдийн талаарх санал дүгнэлт № 10) болон [ЕПЗЗ-ийн 2002 оны Шүүгчийн ёс зүй болон хариуцлагын талаарх санал дүгнэлт № 3-ын](#) 71-р зүйлийг тус тус харна уу.

²⁷⁷ Өмнө иш татсан 9-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон 89-р зүүлт, 76-р зүйл (2014 оны АИХЭГ болон Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт)-ийг тус тус үзнэ үү.

²⁷⁸ Өмнө иш татсан 9-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагын дүрмийг батлах Ерөнхийлөгчийн эрх, үүргийг хүчингүй болгох нь зүйтэй. Дүрмийг сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллага өөрөө боловсруулах нь зохистой болно.

139. Шүүхийн мэргэшлийн хорооны тухайд, хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь хорооны гишүүдийг сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагын орон тооны бүс гишүүнчлэл олгосноор хорооны гишүүд өөрийн үүргээ мэргэжлийн, үр дүнтэй, үр өгөөжтэй, цаг тухайд нь гүйцэтгэх нөхцөлийг буй болгох эсэх асуудлыг судалж үзэж болох юм. Эс бөгөөс, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд нэвтрүүлэх боломжтой бөгөөд бодитой эсэхийг харгалзан үзэж, ЭЗХАХБ-аас мөн зөвлөсний дагуу,²⁷⁹ **бүрэн гишүүнчлэл олгох асуудлыг мөн судлан үзэж болох юм.**
140. Эцэст нь дурдахад, төрийн ямарч байгууллагын томилгооны тухайд, сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллагын гишүүдийг томилохдоо жендэрийн болон цөөнхий төлөөллийг харгалзан үзэж байх нь зохистой болно.²⁸⁰

5.6.2 Ёс зүйн зөрчил болон албан ажлаас чөлөөлөх, огцруулах үндэслэлүүд

141. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18-р зүйлд шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох тухай хоёр томъёолол байна: шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож “чөлөөлөх” болон шүүгчийг “огцруулах”. Хэдийгээр үндэслэл нь тодорхой тусгагдсан байгаа ч, энэ хоёрыг хэрэгжүүлэх процедурын хороондын ялгаа нь ойлгомжгүй байна. Магадгүй орчуулгын зөрүүний асуудал байж болох, Монгол хэл дээрх хуулийн найруулганд процедур нь ойлгомжтой байж болох ч, хуулинд чөлөөлөх болон огцруулах үйл ажиллагааны ялгааг нь мөн өөр өөр процедур хэрэглэдэг эсэхийг тодорхой оруулах нь зохимжтой болно.
142. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.3.2-р зүйлд шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө эрүүл мэндийн болон “хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар” шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд чөлөөлж болно гэж заасан байна. Энэхүү заалт нь тодорхой биш бөгөөд шүүгчийг үндэслэлгүй чөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж болохоор байна.²⁸¹ **Иймд “хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар” гэсэн заалтыг тодорхой болгохыг эсвэл хуулиас хасахыг зөвлөж байна.**
143. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд шүүгчийг албан ажлаас нь чөлөөлөх/огцруулах хэд хэдэн үндэслэлийг тусгасан байна, үүнд: шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн; сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн; гэм буруутайд тооцож

²⁷⁹ Өмнө иш татсан 5-р зүүлт, 15-16- хуудас дээрх Шинэ зөвлөмж 11.9 харна уу. (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан).

²⁸⁰ Өмнө иш татсан 89-р зүүлт, 5.1 дэл хэсэг (2014 оны АИХЭГ болон Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт)-ийг харна уу.

²⁸¹ Харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Oleksandr Volkov v. Ukraine](#) (Application no. 21722/11, judgment of 25 May 2013), “шүүгчийн тангарагийг зөрчөн” гэх үндэслэлээр огцруулсан тухай 174-185-р зүйлийг харна уу.

эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон; эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон гэх мэт (18.4-р зүйл). Үүний сацуу тус хуулинд шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож чөлөөлөх үндэслэлүүдийг мөн тусад нь тусгасан байна, жишээ нь шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан; шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон; шүүгч улс төрийн сонгуульд нэр дэвших болсон; шүүхийг татан буулгах, эсхүл өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан өөр шүүхэд шилжүүлэхээс шүүгч өөрөө татгалзсан; өөр ажилд шилжсэн буюу томилогдсон гэх мэт (18.3-р зүйл). Тус хуулийн 27-р зүйл түүнчлэн шүүгчид хориглох зүйлийг мөн тусгасан байна. **Тус хуулийн 27-р зүйлийг зөрчсөн тохиолдолд шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах тухай заалт байхгүй бөгөөд үүнийг хуулинд тодорхой болгох нь зүйтэй.** Нөгөөтэйгүүр тус хуулийн 27-р зүйлд заасан шүүгчид хориглох зүйлүүдийн зарим нь 18.4-р зүйлд заасан шүүгчийг чөлөөлөх/огцруулах үндэслэлүүдтэй давхцаж байна. Ийнхүү ижил үйлдэлд тодорхой хэмжээгээр хоорондоо давхцсан хэд хэдэн дүрэм журам хэрэглэж болох явдал нь хуулийн зохицуулалтын тухайд будилаан үүсгэж байна. Улмаар хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх асуудалд эргэлзээ төрүүлэх магадлалтай байна.²⁸² **Иймд хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид албан ажлаас чөлөөлөх/ огцруулах үндэслэл болон журмыг сахилгын хариуцлага ногдуулах үндэслэл, журмыг хооронд нь тус тус салгаж, тодорхой болгох нь зохимжтой юм.**²⁸³

144. Шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн гэх заалт (18.4.1-р зүйл) мөн ойлгомжгүй байна. Энэ нь тус хуулийн 27-р зүйлд заасан шүүгчид хориглох зүйлсийг хэлээд байна уу, эсвэл өөр үйл ажиллагааг хэлээд байгаа уу гэдэг нь ойлгомжгүй байна. **Үүнийг тодорхой болгох нь зүйтэй.** Үүний сацуу шүүгчийг албан ажлаас нь чөлөөлөх нэг үндэслэл болох сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн гэсэн заалт ойлгомжгүй байна (18.4.2-р зүйл). Энэ нь дээрх үндэслэлээр шүүгчийг албан ажлаас нь шууд огцруулах уу эсвэл сахилгын хариуцлага ногдуулах эрх бүхий байгууллага дахин хянах уу гэдэг нь тодорхой бус байна. Иймд тухайн шүүгчид процедурын хамгаалалтыг хангаж, сахилгын зөрчил гаргасан байж болзошгүй гэж үзэж байгаа бүх тохиолдолд, сахилгын шийтгэл дахин хүлээсэн байсан ч, холбогдох шүүхийн өмнө өмгөөлөл авах эрх болон давж заалдах эрхийг нь хангах нь чухал болно.²⁸⁴ **Иймд 18.4.2-р зүйлийг шүүгчийг шууд албан ажлаас нь огцруулах үндэслэл гэж тайлбарлаж болохгүй болно.**
145. Ерөнхийдөө, тодорхой бус ерөнхий тодорхойлолтыг өгөхөөс илүүтэйгээр, ийнхүү хориглох зүйлийг тодорхой жагсааж гаргасан явдал нь олон улсын стандартад нийцсэн

²⁸² Харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Rekvenyi v. Hungary](#) [GC] (Application no. 25390/94, judgment of 20 May 1999), 34-р зүйлийг харна уу.

²⁸³ Өмнө иш татсан 5-р зүүлт, 10-р хуудас болон 15-16-р хуудас дээрх Шинэ зөвлөмж 11 харна уу. (ЭЗХАХБ-ын 2019 Авлигын эсрэг шинэтгэлийн талаарх үнэлгээний тайлан).

²⁸⁴ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

сайн туршлага/ хандлага болно.²⁸⁵ Дээрх хуулийн 27-р зүйлд тусгасан хориглох зүйлүүд нь сахилгын зөрчилд тооцогдоно гэж үзэж, ийнхүү хориглох зүйлсийн жагсаалт байгаа нь сайшаалтай бөгөөд эдгээр нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад байдаг сахилгын зөрчлүүдийг ерөнхийд нь тусгасан байна. Нөгөөтэйгүүр 27-р зүйлийн 1.11-1.14-т гадаад улсын засгийн газар, байгууллага, иргэд болон олон улсын байгууллагатай харилцахыг шүүгчдэд хориглосон хэд хэдэн заалтууд байна. Бусад лавлагаа хийх контекстгүй учир ойлгоход хэцүү заалтууд байна. Жишээ нь Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллагын санхүүжилтээр эрдэм шинжилгээний болон судалгааны ажил эрхлэхийг яагаад хориглож буй нь тодорхой бус байна. Ийнхүү хориглож буй явдал нь, хэрэв зөв ойлгосон бол, Монгол улсын шүүгч нар гадаад улсын их дээд сургуулийн санхүүжилтээр эрдэм шинжилгээний болон судалгааны ажил эрхлэхийг хориглоно гэж ойлгож байна, энэ нь үндэслэлтэй бус харагдаж байна. Үүний сацуу жишээ нь шүүгч нь гадаад улсын эрдэм шинжилгээний хүндэт цол эсвэл бусад гадаад улсын засаг төр, олон нийтийн болон бусад байгууллагаас хүний эрхийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсаны төлөө тусгай цол, шагнал, одон, тэмдэг авахыг нь хориглож буй нь ойлгомжгүй байна. **Иймд 27-р зүйлийн 1.11-1.14-т заасан хориглосон зүйлийг зохимжтой эсэхийг ядаж эргэн харахыг, эсвэл хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид эл тухай Зөвлөлд мэдэгдэж байх үүрэг хүлээнэ гэх заалт оруулж болох юм.**

146. Үүний сацуу, шүүхийн өмнө бүгд эрх тэгш байх зарчмыг шүүгчид дагаж мөрдөх нь нэн чухал учир, **хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид 27-р зүйлд үндэс угсаа, хүйс, жендэр, шашин шүтлэг, итгэл үнэмшил, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн болон нийгмийн харьяалал зэрэг дээр үндэслэн ялгаварлан гадуурхах, шударга бус харьцаа, үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх, хориглох нөхцөл байдлын талаарх жишиг лавлагаа шүүгчдэд зориулан нэмж оруулах асуудлыг судалж үзэж болох юм. Шүүхийн албан хаагчид, хуульч өмгөөлөгчид болон хэргийн талуудад ч ийнхүү авир, үйлдэл гаргахыг хориглох үүрэг хүлээлгэх.**²⁸⁶
147. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1-р зүйлд шүүгч “зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжсүйгээр зөрчсөн бол” холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ гэж заасан байна. Нэгд, энэхүү заалт нь ойлгомжгүй бөгөөд хэт өргөн хүрээг хамарсан байна, иймд сахилгын хариуцлага хүлээлгэхэд хүргэх зөрчлийг нь тодорхой болгож, зөрчил гаргагч этгээд нь өөрийн гаргасан үйлдлийн үр дагварыг урьдчилан харж, зөрчил гаргахад хүргэх үйлдэлээ засаж залруулах боломжтой байх нь

²⁸⁵ Өмнө иш татсан 15-р зүйл, [АИХЭГ болон Венецийн Комиссын Молдав улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлтийг](#) CDL-AD(2014)006 болон [ЕПЗЗ-ийн Шүүгчийн ёс зүй болон хариуцлагын талаарх санал дүгнэлт № 3-ын](#) 63-65-р зүйлийг тус тус харна уу.

²⁸⁶ Өмнө иш татсан 22-р зүйл, 183-191-р зүйл (НҮБ-ын МБГХТА-ны Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчимуудад хийсэн тайлбар)-ийг үзнэ үү.

зохимжтой.²⁸⁷ Сахилгын хариуцлага хүлээлгэхэд хүргэх зөрчил, нөхцөлийг тодорхой тайлбарлан оруулснаар өөрийн үзэмжээр, субъектив шийдвэр гаргах үйлдлээс сэргийлэх талтай.²⁸⁸ Үүний сацуу ийнхүү 31.1-р зүйлд хэрэглэсэн өргөн хүрээг хамарсан хэллэг нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, эд мөрийн баримтыг үнэлэх, нотлох баримтыг үнэлж, дүгнэх зэрэг шүүгчийн ажилд сөрөг нөлөө үзүүлж, шүүгчдийг ороох нөхцөл дагуулах талтай байна. Гэхдээ дээр дурдсан алдаатай үйлдлийг шүүгчийн халдашгүй эрхээр хамгаалсан (тус санал дүгнэлтийн 5.3 дэд хэсэг үзнэ үү) бөгөөд санаатайгаар болон хайхрамжгүй байдлаас алдаа, зөрчил гаргаснаас бусад тохиолдолд шүүгчид алдаа, гаргасан зөрчлийн төлөө иргэний болон сахилгын хариуцлага хүлээхгүй юм.²⁸⁹ Үнэхээр сахилгын хариуцлага ногдуулах ажиллагаа нь шүүх засаглалыг үл хүндэтгэсэн онц ноцтой зөрчлийг л шийдвэрлэх бөгөөд шүүхийн шийдвэрийн болон шүүхийн үйл ажиллагааг шүүмжилсэн шүүмжийн агуулга үүнд хамаарахгүй болно.²⁹⁰ Эцэст нь, тус санал дүгнэлтийн 81-р догол мөрөнд дурдсан ёс зүйн дүрмийн тухайд, эдгээр дүрэм нь шүүгчид үйл ажиллагаандаа мөрдлөг болгох шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоосон, зөвлөмжийн чанартай байгаа бөгөөд үр дагварыг нь урьдчилан харах шаардлага мөн хангадаггүй тул тус дүрмийг шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эрх зүйн баримт бичигтэй дуйцүүлэн хэрэглэх нь зохимжгүй болно.²⁹¹ Иймээс, ёс зүйн дүрэм болон сахилгын хариуцлагын дүрмийг хооронд нь салгаж ойлгох хэрэгтэй.²⁹² Нөгөөтэйгүүр агуулгын хувьд маш тодорхой, нарийн зүйлчилсэн ёс зүйн дүрмүүд боловсруулж сахилгын хариуцлага тооцох зөрчлийн үндэслэл болгож хуулинд оруулж болох талтай юм. Дээрх асуудалтай холбогдуулан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-р зүйлийн шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ гэсэн заалт нь мөн асуудалтай байгааг дурдах нь зүйтэй болов уу.

148. Дээр дурдсантай холбогдуулан, **тус хулийн 31.1-р зүйлийг бүхэлд нь эргэн харахыг зөвлөхийн сацуу тус санал дүгнэлтийн 143-р догол мөрөнд санал болгосны дагуу тус хуулийн 27-р зүйлд заасан шүүгчид хориглох зүйлс нь сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэдгийг тодорхой болгох нь зүйтэй болно. Ямар ч**

²⁸⁷ Өмнө иш татсан 13-р зүүлт, 19-р зүйл (2007 оны НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) Ерөнхий Тайлбар 32)-рт “*гишүүн орнууд нь үндсэн хууль болон бусад хууль эрх зүйн тогтоомжонд шүүгчийг чөлөөлөх/огцруулах тодорхой, объектив шалгуур дээр үндэслэсэн журмыг боловсруулан, тогтоож, шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулах бүхий л арга хэмжээг авах үүрэг хүлээнэ*” гэжээ. Өмнө иш татсан 16-р зүйл, АИХЭГ болон Венецийн Комиссын Молдав улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлтийг [CDL-AD\(2014\)006](#) үзнэ үү. Мөн харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [N.F. v. Italy](#) (Application no. 37119/97, judgment of 2 August 2001), pars 29-30; and [Volkov v. Ukraine](#) (Application no. 21722/11, judgment of 1 January 2013), par 173ff. хэргүүдтэй танилцана уу.

²⁸⁸ Өмнө иш татсан 89-р зүүлт, 24-р зүйл (2014 оны АИХЭГ болон Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт)-ийг үзнэ үү.

²⁸⁹ АИХЭГ болон Венецийн Комиссын Молдав улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт [CDL-AD\(2014\)006](#)-ийн 20-23-р зүйл болон өмнө иш татсан 24-р зүүлт, 66-68-р зүйл (Европын Зөвлөлийн Зөвлөмж CM/Rec(2010)12) тус тус харна уу.

²⁹⁰ Өмнө иш татсан 18-р зүүлт, 25-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

²⁹¹ Өмнө иш татсан 136-р зүүлтийг харна уу.

²⁹² Өмнө иш татсан 89-р зүүлт 25-28-р зүйл (2014 оны АИХЭГ болон Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчийн сахилгын хариуцлагын тухай журамд хийсэн хамтарсан санал дүгнэлт)-ийг үзнэ үү. Мөн 2002 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийн ёс зүй болон хариуцлагын талаарх санал дүгнэлт № 3-ын 60-р болон 48(i) зүйл болон өмнө иш татсан 24-р зүүлт, 72-73-р зүйл (Европын Зөвлөлийн Зөвлөмж CM/Rec(2010)12)-ийг тус тус харна уу.

тохиолдолд, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд байгаа шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ гэсэн заалтуудыг хүчингүй болгох нь зохимжтой байна (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1, 32.2, 33.1 болон 37.1-р зүйлийг тус тус харна уу).

5.6.3. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх болон сахилгын журам

149. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1.8-р зүйлд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг үндэслэн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн саналаар шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ гэж заасан байна. Гэвч ийнхүү зөвлөмж гаргах үндэслэл болон журам горим, гарсан зөвлөмж нь хэр үндэслэлтэй болох нь тодорхой бус байгаагаас гадна ийнхүү гарсан зөвлөмжийн агуулгатай шүүгч танилцах эрхтэй эсэх нь мөн тодорхой бус байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн 33-р зүйлд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ гэж тусгасан байгааг дурдах нь зүйтэйгээс гадна түүний бүрэлдэхүүнд Ерөнхий сайд болон УИХ-ын дарга нар багтдаг байна. Иймд дээр дурдсан шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэл нь шүүгчийн бие даасан байдлыг ганхуулах, гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс зохисгүй хөндлөнгийн нөлөөлөл үзүүлэх нөхцөл үүсгэх асуудлыг хөндөж байна. **Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь шүүхийн эрх мэдлийн байгууллагын ажиллагаатай холбоотой асуудалд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн оролцоог эргэн харж, наад зах нь шүүгчийн бие даасан байдлыг хамгаалж баталгаажуулсан заалт оруулахыг зөвлөж байна. Үүний сацуу Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гаргасан зөвлөмж нь Шүүхийн Ерөнхий Зөвлөл заавал биелүүлэх ёстой зөвлөмж бус байхыг тусгахаас гадна тус зөвлөмж нь ул үндэслэл, сэдэлтэй байхыг мөн тусгах нь зүйтэй. Мөн шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлүүдийг тодорхой болгож, хязгаарлаж, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гаргасан зөвлөмжийн агуулгатай танилцаж, шүүхийн өмнө энэхүү зөвлөмжийг (эсвэл түдгэлзүүлэх шийдвэрийг) давж заалдах шүүгчийн эрхийг нь тус тус хангах нь зохистой болно. Түүнчлэн, түдгэлзүүлэхэд хугацаа байхгүй гэдгийг дурдах нь чухал бөгөөд үүнийг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 27-р зүйлд тодорхой оруулах нь зохимжтой болно. Зөвлөлийн бусад шийдвэрийн тухайд (тус санал дүгнэлтийн 4.3-р дэд хэсгийг үзнэ үү), түдгэлзүүлэх тухай шийдвэрийг хянаж шалгах нь зүйтэй болно. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэр нь “иргэний” эрхийг зөрчиж буй үйлдэл бөгөөд шүүгч нь ИБУТЭОУП-ын 14-р зүйлийн дагуу хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй.**²⁹³
150. Шүүгчтэй холбоотой гомдол, хүсэлтийг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн хүлээн авч шалгана гэж заасан байхад (34.1-р зүйл), сахилгын хэрэг үүсгэх шийдвэрийг Ёс зүйн хорооны гурван гишүүн хянаж, гаргана гэж заасан байгааг онцлох нь зүйтэй (34.2-р зүйл). Улмаар Ёс зүйн хороо сахилгын хэргийн хуралдаанд оролцсон гишүүдийн

²⁹³ Өмнө иш татсан 34-р зүйл, 105-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Молдав улсын талаарх урьдчилсан санал дүгнэлт) болон харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Paluda v. Slovakia](#) (Application no. 33392/12, judgment 23 May 2017) хэргийн 34-р зүйлийг тус тус харна уу.

олонхын саналаар шийдвэр гаргаж (35.1-р зүйл), гарсан магадлалыг шүүгч эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг байна (35.2-р зүйл). Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, нэг талдаа сахилгын хэрэг үүсгэх болон хянах ажиллагааг, нөгөө талдаа сахилгын хариуцлага ногдуулах шийдвэрийг хоёр тусдаа байгууллага гаргаж байх нь зохимжтой тухай олон улсын түвшинд боловсруулсан зөвлөмжинд тусгасан байдаг болно.²⁹⁴ [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжинд](#) мөн “шүүхийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэдэг байгууллагууд сахилгын хэрэг үүсгэж болохгүй бөгөөд тус байгууллагын бүрэлдэхүүнд нь сахилгын хэрэг үүсгэх эрхтэй гишүүн байх ёсгүй болно”²⁹⁵ гэж тодорхой тусгасан байдаг. Үүнтэй холбогдуулан дурдахад хуулийн 34-р болон 35-р зүйлд гомдол хүсэлт хүлээн авч шалгасан гишүүн болон сахилгын хэрэг үүсгэх шийдвэр гаргасан гишүүд нь сахилгын хариуцлага ногдуулах шийдвэр гаргах ажиллагаанд оролцож болохгүй гэсэн томъёолол байхгүй байна. **Иймд дээрх хуулийн 34-р болон 35-р зүйл заалтад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахыг зөвлөж байна.**

151. Хуулийн 18.6-р зүйлд шүүгчийг хугацаанаас өмнө огцруулах (18.4-р зүйл) болон шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн үндэслэлээр (18.5-р зүйл) Шүүхийн Ерөнхий Зөвлөл шүүгчийг огцруулах саналаа өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч огцуулах шийдвэр гаргадаг тухай заасан байна. Харин энэ тохиолдолд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дагаж мөрдөх процедурын тухай хуулинд нарийн зүйлчлээгүй байна. Хэдийгээр зарим үндэслэл нь шууд ойлгогдох ба жишээ нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн санал нь хүчин төгөлдөр шийдвэр дээр үндэслэсэн тохиолдолд (жишээ нь шүүгчийг гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон), зарим үндэслэлийг эргэн харж, үнэлэх шаардлагатай байгаа бөгөөд шүүхийн бие даасан болон шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс тодорхой процедур мөрдөх нь зохимжтой байна. Сахилгын хариуцлага нь ИБУТЭОУП-ын 14-р зүйлийн 1 дүгээр заалтын хамрах хүрээнд буюу иргэний эрхийн асуудалд²⁹⁶ нь багтаж байгаа бөгөөд НҮБ-ын Хүний эрхийн хорооны зөвлөмжинд сахилгын хариуцлагын ажиллагаа нь хараат бус, объектив, шударга явагдах ёстой гэж заасан байдаг болно.²⁹⁷
152. Ялангуяа, **Зөвлөлийн хуралдаанууд нь олон нийтэд нээлттэй явагдах эсэх талаар огт дурдаагүй байна, үүнийг тодорхой болгох нь зүйтэй.** [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжинд](#), сахилгын хариуцлага хэлэлцэх хуралдаан нь олон нийтэд нээлттэй байна, хэрэв сахилгын зөрчил гаргасан шүүгч нь өөр хүсэлт гаргаагүй бол, эл тохиолдолд хуралдааныг хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ гэж заасан

²⁹⁴ Өмнө иш татсан 18-р зүйлт, 5-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-д “Шүүхийн ерөнхий зөвлөлүүд нь а/ нэг талдаа сахилгын хэрэг үүсгэх болон хянах ажиллагааг, б/ нөгөө талдаа сахилгын хариуцлага ногдуулах шийдвэрийг гаргаж байх нь зохимжгүй болно” гэж тусгажээ. Мөн өмнө иш татсан 24-р зүйлт, 69-р зүйл (Европын Зөвлөлийн Зөвлөмж CM/Rec(2010)12 болон 2002 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №3-рт заасан 68-69 болон 77-р зүйлийг тус тус үзнэ үү.

²⁹⁵ Өмнө иш татсан 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) Шүүхийн хараат бус байдлын талаарх Киевын зөвлөмжүүд харна уу.

²⁹⁶ Өмнө иш татсан 89-р зүйлт, 105-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) харна уу.

²⁹⁷ Өмнө иш татсан 13-р зүйлт, 20-р зүйл (2007 оны НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн (CCPR) Ерөнхий Тайлбар 32).

байна.²⁹⁸ Гэхдээ, ийнхүү зөрчил гаргасан шүүгч нь яг ямар тохиолдолд хуралдааныг хаалттай явуулах хүсэлт гаргах эрх эдлэхийг нь тодорхой тогтоож өгөх нь зохимжтой болно.²⁹⁹ Үүнтэй холбогдуулан хуульд заасан нөхцөлд, олон улсын хууль тогтоомж, олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцсэн тохиолдолд ажиллагааг *хаалттай* явуулж болно гэдгийг ЕАБХАБ-ын гишүүн орнууд хүлээн зөвшөөрсөн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.³⁰⁰ Улмаар, шүүгчийн тавьсан хүсэлтийг л үндэслэн хуралдааныг хаалттай явуулах зөвшөөрлийг шууд өгөх нь зохимжгүй, харин ийнхүү тавьсан хүсэлт нь хэр үндэслэлтэй болохыг Хороо судлаж үзэх нь зохистой болно.³⁰¹ Ийнхүү шийдвэрийг тухай бүрт нь хүсэлтийн үндэслэл, нөхцөл байдал зэрэгт үнэлэлт дүгнэлт хийж, ИБУТЭОУП-ын 17-р зүйлээр баталгаажсан шүүгчийн хувь хүний нууц, нэр төр, алдар хүндээ хамгаалах эрхийг нь хүндэтгэн үзэж, гаргаж байх нь зүйтэй.³⁰² Цаашилбал, хуралдааны нээлттэй, ил тод байдлыг сурталчлах үүднээс, тухайн хэлэлцэх асуудлаас хамааран, Хороо нь ийнхүү хуралдааны тов, цаг, газрын тухай мэдээллийг³⁰³ олон нийтэд хүртээмжтэй газар байршуулж байх нь зохимжтой болно. **Хуулинд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.**

153. Үүний сацуу, **шүүгчтэй холбоотой сахилгын хянан шалгах үйл ажиллагааны талаар, шүүгчийн эсрэг гарсан гомдлын мөн чанар болон нотлох баримтын талаар урьдчилан мэдээлэл авах шүүгчийн эрхийн талаар** хуульд огт тусгаагүй байна. [НҮБ-ын Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчимүүдэд](#) “шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны эсрэг гомдолтой холбогдуулан эхний хэлэлцэх үе шатанд нь түүнд тайлбар хийх боломжийг хангах ёстой” мөн “шүүгчтэй холбоотой хянан шалгах үйл ажиллагааны үе шатанд шүүгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нууцлалтай байна” гэж заасан байдаг.³⁰⁴ **Хуулинд эл талаар тусгах нь зүйтэй.**
154. Хянан шалгах үйл ажиллагааны үед, маргаантай талуудын хооронд “шударга тэнцвэр”-ийг баримтлах зарчмыг шаарддаг бөгөөд талуудад эсрэг талтай харьцуулахад мэдэгдэхүйц сул нөхцөл байдалд оруулаагүй нөхцөлд хэргийг

²⁹⁸ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд). Шүүгчийн тавьсан хүсэлтийг л үндэслэн хуралдааныг хаалттай явуулах зөвшөөрлийг шууд өгөх нь зохимжгүй, харин ийнхүү тавьсан хүсэлт нь хэр үндэслэлтэй болохыг судлаж үзэж, тухай бүрт нь хүсэлтийн үндэслэл, нөхцөл байдал зэрэгт үнэлэлт дүгнэлт хийж шийдвэрлэж байхыг АИХЭГ болон Венецийн Комисс зөвлөдөг болно. Өмнө иш татсан 89-р зүүлт, 106-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) харна уу.

²⁹⁹ Өмнө иш татсан 106-р зүйлийг харна уу.

³⁰⁰ ЕАБХАБ-ын Хүний эрхийн хэмжигдэхүүний Копенгагены бага хурлын баримт бичгийн 12-р зүйлийг харна уу. Копенгаген хот, 1990 он.

³⁰¹ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) харна уу. Харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Diennet v. France](#) (Application no. 18160/91, judgment of 26 September 1995) хэрэгтэй танилцана уу.

³⁰² Өмнө иш татсан 89-р зүүлт, 106-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) харна уу.

³⁰³ Хүний эрхийн зөвлөлийн, [Van Meurs v. the Netherlands](#), Human Rights Committee Communication №.215/1986, UN Doc CCPR/C/39/D/215/1986 (1990), par 6.2. танилцана уу.

³⁰⁴ Өмнө иш татсан 11-р зүүлт, Зарчим 17 (1985 оны Шүүхийн хараат буй байдлын талаарх НҮБ-ын ерөнхий зарчимууд) харна уу.

танилцуулах боломж олгохыг шаарддаг болно.³⁰⁵ Үүнтэй холбогдуулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөж байна. Үүний сацуу, шүүгчтэй холбоотой сахилгын хорооны хуралдаанд тухайн шүүгч өөрийн биеэр оролцох³⁰⁶ эсвэл түүний сонгосон өмгөөлөгч төлөөлөн оролцох эрхийг нь хангах ёстой болно.³⁰⁷ Хуулинд энэ талаар тусгах нь зүйтэй.

155. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-р зүйлд заасны дагуу Хорооноос гарах шийдвэр нь үндэслэлтэй байх бөгөөд үндсэн дүгнэлт, нотолгоо, эрх зүйн үндэслэлийг агуулсан байх нь³⁰⁸ чухал бөгөөд ингэснээр шүүгч буюу нэхэмжлэгч шийдвэрийн хууль ёсны байдлыг үнэлэх боломжтой болно.³⁰⁹ Мөн гарсан шийдвэрийг давж заалдах тохиолдолд хүссэн үр дүндээ хүрэх эсэхэд дүн шинжилгээ хийх боломжийг олгож байна. Нэмж дурдахад, [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмж](#)нд сахилгын арга хэмжээ авах тухай эцсийн шийдвэрийг хэвлэн нийтлэх тухай заалтыг хуулинд оруулахыг зөвлөдөг.³¹⁰ Эдгээр асуудлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлд тусгах нь зүйтэй болно.
156. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.6-р зүйл болон 37.2-р зүйлд шүүгчийг ажлаас чөлөөлөх/огцруулах тохиолдолд Шүүхийн Ерөнхий Зөвлөл саналаа Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ гэж тусгасан байна. Энэ асуудлаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх нь зөвхөн бэлгэдлийн чанартай эсэх нь тодорхойгүй байна. Ерөнхийдөө шүүгчид сахилгын хариуцлага ногдуулах ажиллагаанд гүйцэтгэх засаглал/ерөнхийлөгч оролцох нь шүүгчийн хараат бус байдалд ноцтой хохирол учруулж, эрх мэдэл хуваах зарчимтай зөрчилддөг.³¹¹ [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмж](#)нд “шүүхийн сахилгын хариуцлага хүлээлгэх байгууллагын үйл ажиллагааг гүйцэтгэх засаглал хянах ёсгүй бөгөөд үүнд улс төрийн нөлөөлөл байх ёсгүй [болон] шүүхийн зөвлөл эсвэл сахилгын хариуцлага хүлээлгэдэг байгууллагууд нь гүйцэтгэх

³⁰⁵ Өмнө иш татсан 89-р зүүлт, 107-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) харна уу. Мөн харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [Werner v. Austria](#) (Application no. 21835/93, judgment of 24 November 1997), хэргийн 63-р зүйлтэй танилцана уу.

³⁰⁶ Хүний эрхийн зөвлөлийн, [Aarela and Nakkalajarvi v. Finland](#), Communication no. 779/1997, UN Doc CCPR/C/73/D/779/1997 (2001), 7.4-р зүйлтэй танилцана уу. Харьцуулалт хийх зорилгоор өмнө иш татсан 19-р зүүлт 5.1-р зүйл 1998 оны Европын Дүрэмд: “шүүгчтэй холбоотой сахилгын хорооны хуралдаанд тухайн шүүгч өөрийн биеэр оролцох эсвэл түүний сонгосон өмгөөлөгч төлөөлөн оролцох эрхийг нь хангах ёстой болно” гэж заасан байна.

³⁰⁷ Хүний эрхийн зөвлөлийн, [Kulov v. Kyrgyzstan](#), Communication 1369/2005, UN Doc CCPR/C/99/D/1369/2005 (2010), 8.7-р зүйлтэй танилцана уу. Мөн өмнө иш татсан ЕАБХАБ-ын Венагийн хурлын эцсийн тайлангийн 13.9-р зүйлтэй танилцана уу. Вена хот 1989 он.

³⁰⁸ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-д “гарах шийдвэр нь үндэслэлтэй байх бөгөөд үндсэн дүгнэлт, нотолгоо, эрх зүйн үндэслэлийг агуулсан байх нь чухал” гэж заасан байдаг. Мөн Хүний эрхийн хорооны Ерөнхий Тайлбар №12-ын 29-р зүйлийг харна уу. Харьцуулалт хийх зорилгоор ЕХЭШ-ийн [H. v. Belgium](#) (Application no. 8950/80, judgment of 30 November 1987) хэргийн 53-р зүйлтэй танилцана уу.

³⁰⁹ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон харьцуулалт хийх зорилгоор өмнө иш татсан 89-р зүүлт, 108-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) тус тус үзнэ үү.

³¹⁰ Өмнө иш татсан 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон 13-р зүүлт, 29-р зүйл (2007 оны НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн (CCPR) Ерөнхий Тайлбар 32 тус тус харна уу.

³¹¹ НҮБ-ын ХЭЗ-ийн [Human Rights in the Administration of Justice - A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers](#) гарын авлагын 8-р хуудас, 4.6-р заалтыг харна уу. Түүнчлэн [АИХЭГ-ын Польш улсын Дээд шүүхийн тухайн хуулийн зарим заалтуудад хийсэн санал дүгнэлтийн](#) (2017.09.26-ны өдрийн байдлаарх) 119-р зүйлийг үзнэ үү. 2017 оны 11-р сарын 13-ны өдөр.

засаглалын аливаа хяналтаас ангид байх нь зохистой” гэжээ.³¹² Шүүгчийг чөлөөлөх/огцруулахад Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь бэлгэдлийн чанартай төдий бол ийнхүү эрх мэдлийг бүрэн эргэж харах нь зүйтэй. Тус хуулийн 18.6-р болон 18.7-р зүйлд тус тус заасан УИХ болон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн тухайд, шүүгчийг чөлөөлөх/огцруулах Ерөнхийлөгчийн үүргийг шүүгч томилох түүний үүрэгтэй адилтгаж хязгаарлахыг зөвлөж байна. Хэрэв дээрх бүрэн эрхийг нь хадгалах бол, тухайн шүүгчийг чөлөөлөх/огцруулах асуудлаар шийдвэр гаргах эрхгүй байхаар зохицуулах. Түүнчлэн Дээд шүүхийн шүүгчдийг томилоход УИХ-ын бүрэн эрхийг хасах тухай дээрх зөвлөмжийг хүлээж авбал УИХ-тай холбогдох заалтуудыг хасах нь зүйтэй. Юутай ч УИХ нь шүүгчдийг чөлөөлөх/огцруулах ажиллагаанд бэлгэдлийн үүрэг гүйцэтгэх нь зохимжтой болно.

5.6.4. Сахилгын хариуцлага

157. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-р зүйлд шүүгчид дараах сахилгын арга хэмжээний аль нэгийг авна гэж заасан байна, үүнд: сануулах; зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах; огцруулах. Гэвч хуулинд тухайн гаргасан зөрчилд нь аль сахилгын арга хэмжээ нь дүйцэх тухай огт тусгаагүй байна. **Иймд, сахилгын арга хэмжээг пропорциональ зарчимд тулгуурласан байхыг хуулинд тусгасан байх нь зохимжтой болно.** Дээрх зарчмыг эрүүгийн байцаан шийтгэх хуулинд тодорхой зүйлчлээгүй л бол, үйлдсэн зөрчлийн хүндийн байдлаас шалтгаалан сахилгын арга хэмжээг нь ногдуулах тухай тодорхой тусгах нь зүйтэй болно.³¹³
158. Нөгөөтэйгүүр, эрх бүхий байгууллага нь сахилгын арга хэмжээг ногдуулах боломжит сахилгын арга хэмжээний сонголттой байх нь пропорциональ зарчмыг хангахад нь дөхөмтэй байлгана.³¹⁴ **Иймд хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид нь 37.1-р зүйлд, ихэнх улс орнуудад мөрддөг шиг, сахилгын бусад арга хэмжээг нэмж оруулах асуудлыг судлаж үзэх нь зүйтэй.** Эдгээрт, жишээ нь, зэрэг дэв эсвэл албан тушаал буруулах, албан тушаал дэвшүүлэхийг түдгэлзүүлэх, зарим давуу эрхийг нь хязгаарлах, өөр шатны шүүх рүү шилжүүлэх,³¹⁵ ажлаас нь түр чөлөөлөх, хугацаанаас нь өмнө нэмэлт тэтгэмжтэй чөлөөлөх болон хугацаанаас нь өмнө аливаа тэтгэмжгүй чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүдийг судлах.³¹⁶

5.6.5. Сахилгын хариуцлагын арга хэмжээг давж заалдах

159. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль нь сахилгын хариуцлага ногдуулдаг байгууллагын шийдвэрийг давж заалдах боломжийн тухай огт дурдаагүй байна. Олон

³¹² Өмнө иш татсан 18-р зүүлт, 9-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд).

³¹³ Өмнө иш татсан 89-р зүүлт, 66-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) үзнэ үү.

³¹⁴ Өмнө иш татсан 64-р зүйлийг үзнэ үү.

³¹⁵ Өмнө иш татсан 24-р зүүлт, 52-р зүйл (2010 оны Европын Зөвлөлийн Зөвлөмж CM/Rec (2012)12)-рт “сахилгын зөрчил эсвэл шүүхийг өөрчлөн байгуулахаас бусад тохиолдолд шүүгчийг өөрт нь мэдэгдэлгүйгээр шинэ ажилд томилох эсвэл өөр ажил руу шилжүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг.

³¹⁶ Өмнө иш татсан 89-р зүүлт, 64-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) үзнэ үү.

улсын хэм хэмжээний дагуу, хүн болгон захиргааны шийдвэрийг давж заалдах эрхтэй болно.³¹⁷ Үүний сацуу шүүхийн зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагын гаргасан сахилгын хариуцлагын шийдвэрийг давж заалдах боломжийг хангах явдал нь олон улсын болон бүс нутгийн түвшинд боловсруулсан зөвлөмжүүдэд нийцэнэ.³¹⁸ Ялангуяа шүүгчид сахилгын хариуцлагын арга хэмжээ ногдуулсан тохиолдолд ийнхүү эрхийг нь хангах механизм байх нь шүүгчийн болон шүүхийн бие даасан байдалд чухал болно. АИХЭГ-ын баримталдаг арга барил, практикт, шүүгчид сахилгын хариуцлагын арга хэмжээ ногдуулдаг байгууллагын шийдвэрийг ИБУТЭОУП-ын 14-р зүйлийн 1-т тусгасан “тусгай шүүх” гэдэг томъёолол доор дээрх сахилгын хариуцлагын байгууллага тооцогддог үл тооцогддог эсэхээс үл хамааран, шүүхийн өмнө давж заалдах³¹⁹ боломжийг олгодог болно. Хэрэв ийнхүү “тусгай шүүх” нь шүүгчийг бүрэн эрхийнх нь хугацаанаас өмнө огцруулах тухай шийдвэр дагуулсан зөрчлийн хэргийг тал үл барих зарчмаар бүрэн хянаж шалгах чадвартай бол, ИБУТЭОУП-ын 14-р зүйлийн 1-ийн дагуу, ийнхүү огцруулах сахилгын арга хэмжээ авсан шүүгч нь дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шүүхэд хэргээ хянан шийдвэрлүүлсэн гэж үзнэ.³²⁰ **Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулинд сахилгын хариуцлага ногдуулдаг эрх бүхий байгууллагын сахилгын арга хэмжээ ногдуулсан шийдвэрийг зохих шатны шүүхэд давж заалдах боломжийн тухай заалт оруулах нь зүйтэй. Ийнхүү ногдуулсан арга хэмжээг давж заалдах шатны шүүх байгууллагын эцсийн шийдвэр гаргал нь түдгэлзүүлэх нь зохистой болно.**

5.7. Шүүгчийн сургалт

160. Олон улсын хүний эрхийн мониторингийн байгууллагууд Монгол улсад шүүгчдийг сургалтад хамруулж байх асуудлыг онцлон тэмдэглэсэн байдаг, ялангуяа олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн тухай,³²¹ эрүүдэн шүүх бүх хэлбэрийг хориглох тухай,³²² эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл болон хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн хэрэгт тооцох тухай, гэмт хэргийн хохирогчдын эмзэг байдлын тухай,³²³ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах ялангуяа эрх

³¹⁷ ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн 5.10-р зүйлийг харна уу.

³¹⁸ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-д холбогдох шатны шүүхэд давж заалдах эрхийг олгохыг санал болгодог. Түүнчлэн өмнө иш татсан 11-р зүүлт, Зарчим 10 (1985 оны Шүүхийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын Ерөнхий зарчимууд) болон харьцуулалт хийх зорилгоор 144-р зүүлт, 77 (v) зүйл (2002 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №3) тус тус танилцана уу.

³¹⁹ Өмнө иш татсан 18-р зүүлт, 26-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон өмнө дурдсан 111-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлт) тус тус харна уу. Мөн [Венецийн Комиссын Албани улсын үндсэн хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд хийсэн санал дүгнэлтийн](#) 116-р зүйлийг үзнэ үү. 2015 оны 12-р сарын 21-ний өдөр.

³²⁰ Өмнө дурдсан 89-р зүүлт, 113-р зүйл (2014 оны АИХЭГ- Венецийн Комиссын Киргиз улсын шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх талаарх төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлтийг үзнэ үү.

³²¹ НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) [Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай зургаа дахь тайлангийн талаарх дүгнэлтийн](#) 6-р зүйл (2017 оны 8-р сарын 22).

³²² [Эрүүдэн шүүхийн эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн хоёр дахь тайлан](#), 2016 оны 9-р сарын 5-ны өдөр.

³²³ Дээр иш татсан НҮБ-ын хорооны тайлангийн 23-24-р зүйл, 28 (f) болон 38 (a) зүйлийг тус тус харна уу. Мөн өмнө иш татсан 73-р зүүлт, 2016 онд Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах НҮБ-ын конвенцийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлангийн 196 зүйл болон [НҮБ-ын ЭЗНСЭХ-ны Монгол улсын төлөв байдлын тухай 4 дэх тайлангийн](#) 21-р зүйлийг тус тус харна уу. 2015 оны 7-р сарын 7-ны өдөр.

зүйн чадамжийг нь хүлээн зөвшөөрөх тухай, шийдвэр гаргалтыг дэмжих механизм,³²⁴ ёс зүй, авлигатай тэмцэх болон шударга ёсыг сахиулах³²⁵ зэрэг чиглэлээрх (заавал хамрагдах) сургалтуудыг дурдсан байна. **Дээр дурдсан сургалтын сэдвүүдийг Шүүхийн захиргааны тухай хуулийн 10.1.4-р зүйлд шүүгчийг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг дурдсан хэсэгт тусгайлан тэмдэглэж болох юм.**

6. Шүүхийн ерөнхий шүүгчид болон Улсын Дээд Шүүхийн танхимын тэргүүн нар

6.1. Шүүхийн Ерөнхий шүүгчдийн томилгоо

161. Шүүгчийн эрх зүйн байдлын тухайн хуулийн 15.4-р зүйлийн дагуу Улсын Дээд Шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч гурван жилийн хугацаагаар томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно гэж заасан байна. Шүүхийн тухай хуулийн 12.4-р зүйлд Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч томилж болно гэж заажээ. Шүүгчийн эрх зүйн байдлын тухайн хуулийн 14.2-р зүйлд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг журмыг баримтлана гэсэн заалт нь бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах ажлыг Шүүхийн Ерөнхий Зөвлөл зохион байгуулна гэж ойлгогдож байна. **Цаашид үл ойлгогдох, харилцан уялдаагүй, давхардсан утга бүхий заалтуудын хуулийн найруулгыг оновчтой болгох нь зохимжтой болно. Ялангуяа шүүхийн ерөнхий шүүгч нарын томилгоонд Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүргийг тус тус тодорхой болгох нь чухал болно.**
162. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.4-р зүйлийг харахад бусад шүүхийн–анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхийн - ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч томилохдоо Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн саналыг дагах үүрэгтэй эсэх нь тодорхой бус байгаа бөгөөд энэ нь Ерөнхийлөгчийн томилгоо нь бэлгэдлийн чанартай/процедур эсэх, эсвэл Ерөнхийлөгч шүүгч нарыг сонгож томилдог гэсэн утгатай эсэх нь ойлгомжгүй байна. Сүүлд дурдсан утга агуулсан тохиолдолд энэ нь шүүх засаглалд гүйцэтгэх засаглалын зохисгүй нөлөөлөл үзүүлэх үр дагавартай учир шүүхийн хараат бус болон шүүгч нарын бие даасан байдалд хамаарах ноцтой асуудал дагуулна. Улмаар ийнхүү Ерөнхийлөгч болон түүний томилсон ерөнхий шүүгч нарын хооронд шатлан захирах ёсны харилцааг үүсгэж, шүүхийн бие даасан, хараат бус байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай болно.
163. Шүүхийн ерөнхий шүүгч нарын томилгоо нь бусад шүүгч нарыг сонгон шалгаруулах, томилох журмын дагуу явагдах ёстой гэж үздэг. Үүний дотор нэр дэвшигчдийг үнэлэх

³²⁴ [НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хангах тухай Конвенцийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайлангийн](#) 21-р зүйлийг харна уу. 2015 оны 5-р сарын 13-ны өдөр.

³²⁵ Өмнө иш татсан 5-р зүүлт, 10-р хуудас (2019 оны ЕЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан).

ажлыг шүүгчийг сонгон шалгаруулах/томилох эрх бүхий хараат бус байгууллага нь тогтсон, тодорхой болон бодитой шалгуураар, нэр дэвшигчийн удирдан зохион байгуулах туршлагыг нь мөн харгалзаж, мерит зарчим дээр үндэслэн явуулахыг зөвлөдөг.³²⁶ Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, хуулинд шүүгчдэд ерөнхийдөө тавигддаг шалгуураас өөр шалгуурын тухай дурдаагүй байна (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14.1-р зүйл). Үүний сацуу тухайн шатны шүүгчид нь сонгох үйл явцад заавал санал өгөх³²⁷ эсвэл зөвлөх хоолотой оролцох тухай эсвэл ерөнхий шүүгчийг шууд сонгох тухай мөн дурдаагүй байна.³²⁸

164. Дээр дурдсантай холбогдуулан, **ерөнхий шүүгч нарыг бусад шүүгч нарыг томилдог журмаар, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн оролцоотойгоор, тухайн шүүхийн шүүгч нарын саналыг харгалзан үзэж, Ерөнхийлөгч нь өөрийн бэлгэдлийн/процедурын үүргийн хүрээнд томилж байхыг зөвлөж байна. өөр нэг сайн хувилбар бол тухайн шатны шүүгчид өөрсдөө ерөнхий шүүгчээ сонгох явдал байна, ЭЗХАХБ-гаас адил зөвлөмж өгсөн болно.**³²⁹ Ямарч тохиолдолд тус санал дүгнэлтийн шүүхийн томилгооны тухай тус санал дүгнэлтийн 5.3-р дэд хэсэгт дурдсан зөвлөмжүүд мөн хамаарна.
165. Үүний сацуу ерөнхий шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаа нь ил тод, нээлттэй байж, сул орон тооны тухай зарыг хэвлэн нийтэлж, албан тушаал/ ажлын туршлагатай бүх шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй байх нь чухал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.³³⁰ Энд мөн төрийн болон хувийн хэвшил дэх, ялангуяа удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахыг Монгол Улсад зөвлөсөн зөвлөмжийг дурдах нь зүйтэй болов уу.³³¹ Цаашилбал, **Монгол Улсын шүүхийн байгууллагын ерөнхий шүүгчид нэр дэвшигчдийг томилохдоо эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцангуй тэнцвэртэй төлөөллийг (үүнд цөөнхийн бүлгийн төлөөлөл, ялангуяа үндэсний цөөнх болон хөгжлийн бэршээлтэй иргэдийн төлөөлөл зэрэг) хангах механизм нэвтрүүлэхийг хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид судалж болох юм. Ингэхдээ нэр дэвшигчдэд тавигддаг ажлын туршлага болон мэргэшлийн шаардлагуудын шалгуурыг хөндөхгүй байх (118-р догол мөрөнд дурдсан механизмуудыг харна уу).**

³²⁶ Өмнө иш татсан 18-р зүйлт, 16-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон харьцуулат хийх зорилгоор [ЕШЗЗ-ийн Шүүхийн Ерөнхий шүүгч нарын үүргийн тухай санал дүгнэлт № 19-ийн](#) 38-р зүйлийг тус тус үзнэ үү. 2016 оны 11-р сарын 10-ны өдөр.

³²⁷ Өмнө иш татсан 16-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) болон ЕШЗЗ-ийн Шүүхийн Ерөнхий шүүгч нарын үүргийн тухай санал дүгнэлт № 19-ийн 38-р зүйлийг үзнэ үү.

³²⁸ Жишээ болгож [Венецийн Комиссын болон ЕЗ-ийн Гүрж улсын шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд хийсэн хамтарсан санал дүгнэлтийн 84-р зүйл](#), CDL-AD (2014)031, 2014 оны 10-р сарын 14-ний өдөр.

³²⁹ Өмнө иш татсан 5-р зүйлт, 15-16-р хуудас, Шинэ зөвлөмж 11 (2019 оны ЕЭЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан) үзнэ үү.

³³⁰ Өмнө иш татсан 18-р зүйлт, 16-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

³³¹ НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын тухай зургаа дахь тайлангийн талаарх дүгнэлтийн 10-р зүйл (2017 оны 8-р сарын 22).

6.2. Улсын Дээд Шүүхийн Ерөнхий Шүүгчийн томилгоо

166. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох ажиллагааг Шүүхийн тухай хуулийн 12.3-р зүйл болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.3-р зүйлд заасны дагуу зохицуулдаг. Улмаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилдог байна. **Ерөнхий шүүгчийг улируулан томилж болох үгүй нь ойлгомжгүй байгаа учир тодруулах нь зүйтэй болно. Үүний сацуу Улсын дээд шүүхээс санал болгох болон санал хураах ажиллагаа, сонгуулийн журмын тухай дурдаагүй байна, хэрэв байдаг бол, сонгон шалгаруулах, томилох ажиллагааг тодорхой байлгах болон зөрчлөөс сэргийлэх үүднээс сонгуулийн журмыг хуулинд нарийвчлан тусгах нь зохимжтой болов уу.**
167. Үүний сацуу, дээрх томилгооны процедур нь шүүгчдийг томилохтой холбогдуулан тус тайланд өмнөх хэсэгт дурдсан Ерөнхийлөгчийн эрх мэдлийн асуудлыг мөн хөндөж байна. Тодруулбал, Улсын дээд шүүхийн саналыг Ерөнхийлөгч хүлээн авч, хир хэмжээнд дагах үүрэгтэй үгүй эсэх зэрэг эргэлзээтэй асуудлууд гарч байна. Улсын хамгийн дээд шатны шүүх байгууллага болох Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг сонгон шалгаруулах, томилох журамд улс төрийн нөлөөллөөс хараат бус байх тухай заалтыг тодорхой тусгах нь зайлшгүй шаардлагатай юм.³³² Улмаар тус санал дүгнэлтийн 126-р зүйлд дурдсаны дагуу, **шүүгчийг томилох ажиллагаан дах Ерөнхийлөгчийн эрх, үүрэг оролцоог зөвхөн процедурын үүргээр хязгаарлаж өгөх нь чухал болно. Эс бөгөөс, [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмж](#)нд тусгасны дагуу, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь ерөнхий шүүгч нарыг томилох тохиолдолд, эрх бүхий зөвлөх коллеги (энэ тохиолдолд Улсын дээд шүүхийн шүүгч нарын коллеги гэх мэт байгууллага) нь саналаа хүргүүлэх, уг саналыг нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нь хүлээн авахаас татгалзсан тохиолдолд, үндэслэл, шалтгаанаа тодорхой тайлбартай ирүүлэх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд зөвлөх коллеги өөр нэр дэвшигчийг санал болгох эрхтэй байхаас гадна олонхийн хүчинтэй саналаар гүйцэтгэх эрх мэдлийн хоригийг хүчингүй болгох боломжтой байх нь зохимжтой болно.**³³³ Иймд Шүүхийн тухай хуулийн 12.3-р зүйл болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15.3-р зүйлд тус тус нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй болно.

6.3. Ерөнхий шүүгч болон Улсын Дээд Шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

168. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6.3-р зүйлд бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, энэхүү ажиллагаатай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид

³³² Өмнө иш татсан 75-р зүүлт, 88-р зүйл (2019 оны АИХЭГ-ын Гүрж улсын Дээд шүүхийн шүүгчдийн томилгооны талаарх санал дүгнэлт) болон харьцуулалт хийх зорилгоор [ЕШЗЗ-ийн Шүүхийн ерөнхий шүүгч нарын үүргийн талаарх санал дүгнэлт № 19-ийн](#) 53-р зүйлийг тус тус үзнэ үү. 2016 оны 11-р сарын 10-ны өдөр.

³³³ Өмнө иш татсан 18-р зүүлт, 16-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно гэж тодорхой тусгасан нь сайшаалтай болно. Энэ нь ерөнхий шүүгч нар бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглосон тухай олон улсын зөвлөмжүүдэд нийцэж байна.³³⁴

169. Шүүхийн тухай хуулийн 12.2-р зүйлд шүүхийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлнэ гэж тодорхой заасан бөгөөд 13-р зүйлд ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг зүйлчилж өгсөн байна. Үүнд: тухайн шүүхийг төлөөлөх, шүүгчдийн зөвлөгөөнтэй холбоотой асуудлуудыг зохион байгуулах, олон нийттэй харилцах асуудлыг зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах болон шүүх хуралдааныг даргалах, шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах зэрэг эрхтэй байна. Ерөнхий шүүгч ажилдаа томилогдсоныхоо дараа ч гэсэн шүүгчийнхээ ажлыг хийж гүйцэтгэж байх нь чухал гэж үзэж байна. Шүүгчийнхээ ажлыг үргэлжлүүлэн хийх нь ерөнхий шүүгчийг бусад шүүгч нартай харилцах харилцаа холбоог хүрээнд бататгах төдийгүй өдөр тутмын практикт үүсэх асуудлыг шуурхай илрүүлж тодорхойлоход нэн чухал ач холбогдолтой юм.³³⁵ Ингэхдээ шүүхийн бие даасан байдлын зарчим, ялангуяа шүүхийн дотоод бие даасан байдлыг хүндэтгэн мөн *primus inter pares* зарчмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь чухал болно.³³⁶ Ерөнхий шүүгчийн үүрэг функц нь бусад шүүгч нарын адилаар шүүн таслах ажиллагаагаар л хязгаарлагдах ёстой³³⁷ бөгөөд шүүхийн үйл ажиллагаанд чухал нөлөөлөхүйц захиргааны шийдвэр гаргах нь зөвхөн ерөнхий шүүгчид олгогдох онцгой эрх мэдэл байх ёсгүй болно.³³⁸
170. Үүнтэй холбогдуулан шинэчилсэн хууль тогтоомжинд ерөнхий шүүгчийн эрх мэдлийг бууруулсан гэж ойлгож байгаа бөгөөд энэ нь сайшаалтай алхам болно.³³⁹ Гэсэн хэдий ч тус хуулийн 12.2-р зүйлийн дагуу ерөнхий шүүгч нь шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох эрхтэй хэвээр байгаа явдал нь шүүхий үйл ажиллагаа болон шүүгчийн бие даасан байдалд тус тус нөлөөлөл үзүүлэх магадлал үүсгэж байна. Үүний сацуу хуулинд ийнхүү онцгой эрхийг хэрэгжүүлэх хэмжүүр нөхцөлийг тодорхой тусгаагүй байна. **Иймд, ЭЗХАХБ-ын зөвлөмжинд тусгасны адилаар ерөнхий шүүгчийн эрх мэдлээс шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүн томилох эрхийг тус тус хасахыг зөвлөж байна.**³⁴⁰

³³⁴ Өмнө иш татсан 11-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү мөн дээр иш татсан 332-р зүүлт 13-р зүйлийг (ЕШЗЗ-ийн Шүүхийн ерөнхий шүүгч нарын үүргийн талаарх санал дүгнэлт № 19)-ийг харна уу.

³³⁵ Өмнө иш татсан 15-р зүйл (ЕШЗЗ-ийн Шүүхийн ерөнхий шүүгч нарын үүргийн талаарх санал дүгнэлт № 19)-ийг харна уу.

³³⁶ Өмнө иш татсан 13-17-р зүйл (ЕШЗЗ-ийн Шүүхийн ерөнхий шүүгч нарын үүргийн талаарх санал дүгнэлт № 19)-ийг харна уу.

³³⁷ Өмнө иш татсан 18-р зүүлт, 11-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

³³⁸ Өмнө иш татсан 12-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд) үзнэ үү.

³³⁹ Өмнө иш татсан 5-р зүүлт, 62-р хуудас (2019 оны ЕЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

³⁴⁰ Өмнө иш татсан 15-16-р хуудас дээр Шинэ зөвлөмж 11 (2019 оны ЕЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

171. Шүүхийн тухай хуулийн 13.1.3-р зүйлд ерөнхий шүүгч нь шүүх хуралдааныг даргалах бүрэн эрхтэй гэж заасан байна. Өөр нарийвчилсан зүйл огт алга. Мөн хуулийн 14.1.3-р зүйлд Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн нь “ хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах” бүрэн эрхтэй гэж мөн заасан байна. Эдгээр заалтууд нь ерөнхий шүүгчид нь тухайн шүүхийн/танхимын бүх шүүх хуралдааныг даргалана гэсэн утгатай юм уу, эсвэл ерөнхий шүүгчийн оролцоо шаардсан тодорхой хэргүүдийн шүүх хуралдааныг даргалах утга илэрхийлж байгаа юм уу гэдэг нь ойлгомжгүй байна. Дээрх хоёр тайлбар ойлголт хоёулаа асуудалтай болно, ийм эрх мэдэл нь маргааныг хянан шийдвэрлэх явцад ерөнхий шүүгч /танхимын дарга нарт онцгой статус өгч, тэдгээр нь шүүх буюу танхимын хуралдааны даргын бүрэн эрх гэж ойлгогдохоор болгоно. Ийм нөхцөл бүрдэх нь зохимжгүй болно. **Эл асуудлыг тодруулж, эргэн харах нь зүйтэй.**
172. Шүүхийн тухай хуулийн 18.2-р зүйлд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь “Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно” мөн тус хуулийн 21.1.4-р зүйлд давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч “*тухайн шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно*” гэж тус тус заасан байна. Бусад шатны шүүхийн ерөнхий шүүгч нарын адилаар Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон давж заалдах шатны ерөнхий шүүгч нар ийнхүү оролцож буй шүүн таслах ажиллагаанд давуу эрх үүрэг эдлэх нь зохимжгүй болно. Шүүхийн бусад гишүүдийн адил шүүн таслах ажиллагааг *primus inter pares* зарчмын хүрээнд явуулах нь чухал болно.³⁴¹ Ийнхүү Улсын дээд шүүхийн болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчид нь бусад шатны ерөнхий шүүгч нараас ялгарч танхим харгазлахгүй шүүн таслах ажиллагаанд оролцох эрхтэй байгаа нь шүүн таслах ажиллагаа явуулах ерөнхий шүүгчдийн эрхийг тэнцвэргүй харагдуулж байна. Мөн эдгээр заалтуудын томьёолол нь ерөнхий шүүгчид өөрийн үзэмжээр аль шүүх хуралдааныг даргалахаа эсвэл оролцохоо сонгох боломжтой үгүй эсэх нь ойлгомжгүй байна. Зарчмын хувьд хэрэг шүүн таслах ажиллагаан дах ерөнхий шүүгч нарын зохисгүй оролцооноос урьдчилан сэргийлэх үүднээс болон ерөнхий шүүгч нарыг өөрийн үзэмжээр шүүн таслах ажиллагааг даргалах эсвэл оролцох буруу практик тогтохоос зайлсхийхийн тулд тэд нарын оролцох хэргүүдийг ерөнхий хэрэг хуваарилах журмын дагуу, объектив, санамсаргүй түүврийн арга байдлаар тогтоож байх нь зохимжтой болно (тус санал дүгнэлтийн 8.1-р дэд хэсгийг үзнэ үү). **Үүнтэй холбогдуулан дээрх давхардмал утгатай тайлбар/ойлголт гаргахгүйн тулд Шүүхийн тухай хуулийг тодорхой болгож, тус хуулийн 18.2-р зүйл болон 21.1.4-р зүйлийг тус тус эргэн харах нь зүйтэй болно.**
173. Шүүхийн тухай хуулийн 18.1.2-р болон 21.1.3-р зүйлд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь хэргийн харьяаллын талаар доод шатны шүүхийн болон (Улсын дээд шүүхийн тухайд) танхим хооронд гарсан маргааныг шийдвэрлэх эрхтэй гэж тус тус заасан байна. Аливаа маргаан нь хуулийг тайлбарлахад үгүй гэхэд хэргийн харьяалалын тухай маргааны нөхцөлийг

³⁴¹ Өмнө иш татсан 18-р зүүлт, 11-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-ийг үзнэ үү.

тайлбарлахад тус тус хүргэдэг учир ийнхүү онцгой эрх нь захиргааны төдий эрх мэдлээс дээгүүр бөгөөд шүүхийн үндсэн үйл ажиллагаанд илүү хамаардаг болно. Ийнхүү шүүхийн ажиллагааны чухал функцийг шүүгчдийн зөвлөл эсвэл хэрэг хуваарилах санамсаргүй түүврийн аргаар шүүгчид хуваарилж өгөхгүйгээр зөвхөн ерөнхий шүүгчийн бүрэн эрхэд тусгасан явдал нь ерөнхий шүүгчдийг бусад шүүгчидтэй харьцуулахад илт давуу, тусгай байр сууринд тавьж байна. Дээр дурдсан [2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжинд](#) шүүхийн ерөнхий шүүгчид бусад шүүгчдийн адил шүүчийн үйл ажиллагаа явуулна гэж заасан байна.³⁴² **Иймд дээрх тусгай эрхийг эргэж харах нь зүйтэй болно.**

174. Эцэст нь, Шүүхийн тухай хуулийн 14-р зүйлд Улсын дээд шүүхийн танхимын дарга нь танхимын ажлыг “удирдан зохицуулна” гэж тусгасан байна. Ийнхүү эрх мэдэл нь тухайн танхимын шүүгчдэд хөндлөгийн нөлөөлөл үзүүлэх, цаашилбал шүүгчийн бие даасан байдалд аюул учруулах боломж олгохуйц нөхцөл бүрдүүлж байна. **Иймд ЭЗХАХБ-гаас өгсөн зөвлөмжинд мөн тусгасан, Шүүхийн тухай хуулийн 14-р зүйлд тусгасан энэхүү эрхийг нь хүчингүй болгохыг зөвлөж байна.**³⁴³ Харин шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаарх санал хураалтад шүүгчдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэх эрхэд дээрх хамаарахгүй болно.

7. Шүүхийн захиргааны ажилтнууд

175. Шүүхийн захиргааны тухай хуулийн 25.1-р зүйлд шүүхийн захиргааны бүрэлдэхүүн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын ажилтнуудаас бүрдэнэ гэж заасан байна. Шүүгчийн туслах нь шүүгчийг шүүх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар шүүгчийн бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог тул мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж, шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэж сурталчлах үүрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.³⁴⁴ Тэдний үүрэг, хууль ёсны эрх, эрх зүйн байдлын зохицуулалт нь шүүхийн захиргааны нэгжийн нэг хэсэг байхын зэрэгцээ шүүгчид чиг үүргээ гүйцэтгэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх зэрэг тэдгээрийн хоёрдмол үүрэгт гаднаас болон шүүхийн байгууллага дотроос урвуулан ашиглах байдлаас ангид байх байдлыг нь хангасан байх ёстойгоос гадна, тодорхой хэрэг дээр ажиллаж байгаа шүүгчийн болон шүүхийн захиргаанаас өгч буй үүрэг даалгавар зөрчилдөх тохиолдолд шүүгчийн шийдвэрийг хүндэтгэх ёстой гэсэн үг юм.³⁴⁵ **Тиймээс шүүгчийн туслах нь Тамгын газрын даргад захирагддаггүй байхыг хуулинд тодотгож өгөх нь чухал байж болох юм.**

³⁴² Дээр дурдсан 11-р зүйлийг харна уу.

³⁴³ Өмнө иш татсан 15-16-р хуудас дээр Шинэ зөвлөмж 11 (2019 оны ЕЭЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

³⁴⁴ Харьцуулалт хийх зорилгоор 2019 оны [ЕШЗЗ-ийн Шүүгчийн туслахын үүргийн талаарх санал дүгнэлт № 22-рм](#) 19-р болон 57-р зүйлийг тус тус харна уу.

³⁴⁵ Өмнө иш татсан 57-р зүйл (2019 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт № 22)-ийг үзнэ үү.

176. Шүүхийн тухай хуулийн 27.4-р зүйлд зааснаар шүүгч төдийгүй “*шүүхээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй шүүхийн ажилтныг*” аливаа улс төрийн нам эсвэл “*улс төрийн хөдөлгөөний*” гишүүн байхыг хориглодог байна. 101-р догол мөрөнд дурдсанчлан “*улс төрийн хөдөлгөөн*” гэсэн нэр томъёо нь тодорхойгүй бөгөөд үүнээс зайлсхийх нь зүйтэй болно. Мөн “*шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй*” гэх заалт нь шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар болон шүүхийн захиргааны бусад ажилтнууд зэрэг шүүхийн ажилтнуудын маш өргөн хүрээг хамрах талтай тул уг томъёолол яг ямар утга агуулж буй нь тодорхойгүй байна. Шүүгч эсвэл шүүгчдийн бүрэлдэхүүний үйл ажиллагаанд шууд туслалцаа үзүүлдэг ажилтнуудад улс төрийн намын харьяалалтай байхыг хориглох нь хууль ёсны үндэслэлтэй байж болох юм.³⁴⁶ Ийнхүү тохиолдолд шүүхэд хандаж буй талууд тэдний хэргийг хянан хэлэлцэж буй шүүгчээс төдийгүй тухайн хэрэг дээр ажиллаж байгаа шүүгчийг туслахын зүгээс шударга, хараат бус байдлыг баримтална гэсэн хүлээлттэй байх юм,³⁴⁷ улмаар улс төрийн намын гишүүнчлэлийн хувьд шүүгчдэд тавигдах ижил хязгаарлалт нь мөн шүүгчийн туслахад хамаарах явдал нь үндэслэлтэй байж болох юм. Үүнээс гадна шүүгчдэд тавигддаг шударга ёсны өндөр хэм хэмжээг шүүх үйл ажиллагаанд оролцдоггүй бусад шүүхийн ажилтнуудад мөрдүүлэх шаардлагагүй гэж үзнэ. Чингэхдээ энэ нь тэдгээрийн төвийг сахих үндсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж болзошгүй тохиолдолд хамаарахгүй. Тиймдээ ч АИХЭГ болон Венецийн Комиссоос “*холбоо байгуулах, тэдгээрт нэгдэх нь төрийн албан хаагчийн үндсэн үүрэгтэй зөрчилдөх болон/эсвэл холбогдох төрийн албан тушаалтнуудын улс төрийн төвийг сахих байдалд аюул занал учруулах*” тохиолдолд зарим төрийн албан тушаалтнуудын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах боломжтойг онцгойлон хүлээн зөвшөөрсөн байдаг юм.³⁴⁸ **Иймээс дээр дурдсан хязгаарлалтыг илүү нарийвчлан тодорхойлох нь зүйтэй болно.**
177. Бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөр хэд хэдэн хязгаарлалтад шүүхийн ажилтнуудыг хамааруулах нь зүйтэй юм. Энэ нь гүйцэтгэж буй албан үүрэг эсвэл үндсэн чиг үүргийн хүрээнд аливаа нэг үйлдэл хийсний төлөө эсвэл хийх гэж буй үйлдлийн төлөө эсвэл хийгээгүйн төлөө ямар нэгэн бэлэг, өв хөрөнгө, зээл, хариу тус хүсэх, хүлээн авах зэргийг хориглохыг тодорхой тусгах асуудал юм.³⁴⁹ Үүнтэй адилаар **шүүхийн ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ холбогдох талуудад адил тэгш хандах зарчмыг хүндэтгэх, ялангуяа алгачлах, ялгаварлан гадуурхах хандлага гаргах мөн аливаа хэлбэрийн дарамт шахалт, үүний дотор бэлгийн дарамт үзүүлэхээс зайлсхийх зэрэг үүргийг хуулинд тусгайлан тусгах нь зүйтэй байж болох юм.**³⁵⁰

³⁴⁶ Өмнө иш татсан 4-р зүйл (2019 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт № 22)-ийг үзнэ үү.

³⁴⁷ Өмнө иш татсан 55-р зүйл (2019 оны ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт № 22)-ийг үзнэ үү.

³⁴⁸ [АИХЭГ-Венецийн Комиссын Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний тухай нэгтгэсэн журмын](#) 144-р зүйл (2014).

³⁴⁹ Өмнө иш татсан 22-р зүүлт, Зарчим 4.15 (2007 оны НҮБ-ын МБГХТА-ны Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчимуудад хийсэн тайлбар) харна уу.

³⁵⁰ Өмнө иш татсан 183-185-р зүйлийг үзнэ үү.

8. Нэмэлт тайлбар

8.1. Хэрэг хуваарилах журам

178. Шүүхийн тухай хуулийн 6.3-р зүйлд шүүхийн Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчид тодорхой хэргийг нэр заан хуваарилахыг хориглоно гэж тодорхой заасан нь сайшаалтай болно. Гэсэн хэдий ч хэрэг хуваарилах журамтай холбоотой асуудал нь тодорхой бус байна. Практик дээр хэрэг хуваарилалтыг хоёрдагч хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд хэргүүдийг ямар нэгэн хөндлөнгийн оролцооноос ангид, тусгай системээр санамсаргүй түүвэр байдлаар хуваарилдаг гэж ойлгож байгаа.³⁵¹ Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалах болон авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс ийнхүү хэрэг хуваарилалтыг хөндлөнгийн бүхий л оролцооноос ангид байх байдлыг нь хангах нь чухал болно. Иймд санамсаргүй түүврийн аргаар эс бөгөөс тогтсон, тодорхой, ил тод, объектив шалгуураар хуваарилалтыг зохион байгуулах нь зохимжтой болно.³⁵² Зарчмын хувьд, шүүгчид хэрэг хуваарилах журам нь, онцгой хэргүүдэд ч хамаарна, дээр дурдсан шалгуурыг үндэслэн хуулинд эсвэл хууль тогтоомжийн дагуу тусгай зохицуулалтаар тус тус тогтоогдсон байх ёстой болно.³⁵³ Хэрэв үнэхээр ерөнхий шүүгчид нь шүүгчид нэр заан тодорхой хэрэг хуваарилах эрхтэй байх юм бол эл эрхээ нэг шүүгчид хэт олон хэрэг хуваарилах аргаар шүүгчийг дарамтлах хэрэгсэл болгох, эсвэл тодорхой хэргүүдийг нэг л шүүгчид хуваарилах замаар хэргийн шүүн таслах ажиллагааны үр дүнд бодит нөлөөлөл үзүүлэх зэргээр эрх мэдлээ урвуулан ашиглахад хүргэх сөрөг дагвар дагуулах боломжтой юм.³⁵⁴ Зохих дүрэм журам нь гадны хөндлөнгийн оролцоо нөлөөлөл орохоос сэргийлнэ.³⁵⁵
179. Дээрх асуудалтай холбогдуулан хэд хэдэн зүйлийг анхааралдаа авах нь зохимжтой болно. Хэргийг зохих хугацаанд хянан шийдвэрлэх ач холбогдолыг анхаарч, ингэхдээ бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж хуваарилалтыг хийх жишээ нь хэргийн хойшлуушгүй нөхцөл байдал, эсвэл улс төр, нийгмийн ач холбогдол, тухайн хэргийн ээдрээтэй нөхцөл (тухайн асуудлаар нарийн мэргэшсэн шүүгч нарын оролцоо шаарлагатай болох), шүүгч нарын мэргэшсэн байдал, шүүгч нарын ажлын ачаалал – шүүгч нарт шударга зарчмаар тэнцүү ажил хуваарилах, мөн шударга ёсны сайн засаглалын зарчмыг баримтлах зэрэг болно.³⁵⁶ Бүх тохиолдолд тохирсон бүрэн цогц

³⁵¹ Өмнө иш татсан 5-р зүүлт, 57-р хуудас (2019 оны ЕЭЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

³⁵² Өмнө иш татсан 18-р зүүлт, 12-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-ийг үзнэ үү. Мөн өмнө иш татсан 19-р зүүлт, 3-4-р зүйл (Шүүгчийн нийтлэг дүрэм)-ийг харна уу.

³⁵³ Өмнө иш татсан 26-р зүүлт, 80-81-р хуудас (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн хараат бус байдлын талаарх тайлан)-ыг үзнэ үү.

³⁵⁴ Өмнө иш татсан 79-р зүйл (2010 оны Венецийн Комиссын Шүүхийн системийн хараат бус байдлын талаарх тайлан)-ийг үзнэ үү.

³⁵⁵ Өмнө иш татсан 21-р зүүлт, 60-61-р хуудас (2012 АИХЭГ-ын шударга шүүгдэх эрхийн тухай олон улсын хуулийн цуглууллага).

³⁵⁶ Жишээ болгож, үндсэн хуулийн шүүхийн тухайд, ЕХЭШ-ийн, [Süßmann v. Germany](#) (Application no. 20024/92, judgment of 16 September 1996) хэргийн 56-р зүйлийг болон Венецийн Комиссын Польш улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2015 оны 6-р сарын 25-ны өдрийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн санал дүгнэлт [CDL-AD\(2016\)001](#)-ийн 54-66-р зүйл, 2016 оны 3-р сарын 11-ний өдөр.

абстракт системийг байгуулах нь боломжгүй байдаг, иймд ерөнхий шүүгчийн хэрэг хуваарилах шийдвэр нь тогтсон объектив шалгуурыг баримтлан гарсан байх ёстой бөгөөд онцгой тохиолдолын тухайд үндэслэлтэй байх.³⁵⁷ Нэгэнт ийнхүү хэрэг хуваарилах журам батлагдсан тохиолдолд үүнд хөдлөнгөөс оролцож болохгүй болно.³⁵⁸

180. Шүүхийн тухай хуулийн 25.2.8-р зүйлд тухайн шүүхийн Шүүгчдийн Зөвлөгөөн нь хэрэг хуваарилах журмыг батлана гэж заасан байна. Энэхүү заалтаар тухайн шүүх болгон нь хэрэг хуваарилах өөрийн журамтай гэсэн утга санаа гарч байна, энэ нь маш их асуудалтай, ялангуяа шүүгч нарын ажлын ачаалал их байдаг бөгөөд байнга нэмэгдэж байдаг, мөн авлига газар авах эрсдэлт нөхцөлийг үүсгэх магадлалтай болно, ЭЗХАХБ-ын зүгээс мөн үүнийг цохон тэмдэглэсэн байна.³⁵⁹ Үүний сацуу энэ нь нийт улс даяар хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаа ялгаатай явагдах нөхцөл үүсгэхээс гадна, будлиантуулахад хялбар хэрэг хуваарилах систем нь хээл хахууль, авлига үүсгэх орон зайг буй болгох юм. Үүнтэй холбогдуулан ЭЗХАХБ-гаас хуулиар хэргийг бүрэн автоматаар (хүний оролцоогүйгээр) хуваариладаг болохыг тусгайлан зөвлөсөн болно.³⁶⁰ АИХЭГ нь дээрх зөвлөмжийг дэмжиж байгаа бөгөөд хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид хууль тогтоомжинд наандаж бүх шүүхүүд мөрдөх тодорхой, объектив шалгуурыг тогтоож өгөхийг зөвлөхийн сацуу Шүүхийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

8.2. Шүүхийн шийдвэрийн үндэслэл

181. Шүүхийн тухай хуулийн 31.1-р зүйлд шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана гэж заасан байна. Гэвч ийнхүү шийдвэрээ гаргахдаа зохих ёсны үндэслэлд тулгуурлан гаргах үүрэгтэй талаар хуулинд огт дурдаагүй байна. Аливаа шүүхийн шийдвэр нь хангалттай үндэслэл дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд гол дүгнэлт, нотлох баримт, хууль зүйн үндэслэл зэргийг тусгасан байх ёстой.³⁶¹ Энэ нь хуулийг нэг мөр ойлгож тайлбарлах, хэрэглэхэд чухал бөгөөд, шүүх ажиллагаанд оролцож буй талуудад тухайн шүүхийн шийдвэрийг давж заалдах эсэхээ тодорхойлоход нь боломж олгож, шүүх байгууллага нь талуудыг сонссон гэдгээ харуулах, үүний дотор шударга ёсны ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгодог болно.³⁶² Иймд Шүүхийн тухай хуулийн 13.1-р зүйлд шүүхийн шийдвэр нь хангалттай үндэслэл

³⁵⁷ Жишээ болгож, Венецийн Комиссын Унгар улсын Шүүгчийн эрх зүйн байдал болон хөдөлмөрийн хөлсний тухай 2001 оны CLXII хууль болон Шүүхийн захиргаа болон шүүх байгуулах тухай 2001 оны CLXI хуулинд хийсэн санал дүгнэлт CDL-AD (2012)001-рт 91-р зүйлийг харна уу. 2012 оны 3-р сарын 19-ний өдөр.

³⁵⁸ Өмнө иш татсан 18-р зүйлт, 12-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-ийг үзнэ үү.

³⁵⁹ Өмнө иш татсан 5-р зүйлт, 58-р хуудас (2019 оны ЕЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

³⁶⁰ Өмнө иш татсан 15-16-р хуудас, Шинэ зөвлөмж 11 (2019 оны ЕЗХАХБ-ын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний тайлан)-ыг үзнэ үү.

³⁶¹ Өмнө иш татсан 13-р зүйлт, 29-р зүйл (2007 оны НҮБ-ын Хүний эрхий зөвлөлийн (CCPR) Ерөнхий Тайлбар 32) болон өмнө иш татсан 21-р зүйлт, 209—211-р зүйл (2012 оны АИХЭГ-ын шударга шүүгдэх эрхийн тухай олон улсын хуулийн цуглууллага) тус тус үзнэ үү. Түүнчлэн харьцуулалт хийх зорилгоор [ЕШЗЗ-ийн Шүүхийн шийдвэрийн үндэслэлийн талаарх Санал дүгнэлт № 11](#) (2008) 31-50-р зүйлийг харна уу.

³⁶² Өмнө иш татсан 210-211 хуудас (2012 оны АИХЭГ-ын шударга шүүгдэх эрхийн тухай олон улсын хуулийн цуглууллага) болон ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт № 11 (2008) 31-р зүйлийг тус тус үзнэ үү

дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд гол дүгнэлт, нотлох баримт, хууль зүйн үндэслэл зэргийг тусгасан байх заалтыг тодорхой тусгахыг зөвлөж байна.

8.3. Маргаанд оролцогч талуудын хувийн нууцыг хангах

182. Шүүхүүд нь шийдвэрээ өөрийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтэлдэг нь (Шүүхийн тухай хуулийн 31.6-р зүйл) сайшаалтай явдал³⁶³ бөгөөд энэ нь шүүхийн тогтолцооны ил тод байдлыг нэмэгдүүлэх болон дээр дурдсан зорилтоо хэрэгжүүлэхэд чухал алхам юм (181-р догол мөрийг харна уу). Үүний сацуу зарим шүүхийн шийдвэр нь ийнхүү цахим хэлбэрээр олон нийтэд ил байх явдал нь хувь хүний нууц болон зарим аж ахуйн нэгжүүдийн ашиг сонхиролд эрсдэл учруулах аюултай тул хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах зохих арга хэмжээг авах,³⁶⁴ жишээ нь хэвлэгдэх шүүхийн шийдвэрүүдэд хувь хүн/аж ахуйн нэгжийн нэрийг нууцлах гэх мэт зохицуулалт хийх нь зохистой болно. **Хууль эрх зүйн баримт бичиг боловсруулагчид эдгээр болгоомжлол, сэрэмжлүүлгийн чанартай зүйл заалтыг Шүүхийн тухай хуулийн 31-р зүйлд оруулахыг судлаж үзэх нь зүйтэй болов уу.**

9. Монгол Улсад шүүх эрх мэдлийн хүрэн дэх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн хуульчилахад анхаарах асуудлууд болон зөвлөмжүүд

183. ЕАБХАБ-ын гишүүн орнууд хууль тогтоомжийг “олон нийтийн хэлэлцүүлгийн процедурын төгсгөлд батлан гаргасан хууль тогтоомжийг албан ёсоор хэвлэн нийтлэснээр тэдгээр хуулийг хэрэглэх эрхийг нь бүрдүүлэх” үүрэг хүлээсэн болно (1990 оны Копенгагены баримт бичиг, 5.8-р зүйл).³⁶⁵ Нэмж дурдахад, ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үндсэн үүрэгт “хууль эрх зүйн баримт бичиг нь иргэдийн шууд оролцоотойгоор эсвэл тэдгээрийн сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан ард түмний хүсэл зоригийг илтгэсэн нээлттэй үйл явцын үр дүнд боловсруулагдаж, батлагдана” гэж заасан байдаг болно (1991 оны Москвагийн баримт бичиг, 18.1-р зүйл).³⁶⁶
184. Олон нийтийн хэлэлцүүлэг нь нээлттэй болон ардчилсан засаглалын чухал арга хэрэгсэл бөгөөд төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлыг бий болгоход чиглэгдэж, хууль батлагдахаас өмнө болзошгүй маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд тусалдаг юм.³⁶⁷ Үр дүнтэй байхын тулд хууль тогтоомж болон бодлогын баримт бичгийн төслийн талаарх хэлэлцүүлгүүд нь иргэд, сонирхолын бүлгүүдийн оролцоог хангасан бөгөөд холбогдох сонирхолын бүлэг, талуудад хууль тогтоомжийн төслийн талаар зөвлөмж боловсруулж, өргөн мэдүүлэхэд хангалттай

³⁶³ Өмнө иш татсан 18-р зүүлт, 32-р зүйл (2010 оны АИХЭГ-ын Киевын зөвлөмжүүд)-ийг үзнэ үү.

³⁶⁴ Жишээ болгож, [ЕПЗЗ-ийн Шүүх засаглал ба Мэдээллийн технологийн талаарх Санал дүгнэлт № 14](#) (2011)-ийн 17-р зүйлийг харна уу.

³⁶⁵ <http://www.osce.org/fr/odihr/elections/14304><http://www.osce.org/fr/odihr/elections/14304> цахим хуудаст нэвтэрч үзнэ үү.

³⁶⁶ <http://www.osce.org/fr/odihr/elections/14310><http://www.osce.org/fr/odihr/elections/14310> цахим хуудаст нэвтэрч үзнэ үү.

³⁶⁷ Өмнө иш татсан.

хугацаа өгч;³⁶⁸ үүний сацуу төр нь цаг тухайд нь санал хариу өгөх эргэх холбоо бүхий тогтолцоог бүрдүүлснээр төрийн байгууллагууд нь олон нийтийн санал сэтгэгдэл, оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нь хариу өгч хэвших юм.³⁶⁹ Үр дүнтэй оролцоог баталгаажуулахын тулд зөвлөлдөх механизм нь олон нийтийн оролцоог эхний шатанд болон *нийт хэлэлцүүлгийн явцын үед*³⁷⁰ ч хангах ёстой, өөрөөр хэлбэл төслийг холбогдох яам бэлтгэх үе шатанд ч мөн парламентаар хэлэлцэх шатанд ч (жишээ нь, нийтийн сонсголыг зохион байгуулах замаар) хангах ёстой. Хэлэлцүүлгийг нээлттэй, хүртээмжтэй зохион байгуулах замаар энэхүү хэлэлцүүлэг нь бүх сонирхогч талуудын янз бүрийн хүчин зүйлсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, батлагдсан хууль тогтоомжид итгэх итгэлийг бэхжүүлнэ. Эцэст нь хэлэхэд, энэ нь хууль батлагдсанаас хойш батлагдсан хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлж, төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг болно.

185. Шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх эрх зүйн шинэчлэлийн үйл явцад оролцох тухайд олон улсын зөвлөмжинд *үндэсний шүүхийн бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийн талаарх хэлэлцүүлэгт шүүгчдийн оролцоо нэн чухал болохыг онцолдог болно.*³⁷¹
186. Өнгөрсөн жилийн тухайд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын ээлжит бус хуралдаанаар сонсгол, олон нийтийн хэлэлцүүлэг хийлгүйгээр яаруу баталсан гэж ойлгож байна.³⁷² Ерөнхийдөө эрх баригчид ТББ-уудыг татан оролцуулах талаар идэвхтэй арга хэмжээ авдаггүй, нөгөөтэйгүүр тэгээрийн оролцох боломж нь тогтмол бус, байнгын бус буюу зохион байгуулалтгүй байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд идэвхгүй байсан хувь хүмүүсээс ихээхэн хамаардаг болохыг тэмдэглэх хэрэгтэй болов уу.³⁷³ Ерөнхийдөө иргэний нийгмийн байгууллагуудын орон зай аажмаар хумигдаж буйг тэмдэглэхийн сацуу, эрх

³⁶⁸ Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын зөвлөмжүүдэд болон ЕАБХАБ-ын бүс нутаг дахь мөрддөг сайн туршлагад, олон нийтийн хэлэлцүүлэг нь багадаа 15 хоног цаашилбал 2-оос 3 сарын турш үргэлжилдэг бөгөөд хэлэлцэж буй асуудлын цар хүрээ, ээдрээ, хуулийн төсөл болон холбогдох нэмэлт мэдээ мэдээллийн хэмжээ зэргээс шалтгаалан хэлэлцүүлгийн хугацааг уртасгаж болно хэмжээ. Жишээ болгож, [АИХЭГ-ын Украин улсын Олон нийтийн хэлэлцүүлгийн тухай хуулийн төсөлд хийсэн санал дүгнэлтийн](#) 40-41-р зүйлийг харна уу (2016 оны 9-р сарын 1-ний өдөр).

³⁶⁹ Жишээ болгож, 2015 оны 4-р сарын 15-16-ны өдрүүдэд Вена хотноо зохиогдсон 2015 оны АИХЭГ-ын Тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудлаарх Хүний хэмжигдэхүүний уулзалтын хүрээнд зохион байгуулсан Иргэний нийгмийн форумын төлөөлөгчдийг гаргасан [Шийдвэр гаргах үйл явц дах иргэний нийгмийн төлөөллийн оролцоог нэмэгдүүлэх](#) тухай зөвлөмжийг харна уу.

³⁷⁰ [АИХЭГ-ын Гүрж улсын хууль тогтоох үйл явцын талаар хийсэн үнэлгээний](#) (2015 оны 1-р сарын 30) 33-34-р зүйлийг үзнэ үү. Мөн 2014 оны АИХЭГ-ын Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай зөвлөмжийн 2-р бүлгийн Олон нийтийн харилцаанд оролцох эрхийн тухай Дэд хэсэг G харна уу, <<http://www.osce.org/odihr/119633>>.

³⁷¹ Өмнө иш татсан 34-р зүүлт, 31-р зүйл (ЕШЗЗ-ийн Санал дүгнэлт №18 (2015)); 19-р зүүлт 1.8-р зүйл (1998 оны Европын Дүрэм)-ийг тус тус харна уу. Мөн өмнө иш татсан 19-р зүүлт, 9-р зүйл (2010 оны ЕШЗЗ-ийн Шүүгчийн Магна Харт)-ид “шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд /үүнд: шүүх байгуулах, журам дүрэм, бусад хууль тогтоомж/ нөлөөлөл үзүүлэх эрх зүйн шинэчлэлийн үйл явцад оролцох нь нэн чухал болохыг” онцолсон байна; Европын шүүхийн зөвлөлүүдийн [сүлжээний 2011 оны Өнөөгийн эдийн засгийн нөхцөлд байдлын үе дэх Шүүхийн засаглалд тулгамдаж асуудлууд ба олон амжилтын тухай Вильнюсын тунхаглалын](#) 9-р зөвлөмжинд мөн “шүүх засаглал болон шүүгчдийг шаардлагатай шинэчлэлийн үйл явц дах оролцоог хангах” тухай мөн онцолсон байна.

³⁷² [НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн Монгол улсад ажилласан талаарх эцсийн тайлан](#) (2019 оны 4-р сарын 30-наас 5-р сарын 13).

³⁷³ Өмнө иш татсан 5-р зүүлтийг 28-р хуудаснаас харна уу (2019 оны ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг үнэлгээний тайлан)

баригчдад иргэний нийгмийн төлөөлөлтэй зохион байгуулалттай, тогтмол хамтын ажиллагаа тогтоохыг ЭЗХАХБ-аас онцгойлон зөвлөсөн байна.³⁷⁴

187. Цаашид, шүүх эрх мэдлийн талаарх хууль эрх зүйн орчинд хийх нэмэлт, өөрчлөлтүүдийг боловсруулах явцад ялангуяа шүүхийн эрх мэдлийн байгууллагууд, шүүгчдийн холбоо эсвэл түүнтэй адилтгах байгууллагууд, түүнчлэн шүүгчид, эрдэмтэн судлаачид, хуульчдийн холбоо, олон нийтийн болон иргэний нийгмийн төлөөлөл оролцуулж, хуулийн хүрээнд, нээлттэй, хүртээмжтэй зөвлөгөөн, хэлэлцүүлэг явуулах нь зүйтэй болно. Нэмж дурдахад, шүүхийн бие даасан байдал болон хууль дээдлэх тогтолцоонд ирээдүйд явагдах шинэчлэлийн үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх нь чухал болно. Иймд эдгээр шинэчлэлийн үзүүлж болзошгүй үр дүнг урьдчилж гүнзгий судалж, үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нотолгоонд суурилсан аргуудыг ашиглан хийж гүйцэтгэж, хамгийн зохистой бөгөөд үр дүнтэй зохицуулалтын хувилбарыг олох нь чухал болно.³⁷⁵
188. Хуулинд орсон нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, батлахад хангалттай цаг хугацаа зарцуулах нь чухал юм. Энэ үүднээс Засгийн газар, парламент аль аль нь нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, үнэлэх, үүний дотор салбарын мэргэжилтнүүдийн болон холбогдох хорооны ажлын албанаас мэргэжлийн саналыг авч судлах, шүүх эрх мэдлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад шинжээчдийн санаа бодлыг тус тус судалж үзэх хангалттай хугацаатай байх ёстой болно. Зарчмын хувьд хуулийн төслийг боловсруулж эхлэхээс өмнө тодорхой хугацаа тогтоож, хууль боловсруулах бүх үе шатанд, эдгээр хууль тогтоомжийн төсөл болон хуулийн бодлого нь олон улсын хүний эрхийн стандартад, үүний дотор жендэрийн эрх тэгш байдал болон олон янз байдлын төлөөллийн тэнцвэртэй байдалд үзүүлэх нөлөөлөлд үнэлгээ хийж байх нь зүйтэй болно.³⁷⁶ Үүнээс гадна, гарч болзошгүй томоохон өөрчлөлтийг харгалзан үзэж, *хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгайлан тогтоож өгөх* нь зүйтэй бөгөөд ингэснээр санал болгож буй шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хангалттай хугацааг тогтоож өгөх юм.
189. Дээр дурдсантай холбогдуулан, цаашид хууль тогтоомжинд оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах болон батлах үйл явцыг ардчилсан хууль тогтоох зарчимд нийцүүлж байх нь зохимжтой гэдгийг тэмдэглэж байна. Шүүх эрх мэдлийн салбар дах аливаа шинэчлэлийн үйл явцыг, **дээр дурдсан зарчмуудын дагуу ил тод, өргөн цар хүрээг хамарсан, олон нийтийн оролцоог хангасан, үүнд шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөл, шүүгч болон хуульчдийн холбоо, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг зөвлөгөөний үр дүнг үндэслэн хийх нь зүйтэй бөгөөд ингэхдээ олон улсын хүний эрхийн холбогдох стандартад нийцэж буй эсэхэд нь бүрэн үнэлгээ хийх нь зохистой болно. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах үе шат болон удаах**

³⁷⁴ Өмнө иш татсан 28-р хуудсыг харна уу (2019 оны ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг үнэлгээний тайлан)

³⁷⁵ [АИХЭГ-ын Молдав улсын хууль тогтоох үйл явцад 2010 онд хийсэн санал дүгнэлтийн тайлангийн](#) 14.5р догол мөрийн харна уу.

³⁷⁶ Өмнө иш татсан 370-р зүүлтийг 6-7-р хуудас дээр харна уу (2015 оны АИХЭГ-ын Гүрж улсын хууль тогтоох үйл явцад хийсэн санал дүгнэлтийн тайлан)

хууль тогтоох үйл явцын шатанд хангалттай хугацаа байх ёстой болно. АИХЭГ нь шүүх эрх мэдлийн болон бусад салбарын хүрээнд эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн хуульчилах аливаа санаачилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт тусламж үзүүлэхэд эрх бүхий байгууллагын мэдэлд хэвээр байх болно.